A photograph of several students in a classroom setting, focused on their work. In the foreground, a young woman with dark hair tied back is looking down at an open book or notebook, holding a pencil. Behind her, other students are also working, some looking at their books. The scene is brightly lit, suggesting a well-lit classroom environment.

**Илүү сайн ажлын  
төлөө сурч  
боловсрох нь**

---

**БИЕ ДААСАН БАЙДАЛ**

# ТАНИЛЦУУЛГА

## ЭНЭ БҮЛЭГ НАМАЙГ СУРГУУЛЬД ОРОХОД ТУСЛАХ УУ?

Боловсролтой болох нь амар хялбар зүйл биш боловч бие даах чадвар хөгжүүлэх энэхүү бүлэг нь танд илүү сайн ажлын төлөө сурч боловсроход тань туслах хамгийн сайн арга замыг зааж өгнө. Та бүлгийн цугларалтаар тодорхой үйлдлүүд хийхээр амлаж, бүлгийнхэн тантай санал бодлоо хуваалцан, дэмжлэг тусалцаа үзүүлнэ. Түүнчлэн энэ бүлгийн зорилго бол зөвхөн сурч боловсроход бэлтгэж, амжилтад хүрэхэд тань туслахаас гадна Их Эзэнд илүү дуулгавартай байж, итгэлээр үйлдэн, Түүний бидэнд амласан, бие даах чадвараа хөгжүүлснээр ирэх сүнслэг ба материаллаг адислалуудыг хүлээн авахад оршино.

## БИЕ ДААХ ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ БҮЛЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Бие даах чадвар хөгжүүлэх бүлэг нь Сүмийн ихэнх анги, хичээл, сургалтаас өөр юм. Бүлэгт багш, удирдагч, дадлагажуулагч багш гэж байхгүй. Бүлгийн гишүүд хамтдаа суралцаж, нэг нэгнээ урамшуулан дэмждэг. Бид нэг нэгнийхээ өмнө өгсөн амлалтаа хэр биелүүлсэнд хариуцлага тооцож, асуудал гарвал хамтдаа авч хэлэлцэнэ.

## БҮЛГИЙН ГИШҮҮД ЮУ ХИЙДЭГ ВЭ?

Цугларалтад бүлгийн гишүүд үйлдэл хийх амлалт өгнө. Бид зөвхөн суралцаад зогсохгүй, биднийг бие даахад туслах зүйлсийг хийж гүйцэтгэх болно. Бид амлалт өгч, нэг нэгэндээ уг амлалтаа биелүүлэхэд нь тусалж, хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнана. Бүлгийн үйл ажиллагаа зөвлөл маягаар явагддаг учраас цугларалтдаа тогтмол, хоцролгүй оролцож байх нь чухал юм. Энэ дасгалын ном болон *"Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил," "Миний бие даах чадвартай болох арга зам"* товхимлуудыг авч ирсэн байх ёстой. Бүлгийн цугларалт бүр ойролцоогоор хоёр цаг үргэлжилнэ. Өгсөн амлалтынхаа дагуу үйлдэхэд өдөрт нэгээс хоёр цаг шаардагдана.

## ЗОХИЦУУЛАГЧ ЮУ ХИЙДЭГ ВЭ?

Зохицуулагч нь боловсрол олгоход, эсвэл зааж сургахад мэргэшсэн хүн биш юм. Тэд бүлгийг удирддаггүй буюу бүлэгт заадаггүй. Тэд зөвхөн материалыг яг бичигдсэний дагуу дагаж мөрдөхөд бүлгийнхэнд тусална. Ихэвчлэн бие даах чадварыг хөгжүүлэх мэргэжилтэн бүлгийн цугларалтыг зохицуулдаг ч, хэдэн долоо хоног өнгөрсний дараа, шаардлага гарвал, бүлгийн гишүүдээс хэн нэгнийг зохицуулагчаар томилж болно. Нэмэлт мэдээллийг *Удирдагчдын удирдамж* болон [srs.lds.org](http://srs.lds.org) вэбсайт дээр байршуулсан дагалдах видео бичлэгүүдээс үзнэ үү.

## ТӨГСӨЛТИЙН ГЭРЧИЛГЭЭ

Цугларалтдаа ирж, амлалт үүргээ биелүүлсэн бүлгийн гишүүд ХҮТ Бизнесийн Коллежоос бие даах чадварыг хөгжүүлэх ангийг дүүргэж, төгссөн гэрчилгээ авах шаардлагыг хангана. Тавигдах шаардлагыг *"Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил"* товхимлын 29-р хуудаснаас үзнэ үү.



*"Хэрэв бид Их Эзэний арга замаар, нэг нэгэнтэйгээ зөвлөлдвөл —жинхэнээсээ зөвлөлдвөл—гэр бүл, тойрог эсвэл гадасны ямар ч асуудлыг шийдвэрлэх боломжтой.*

**М.РАССЭЛЛ БАЛЛАРД,**  
**Counseling with**  
**Our Councils, засаж**  
**сайжруулсан хэвлэл**  
**(2012), 4**

# АГУУЛГА

1. Ямар төрлийн ажил бие даахад маань туслах вэ?..... 1
  2. Ямар боловсрол миний ажлын шаардлагыг хангах вэ? ..... 25
  3. Би сургалтын төлбөрөө хэрхэн төлөх вэ? ..... 41
  4. Би Тасралтгүй Боловсролын Сангаас зээл авах хүсэлт гаргах хэрэгтэй юү?..... 55
  5. Би ангид байхдаа хэрхэн амжилттай суралцах вэ?..... 79
  6. Би ангиас гадуурх орчинд хэрхэн амжилтад хүрэх вэ? ..... 97
- 7-12 дахь цугларалтуудад бид “Ажил хайх нь” дасгалын номны материалуудаас ашиглана.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав.

Юта муж, Солт Лэйк хот

© 2014 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан.

Англи эхийн зөвшөөрөл: 8/13

Орчуулгын зөвшөөрөл: 8/13.

*“Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь”* дасгалын номны орчуулга

Mongolian

12377 363



# 1

*Ямар төрлийн  
ажил бие даахад  
маань туслах вэ?*

---

**Илүү сайн ажлын төлөө сурч  
боловсрох нь**



# ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

## Цугларалт хийх өдөр:


- Хэрэв танд бүлгийн гишүүдийн холбоо барих мэдээлэл байгаа бол тэдэн рүү мессеж илгээ, эсвэл утсаар ярь. Тэднээс цугларалтад ирэх эсэхийг асуу. Тэднийг 10 минутын өмнө ирж, ирцийн бүртгэл дээр гарын үсэг зурахад урь.
- Цугларалтын үеэр ашиглах материалуудыг бэлд:
  - \* Бүлгийн гишүүн бүрд зориулж, дасгалын дэвтэр болон *“Миний бие даах чадвартай болох арга зам”* товхимлын хувийг авч ир.
  - \* Боломжтой бол видео бичлэг үзүүлэхэд бэлд.
  - \* Ном эсвэл видео бичлэгүүд байхгүй бол та тэдгээрийг онлайн-наар [srs.lds.org](http://srs.lds.org) вэбсайтаас авч болно.
  - \* Бие даах чадвар хөгжүүлэх төвийн Санал болгосон жагсаалтуудын хуулбарыг авч ирнэ үү: (1) Санал болгосон ажлын жагсаалт, мөн (2) Санал болгосон сургууль, хөтөлбөрийн жагсаалт. Та эдгээрийг өөрийн гадасны бие даах чадвар хөгжүүлэх төвөөс, мөн бие даах чадвар хөгжүүлэх төвийн мэргэжилтнээс, эсвэл онлайн-наар [srs.lds.org/pref](http://srs.lds.org/pref) вэбсайтаас авч болно.

## Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойртуулан суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
  - \* Зохицуулагч нь цугларалтын үеэр зогсохгүй, мөн ширээний эхэнд суухгүй. Зохицуулагч анхаарлын төвд байх ёсгүй бөгөөд бүлгийн гишүүдийг нэг нэгэндээ анхаарал хандуулахад туслах ёстой.

## Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд дотно хүлээн авч угт. Гишүүдийн нэрийг чээжил.
- Бүртгэлийн хуудас дамжуулан явуулж, бүлгийн гишүүдээс өөрийн овог нэр, тойрог, эсвэл салбар, мөн төрсөн огноогоо (*оныг оруулахгүй, сар, өдрөө бичнэ*) бичихийг хүс.
- Бүлгийн цугларалтыг хуваарийн дагуу явуулахын тулд цаг бүртгэгч томил. Уг цаг бүртгэгчээс номонд заасны дагуу цаг хэмжигчийг тааруулахыг хүс.
  - \* Жишээлбэл, та “Цаг: Суралц хэсэгт 60 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул” гэсэн зааврыг харна. Цаг бүртгэгч нь хугацааг гар утас, бугуйн цаг эсвэл өөр бусад цаг хэмжих хэрэгсэл дээр тавих бөгөөд цаг дуусаж байгааг бүл-



гийнхэндээ мэдэгдэнэ. Үүний дараа бүлгийнхэн дараагийн хэсэг рүү орох, эсвэл хэлэлцүүлгээ дахин хэдэн минутаар сунгах эсэхээ шийднэ.

## Цугларалтын дараа:

- Бүлгийн цугларалтын дараа [srs.lds.org/report](https://srs.lds.org/report) вэбсайт руу орж, зааврыг даган, бүлгийн бүх гишүүнийг бүртгэнэ.
- Эхний цугларалтын дараа холбоо барих мэдээллийн жагсаалтыг гаргаад, дараагийн цугларалтаар бүлгийнхэнд тарааж өгнө.

## Цугларалт эхлэх үед:

- “Энэхүү бие даах чадвар хөгжүүлэх бүлэгт тавтай морилно уу” гэж хэл.
- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Дараах зүйлсийг хэл:
  - \* Энэ бол бие даах чадварын “Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь” бүлэг юм. Та нар бүгд энд илүү сурч боловсрох зорилготой ирсэн үү?
  - \* “Танд Тасралтгүй Боловсролын Сангаас зээл авах шаардлага байхгүй бол маш сайн! Хэрэв танд ТБС-ийн зээл хэрэгтэй бол та дөрөв дэх цугларалтаас эхлэн маягтаа бөглөж эхлэхэд бэлэн болсон байна.
  - \* Бид 12 удаа цугларна. Цугларалт бүр ойролцоогоор 2 цаг үргэлжилнэ. Үүнээс гадна бид өдөр бүр боловсрол олоход, эсвэл мэргэжил эзэмшихэд тань туслах өгсөн амлалтаа биелүүлэхэд нэг юмуу хоёр цаг зарцуулах болно. Та энэ бүхнийг хийхэд цаг зав гаргах уу?”
- Нээлтийн залбирал хий (хүсвэл дуулал дуулж болно).
- Дараах зүйлсийг хэл:
  - \* “Цугларах болгондоо бид *“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил”* нэртэй товхимлын нэг сэдвээр эхэлж байх болно. Энэ товхимол нь бидэнд сүнслэг болон материаллаг тал дээр бие даах чадвартай болоход хөтлөх зарчим, ур чадвар, дадал хэвшлүүдийн талаар суралцаж, тэдгээрийг дагаж амьдрахад туслах юм.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” дээр ажиллахад 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын 2-р хуудсан дээрх Тэргүүн Зөвлөлийн захидлыг унш. Дараа нь уг товхимлын 1-р зарчмыг үзэж дуусгаад, энэ дасгалын номон дээр үргэлжлүүлэн ажилла.





# СУРАЛЦ

## БИД ЭНЭ БҮЛЭГТ ХАМРАГДСАНААРАА ЮУ ХИЙХ ВЭ?

**Цаг:** Судал хэсэгт 60 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Унш:** Бие даах чадвар хөгжүүлэх энэхүү бүлгийн зорилгыг ойлгохын тулд энэ дасгалын номны нүүрний ар талын хуудсыг нээж, танилцуулгыг унш.

Бид нэг нэгэндээ боловсролтой болоход нь, мөн ажлын нөхцөл байдлаа сайжруулахад нь туслахаар энд цуглараад байна. Түүнчлэн бусдад илүү сайн хүрч үйлчлэхийн тулд бие даах чадвартай болох гэсэн илүү том зорилго бидэнд бий.

**Үз:** “Бие даах чадвартай болохын тулд сурч боловсрох нь” (Видео бичлэг байхгүй бол 18-р хуудсыг унш.)

**Ярилц:** Та видео бичлэгээс юу мэдэж авсан, эсвэл мэдэрсэн бэ?

**Унш:** Эдгээр мэдэгдлийг ээлж ээлжээр уншицгаая.

1. Бид бие даахыг хүсдэг.
2. Гэхдээ бидэнд сайн ажилд орох, эсвэл сайн бизнес бий болгох ур чадвар байхгүй.
3. Тийм учраас бид өөрсдийн ур чадварыг сайжруулахын тулд сурч боловсрох, эсвэл дадлага туршлагатай болох хэрэгтэй.
4. Эдгээр ур чадвар нь биднийг илүү сайн ажил, илүү их орлого руу хөтөлнө.
5. Түүнчлэн илүү их орлого, илүү их итгэл биднийг бие даахад тусална.

**Ярилц:** Энэ нь бидний энд байгаа шалтгааны тухай сайн дүгнэлт мөн үү?

**Унш:** Бид долоо хоног болгон дараах асуултуудад бүлгээрээ хариулж байх болно.

1 ДЭХ ДОЛОО ХОНОГ	2 ДАХЬ ДОЛОО ХОНОГ	3 ДАХЬ ДОЛОО ХОНОГ	4 ДЭХ ДОЛОО ХОНОГ	5 ДАХЬ ДОЛОО ХОНОГ	6 ДАХЬ ДОЛОО ХОНОГ
Ямар төрлийн ажил бие даахад маань туслах вэ?	Ямар боловсрол миний ажлын шаардлагыг хангах вэ?	Би сургалтын төлбөрөө хэрхэн төлөх вэ?	Би Тасралтгүй Боловсролын Сангаас зээл авах хүсэлт гаргах хэрэгтэй юү?	Би ангид байхдаа хэрхэн амжилттай суралцах вэ?	Би ангиас гадуурх орчинд хэрхэн амжилтад хүрэх вэ?

**Ярилц:** Бид яагаад энэ долоо хоногийн цугларалтыг боловсролын талаар биш, харин сонирхож буй ажлаа хэрхэн сонгох талаар эхэлж байна гэж та бодож байна вэ?



**Унш:** Боловсролын зорилго бол сайн ажилтай болох явдал юм. Эхний 6 долоо хоногт бид боловсролын талаар суралцана. 7-12 дахь долоо хоногт бид хэрхэн сайн ажил олох, мөн ажилдаа хэрхэн амжилт гаргах талаар суралцана.

7 ДАХЬ ДО- ЛОО ХОНОГ	8 ДАХЬ ДО- ЛОО ХОНОГ	9 ДЭХ ДО- ЛОО ХОНОГ	10 ДАХЬ ДО- ЛОО ХОНОГ	11 ДЭХ ДО- ЛОО ХОНОГ	12 ДАХЬ ДО- ЛОО ХОНОГ
Би зөв ажлын боломжуудыг хэрхэн олох вэ?	Би өөрийгөө хэрхэн итгэл үнэмшилтэй танилцуулах вэ?	Би хөдөлмөрийн “далд” зах зээл рүү хэрхэн орох вэ?	Би шууд сонгогдохын тулд ямар байх ёстой вэ?	Би ажлынхаа эрэл хайгуулыг хэрхэн хурдан хийх вэ?	Би ажлаа хэрхэн сайн гүйцэтгэж, үргэлжлүүлэн амжилт гаргах вэ?

**Унш:** Бид хамтдаа эдгээр асуултад хариулж, амжилтад хүрч чадна!

## БИ ЯМАР ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ ЧАДАХ ВЭ?

**Унш:** Бид бүлгээрээ хэрхэн ажиллах талаар ярилцацгаая.

**Үз:** “Явж, мөн хийх’ талаар суралцах нь” (Видео бичлэг байхгүй бол 20-р хуудсыг унш.)

**Ярилц:** Бид нэг нэгэндээ “Явж, мөн хийх”-д нь тусална. Энэ видео бичлэгт юу чухал байсан бэ? Сурч боловсрох энэ хандлага сургуулийн, эсвэл Сүмийн жирийн ангиудаас юугаараа ялгаатай вэ?

**Дадлага хий:** Суралцагчдыг гурав гурван хүнээс бүрдсэн жижиг бүлгүүдэд хуваарил. Сандлаа нэг нэгэн рүүгээ харуулан сууж, дараах үйл ажиллагааг хий.

1. Өөрийгөө товч танилцуул—нэр, гэр бүлээ. Хийж бүтээсэн ажил үйлсийнхээ талаар ярь. Жишээлбэл, “Би ажлаасаа сайн ажилтны шагнал авсан,” эсвэл “Би номлолд үйлчилсэн,” эсвэл “Би гурван хүүхэд өсгөсөн” гэх мэт.
2. Дараа нь бүлгийн нөгөө хоёр хүн танд тэр ажлыг хийж гүйцэтгэхэд ямар ямар чадвар хэрэгтэй байсан талаар хурдхан хэлнэ. Хэрэв таныг “Би номлолд үйлчилсэн” гэж хэлбэл, бусад нь “Тэгвэл та зоригтой, ажилсаг, мөн удирдагч, багш, бас хүмүүстэй сайхан харьцаж чаддаг юм байна” гэж хэлж болно.
3. Хүн болгон энэ маягаар давтаж хийнэ.
4. Бүлэгтээ буцаж нийл. Бүлгийн гишүүдийн хийж бүтээсэн ажил үйлс, тэдний зарим ур чадварын талаар хуваалц.

**Унш:** Бидэнд буй бүх авьяас чадвар, хүч чадал нь Их Эзэний агуулахын нэг хэсэг юм. Баруун гар талд байгаа судрыг унш.

**Ярилц:** Манай бүлэг нэг нэгэндээ туслахын тулд хэрхэн хамтран ажиллаж чадах вэ?

**Дадлага хий:** Эхний үйлдлийг бүлгээрээ хамт хий. Таван минутын дотор бүлэгтээ ямар нэр өгөхөө ярилц.

Бүлгийн нэрийг доор бич:

*“Мөн хүн болгон авьяас билгээ сайжруулж болохын тулд, хүн бүр өөр авьяасыг тийм ээ, бүр зуу дахин ихийг олж авч болохын тулд. . . Их Эзэний агуулахад хийгдэж болох буюу. . . Хүн болгон хөршийнхөө анхаарал тусламжийг эрэлхийлж мөн бүх зүйлийг Бурханы алдар суугийн төлөө бүхнээ зориулан хийх ёстой.”*

**СУРГААЛ БА ГЭРЭЭ**  
**82:18-19**

## БИ ИРЭЭДҮЙД ЯМАР АЖИЛ СОНГОХ ВЭ?

**Унш:** Энэ долоо хоногийн турш бид илүү их бие даахын тулд ямар төрлийн ажил хийхээ шийднэ. Дараа нь бид эргэж ирээд, тайлагнана.

Энэ долоо хоногийн дараах асуулт, хийх зүйл нь бидний ярилцлага, амлалтуудыг чиглүүлнэ.

**Унш:** ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН АСУУЛТ—Ямар төрлийн ажил бие даахад маань туслах вэ?

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ—Ирээдүйн ажлын боломжуудыг судалж, ажлуудын талаар хүмүүсээс мэдээлэл цуглуулан, төлөвлөгөө гаргах

**Дадлага хий:** Бие даахад шаардагдах сар тутмын орлогынхоо мөнгөн дүнг бич (Миний бие даах чадвартай болох арга зам дээрх бие даах чадварын үнэлгээнээс):

Надад бие даахад сар болгон           МӨНГӨН ДҮН           төгрөг хэрэгтэй.

**Унш:** Тэгэхээр бид ирээдүйд энэ хэмжээний орлоготой ямар ажилд орохыг хүсэж байна вэ?

**Үз:** “ТБС-ийн Санал болгосон жагсаалтууд” (Видео бичлэг байхгүй бол 21-р хуудсыг унш.)

**Дадлага хий:** Зохицуулагч та нарын хүн нэг бүрд Санал болгосон ажлын жагсаалтын нэг хувийг өгөх ёстой.

1. Сандлаа бүлгийн өөр нэгэн гишүүн рүү харуулж суу. Зохицуулагчийн та нарт өгсөн Санал болгосон ажлын жагсаалтыг хамтдаа үз.

2. Одоо эдгээр асуултад хариул:

- Ямар ажил таны анхаарлыг татаж байна вэ? Тэдний дунд таны давуу тал эсвэл дадлага туршлагатай нийцэх ажил байна уу?
- Ямар ямар ажил өндөр цалинтай байна вэ?
- Ямар ажилд илүү их боловсрол шаардагдах вэ?
- Энэ жагсаалт та нарт хэрхэн туслах вэ?

**Унш:** Бид цалингийнхаа шаардлагыг хангасан, мөн эрэлт хэрэгцээ ихтэй ямар ямар ажил байгаа талаар ойлголттой болсны дараа сонголтуудынхаа талаар илүү ихийг судалж, сонголтоо хийх ёстой. “Ажлын төлөвлөгөө” нь бидэнд ирээдүйн ажлын, эсвэл бизнесийн талаар шийдвэр гаргахад тусална.

*Миний бие даах чадвартай болох арга зам товхимол нь танд эдгээр шийдвэрийг гаргахад тусална.*

## 1: Ямар төрлийн ажил бие даахад маань туслах вэ?

**Унш:** Долоо хоногийн дундуур бид ажлын төлөвлөгөө гаргана (24-р хуудсыг үзнэ үү). Энэ дадлага ажил төлөвлөгөө гаргахад маань алхам алхмаар туслах болно!

**Дадлага ажил:** Сандлаа бүлгийнхээ өөр нэгэн гишүүн рүү харуулж, энэ дасгалыг хамтарч хий.

**1-р алхам.** Дараах хоёр жишээг унш. Дараа нь дадлага хийх маягаар өөрийн сонирхож буй нэг ажлыг “Таны жишээ” гэдгийн доор байрлах хоосон хүснэгтэд бич. Хажуугийн мөрөнд тухайн ажлын талаар асууж болох хүмүүсийн нэрийг бич.

### МИНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: ЯМАР АЖИЛ БИЕ ДААХАД МААНЬ ТУСЛАХ ВЭ?

	1-р жишээ	2-р жишээ	Таны жишээ
Таны анхаарлыг татсан гурван төрлийн ажлыг жагсааж бич.	<i>Автомеханик</i>	<i>Эмнэлгийн техник хэрэгслийн операторч</i>	

### ЭНЭ ТӨРЛИЙН АЖЛЫН ТАЛААР ХЭН МЭДЭХ ВЭ?

Ажил тус бүрийн талаар уулзаж ярилцах 3-5 хүний нэрийг жагсааж бич.	<i>Мигель, механикч найз Роберто, автомашин борлуулагч Карлос, миний авга ах</i>	<i>Наоми, эмнэлэгт ажилладаг Дорин, сувилагч Сюзи, компьютерийн мэргэжилтэн</i>	
---	--	---	--

## 1: Ямар төрлийн ажил бие даахад маань туслах вэ?

**2-р алхам.** Доорх асуулт, жишээнүүдийг унш. “Таны жишээ”-ний хүснэгтийг бөглө. Та энэ дасгалыг хийхдээ зарим зүйлийг таамаглаж бөглөх хэрэгтэй болох байх.

### БИ ЭНЭ ХҮМҮҮСТ ЯМАР ЯМАР АСУУЛТ ТАВИХ ВЭ?

	<b>1-р жишээ (Автомеханик)</b>	<b>2-р жишээ (Эмнэлгийн техник хэрэгслийн операторч)</b>	<b>Таны жишээ</b>
Би энэ ажлыг хийж эхлэхэд сар болгон хэдэн төгрөгийн цалин авах вэ? Нэг жилийн дараагаас хэдэн төгрөгийн цалин авдаг болох вэ?	<i>Гарааны цалин: 3500 Нэг жилийн дараах цалин: 4500</i>	<i>Гарааны цалин: 4200 Нэг жилийн дараах цалин: 5000</i>	
Би ажил тус бүрд тавигдах шаардлагад хэрхэн нийцэх вэ?	<i>Механик инженерийн сургууль, 8 сар 1 жил ажилласан туршлагатай Харилцаа холбоо тогтоох хэн нэгнийг таньдаг байх</i>	<i>Анагаахын дунд сургууль, 2,5 жил 1,5 жилийн ажлын туршлагатай Математик, шинжлэх ухааны хичээлүүдийг авсан байх</i>	
Танай нутаг дэвсгэрт сургууль байдаг уу?	<i>Тийм</i>	<i>Тийм</i>	
Энэ ажлын байрны эрэлт хэрэгцээ өсөж байгаа юу?	<i>Өсөлт удаан, эрэлт хэрэгцээ дунд зэрэг</i>	<i>Өсөлт хурдан, эрэлт хэрэгцээ их</i>	
Ажилд ороход ямар үнэ өртөгтэй байх вэ?	<i>Багаж хэрэгсэлд 6000</i>	<i>Мэргэжлийн гэрчилгээ авах шалгалтад 4000</i>	

**3-р алхам.** Жишээнүүдийг уншаад, хариултаа гурав дахь баганад дүгнэж бич. Энэ бол дадлага маягаар хийж байгаа дасгал юм шүү. Бид энэ долоо хоногт илүү үнэн зөв мэдээлэл цуглуулна. Хийж дууссаныхаа дараа үндсэн бүлэгтээ буцаад нэгд.

**АЛЬ АЖИЛ НЬ ЦАЛИН ӨНДӨРТЭЙ БӨГӨӨД МИНИЙ ХҮЧТЭЙ ТАЛ, ДАДЛАГА ТУРШЛАГАД ТОХИРЧ БАЙНА ВЭ?**

	<b>1-р жишээ (Автомеханик)</b>	<b>2-р жишээ (Эмнэлгийн техник хэрэгслийн операторч)</b>	<b>Таны жишээ</b>
Би эдгээр сонголтын талаар юу олж мэдсэн бэ? Аль нь надад илүү тохирч байна вэ?	Арай бага боловсрол шаардах, зардал багатай, хэрэгцээ хангахуйц цалинтай, эрэлт хэрэгцээ багатай ажил	Шаардлагыг хангахад илүү их чадвар, илүү боловсрол хэрэгтэй, хугацаа урт, илүү өндөр зардалтай, мөн илүү өндөр цалинтай, эрэлт хэрэгцээ ихтэй ажил	

**Унш:** Бид энэ долоо хоногийн дотор мэдээлэл цуглуулсныхаа дараа шийдвэр гаргана. Бид тусламж авахын тулд залбирч, патриархын адислалаа уншиж болно. Анхаарвал зохих зүйлс: (1) Бид бие даахад хэдэн төгрөгийн цалинтай байх шаардлагатай вэ гэдгээс эхэлнэ. (2) Дараа нь бид тэр хэмжээний цалинг олгох таны хүсэж буй ирээдүйн ажлыг сонгоно. (3) Түүний дараа бид тэрхүү ажлын шаардлагад ямар боловсрол, дадлага туршлага нийцэх талаар шийд гаргана.



## БИ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ ХЭРХЭН ТАНИЛЦУУЛАХ ВЭ?

**Унш:** Дараагийн долоо хоногт бид ажлын төлөвлөгөөгөө бүлгийнхэндээ чанга уншиж танилцуулна. Тиймээс энэ жишээг үзээд, дараа нь дадлага хийцгээе.

**Үз:** “Миний ажлын төлөвлөгөө гурван минутад” (Видео бичлэг байхгүй бол 22-р хуудсыг унш.)

**Дадлага ажил:** Босоод, өнөөдөр хамт дадлага хийгээгүй хэн нэгэн дээр оч. Ажлын төлөвлөгөөний энэ жишээг (7-9-р хуудас дээрх) өөрийнх мэтээр танилцуул. Видео бичлэг дээрх жишээг дага. Хэрэв танд аль нэг мэдээлэл нь байхгүй бол өөрөө ургуулан бодоод хий.

1. Өөрийнхөө хийсэн ажлын сонголтууд болон ажлуудынхаа талаар хэнтэй уулзаж ярилцсан тухайгаа нэг минут ярь.
2. Тавьсан асуултуудынхаа хариултыг нэг минутад хуваалц.
3. Та эдгээр жишээ болгон өгсөн ажлын сонголтын алийг сонгосон, мөн яагаад сонгосон болохоо нэг минут ярь.
4. Дараа нь нөгөө хүнээсээ санал хүсэлт байгаа эсэхийг асуухад хоёр минут зарцуул. Асуу: Би ажлын төлөвлөгөөгөө хэрхэн илүү боловсронгуй болгох вэ? Би үүнийг хэрхэн үр дүнтэй танилцуулж болох вэ?
5. Дүрээ солиод, нөгөө хүнээрээ танилцуулга хийлгүүл.

**Ярилц:** Та нийт бүлгийнхэнтэйгээ энэ долоо хоногийн турш хэрхэн мэдээлэл цуглуулах, мөн ажлын төлөвлөгөөгөө хэрхэн танилцуулах талаар ярилц. Асуулт тавьж, санал бодлоо хуваалц.

**Унш:** Энэ долоо хоногийн турш мэдээлэл цуглуулаад, тэрхүү мэдээллээ дараагийн хуудсан дээрх ажлын төлөвлөгөөн дээр бич. Боломжийнхоо хэрээр, аль болох олон хүнтэй уулзаж ярилц. Олон асуулт тавь! Танд бичиж, тэмдэглэх илүү зай хэрэгтэй байгаа бол, 24-р хуудсан дээрх нэмэлт ажлын төлөвлөгөөг ашиглаж болно.

**МИНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: ЯМАР АЖИЛ БИЕ ДААХАД МААНЬ ТУСЛАХ ВЭ?**

Сонирхож байгаа 3 төрлийн ажлаа жагсаан бич.

--	--	--

**ЭНЭ ТӨРЛИЙН АЖЛЫН ТАЛААР ХЭН МЭДЭХ ВЭ?**

Ажил бүрийн талаар уулзаж ярилцах 3-5 хүний нэрийг жагсаан бич.

--	--	--

**БИ ЭДГЭЭР ХҮНД ЯМАР ЯМАР АСУУЛТ ТАВИХ ВЭ?**

Би энэ ажилд орохдоо эхлээд хэдэн төгрөгийн цалинтай байх вэ? Нэг жил ажилласны дараа миний цалин хэд болох вэ?

--	--	--

Би ажил тус бүрийн шаардлагыг хэрхэн хангах вэ?

--	--	--

Танай нутаг дэвсгэрт сургууль бий юу?

--	--	--

Энэ төрлийн ажлын эрэлт хэрэгцээ өсөж байгаа юу?

--	--	--

Энэ ажлыг эхлүүлэхэд зардал нь хэд байх вэ?

--	--	--

Бусад асуулт?

--	--	--

**ЯМАР АЖИЛ ХАМГИЙН САЙН ОРЛОГОТОЙ БӨГӨӨД МИНИЙ ХҮЧТЭЙ ТАЛ, УР ЧАДВАРТ ИЛҮҮ ТОХИРЧ БАЙНА ВЭ?**

Би эдгээр сонголтын талаар юу олж мэдсэн бэ? Аль нь надад хамгийн сайн тохирч байна вэ?

--	--	--

### БИ САНХҮҮГЭЭ ХЭРХЭН УХААЛАГ ЗОХИЦУУЛАХ ВЭ?

**Унш:** Бие даахын нэг хэсэг бол олсон орлогоосоо бага зарцуулж, хадгаламжиндаа мөнгөтэй байх явдал юм. Хадгаламж нь төлөвлөгдөөгүй зардлууд гарахад, эсвэл бидний орлого тооцоолж байснаас бага болох үед өөрийн болон гэр бүлийнхээ хэрэгцээг хангахад туслах юм. Бид энэ бүлгийн гишүүний хувьд долоо хоног бүр, ганц хоёр төгрөг байсан ч гэсэн хадгаламжиндаа хийж байх амлалт өгч байна.

**Ярилц:** Зарим улс оронд банкинд мөнгөө хадгалуулах нь зөв шийдвэр байдаг. Харин мөнгөний ханшны уналт ихтэй, эсвэл банкны систем нь тогтворгүй зарим улс оронд банкинд мөнгө хадгалуулах нь зөв шийдвэр байж чаддаггүй. Танай улс оронд банкны хадгаламжийн нөхцөл хэр сайн бэ? Аль банкны хадгаламжийн хүү хамгийн өндөр вэ?

**Унш:** Бие даахын өөр нэг чухал хэсэг бол хувийн өр зээлгүй байх явдал юм. Бид төлж чадахаасаа илүү их мөнгө зарцуулах үед хувийн зээлийг ашигладаг. Бошиглогчид бидэнд хувьдаа зээл авахаас зайлсхийхийг, мөн илүү их бие дааж эхлэхдээ зээлээ багасган, улмаар төлж барагдуулахыг (бизнесийн зээл авах нь зарим тохиолдолд ухаалаг ч) зөвлөсөн байдаг.

Эмчилгээний гэнэтийн зардлууд нь ихэнхдээ санхүүгийн хувьд томоохон дарамт үүсгэдэг. Даатгал, засгийн газрын эрүүл мэндийн хөтөлбөрүүд ихэнхдээ биднийг эдгээр дарамтад орохоос сэргийлдэг. Даатгалд, эсвэл засгийн газрын эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд хамрагдах нь бидний бие даах чадвараа хөгжүүлэх арга замын чухал хэсэг байж болно.

**Ярилц:** Зарим төрлийн даатгалд (эрүүл мэндийн болон амь насны даатгал гэх мэт) хамрагдах боломж их байдаг бөгөөд тэдгээр нь бусад төрлийн даатгалаас илүү ашигтай байдаг. Зарим даатгалын үйлчилгээ үзүүлэгч сайн байхад, зарим нь шударга бус байх тохиолдол бий. Танай улсад ямар даатгалын байгууллага хамгийн сайн нь вэ?

## ЯАГААД ИХ ЭЗЭН БИДНИЙГ БИЕ ДААСАН БАЙЛГАХЫГ ХҮСДЭГ ВЭ?

**Ярилц:** Яагаад Их Эзэн биднийг бие даасан байлгахыг хүсдэг вэ?

**Унш:** Баруун гар талд байгаа эшлэлийг унш.

**Ярилц:** Ахлагч Д.Тодд Кристоффэрсоны хэлснээр, бидний ажилд орох гэсэн хичээл зүтгэл хэрхэн “ариун зорилгод” үйлчилж байгаа вэ?

**Унш:** Биднийг бие даахад туслах хүч чадал Аврагчид бий. Тэрээр “Учир нь болгоогтун, би бол Бурхан, мөн би бол гайхамшгуудын Бурхан” ( 2 Нифай 37-23) хэмээн хэлсэн байдаг. Бид ажил хөдөлмөртөө амжилт гаргахсан гэсэн хичээл зүтгэлээ бие даах гэсэн ариун зорилгод зориулах, эсвэл өргөл болгох аваас Их Эзэн биднийг сүнслэг өдөөлтөөр дамжуулан удирдах болно. Бид Түүнээс ирэх сүнслэг өдөөлтийг сонсон, дагаснаараа итгэлээ харуулах үед Их Эзэн гайхамшгуудыг үйлдэж, бидний хийж чадахаас ч их зүйлийг бидэнд өгөх болно.

*“Өргөл болгох гэдэг нь ямар нэгэн ариун болох зүйлийг ариун зорилгод зориулагдсан хэмээн хуримтлуулах, эсвэл өргөл болгох гэсэн утгатай юм.”*

**Д.ТОДД  
КРИСТОФФЭРСОН,**  
*“Өргөл болгосон амьдралын тухай бодол эргэцүүлэл,” Ensign эсвэл 2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 17*

## БИ ТБС-ААС ЗЭЭЛ АВАХАД ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

Хэрэв та болон танай гэр бүл санхүүгийн боломжгүй, мөн орон нутгийнхаа санхүүгийн эх сурвалжуудыг ашиглах боломжгүй бол, ТБС-ийн зээл авахад тавигдах шаардлагыг хангаж, сургалтын төлбөрөө төлөх боломжтой. Түүнчлэн таны ажлын төлөвлөгөө ТБС-ийн зээлд бэлтгэхэд тань туслах болно. Хэрэв та ТБС-ийн зээл хэрэгтэй гэж бодож байгаа бол ажлын төлөвлөгөөгөө боловсруулж байхдаа эдгээр асуултад хариулж, мэдээллийг ТБС-ийн маягт бөглөхөд зориулан хадгал.

### МИНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: ЯМАР АЖИЛ БИЕ ДААХАД МААНЬ ТУСЛАХ ВЭ?

#### Одоогийн ажил

Нэг долоо хоногт ажиллах цаг (бүх ажил)

Албан тушаал(ууд)

Сарын цалин:

**Ирээдүйн ажил (ажил нь БДЧХТ-ийн Санал болгосон ажлын жагсаалтад байх ёстой, эсвэл жагсаалтад байхгүй бол харгалзаж үзэх хүсэлт гаргасан байх ёстой)**

Ирээдүйн ажлын албан тушаал:

Тооцоолж буй сарын цалин (хөтөлбөрт хамрагдаж төгссөний дараа):





# ТУНГААН БОД

## БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

**Цаг:** Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр судар хуваалцаныг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

---

---

---

---

---

---

---

**Ярилц:** Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

*“Үнэнээр би хэлнэ, хүмүүс сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулж, мөн чөлөөт хүсэл зоригоороо олон зүйлийг хийж, мөн туйлын зөв шударга байдлыг тохиолгохоор авчрах ёстой.”*

**СУРГААЛ БА ГЭРЭЭ 58:27**



# АМЛАЛТ ӨГ

## БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

**Цаг:** Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Унш:** Бид долоо хоног бүр “хамтрагчаа” сонгоно. Энэ хамтрагч нь өгсөн амлалтаа биелүүлэхэд бидэнд туслах тус бүлгийн гишүүн байна. Хамтрагчид нь долоо хоногийн турш нэг нэгэнтэйгээ холбогдож, хийж гүйцэтгэсэн ажлаа бие биендээ тайлагнана. Ерөнхийдөө, хамтрагч нь нэг хүйсийнх байх бөгөөд гэр бүлийн гишүүн бус хүн байна.

**Дадлага хий:** Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

---

*Хамтрагчийн нэр*

---

*Холбоо барих мэдээлэл*

**Хамтрагчдаа амлалтаа нэг нэгээр нь чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.**

### МИНИЙ АМЛАЛТУУД

**Би ажлынхаа төлөвлөгөөний мэдээллийг цуглуулахын тулд наад зах нь таван хүнтэй уулзаж ярилцана.**

Миний зорилго:    5    8    10

**Би ажлын төлөвлөгөөгөө танилцуулахад бэлтгэнэ.**

Би өнөөдрийн “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

---

*Миний гарын үсэг*

---

*Хамтрагчийн гарын үсэг*

## БИ ГАРГАЖ БУЙ АХИЦДАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

- Үз:** “Үйлдэл ба амлалт” (Видео бичлэг байхгүй бол 23-р хуудсыг унш.)
- Унш:** Бид амлалтаа тайлагнаж байвал, тэдгээрийг биелүүлэх магадлал өндөр байдаг. Баруун гар талд байгаа эшлэлийг унш.
- Дасгал:** Дараагийн цугларалтын өмнө хийж гүйцэтгэсэн ажлаа тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх хүснэгтэд “Тийм” , “Үгүй” гэж эсвэл амлалтаа биелүүлсэн тохиолдлынхоо тоог бич.

Ажлын төлөвлөгөөнийхөө талаар наад зах нь таван хүнтэй уулзаж ярилцсан (Тоог бич)	Ажлын төлөвлөгөөнийхөө талаар танилцуулга бэлтгэсэн (Тийм/Үгүй)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)

**Унш:** Түүнчлэн “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлынхоо арын хуудсан дээр зарлагаа тэмдэглээрэй.

Бидний дараагийн цугларалтын үеэр зохицуулагч самбар дээр амлалтын хүснэгт зурна (дээрхтэй адил). Бид цугларалт эхлэхээс 10 минутын өмнө ирж, хүснэгт дээр өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажлыг бичнэ.

Дараагийн долоо хоногт “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” дээрх сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. Зохицуулагч юу хийдэг талаар олж мэдэхийн тулд тэднээс энэ дасгалын номны нүүр хавтасны арын хуудаснаас уншихыг хүс. Тэд өнөөдөр зохицуулагчийн хийж гүйцэтгэсэнтэй адил зүйлийг хийхэд туслах ёстой.

- Сүнснийг урь. Бүлгийн гишүүдийг Сүнснийг эрэлхийлэхэд урь.
- Ашиглаж буй материалдаа бүрэн найд. Бүү нэм. Зөвхөн хийгэсэн зүйлийг л хий.
- Цагаа зохицуул.
- Эрч хүчтэй, хөгжилтэй бай!

Хэн нэгнээс хаалтын залбирал хийхийг хүс.



“Гүйцэтгэлийг хэмжвэл, гүйцэтгэл сайжирдаг. Гүйцэтгэлийг хэмжиж, тайлагнаж байвал сайжрах хурд нэмэгддэг.”

**ТОМАС С.МОНСОН,**  
Ерөнхий чуулганы тайлан, 1970 оны 10-р сар, 107

### Санал хүсэлт

Санал, сэтгэгдэл, санаа бодол болон туршлагаа [srsfeedback@ldschurch.org](mailto:srsfeedback@ldschurch.org) хаягаар илгээнэ үү.

### Зохицуулагчийн анхааралд:

Бүлгийн бүх гишүүнийг [srs.lds.org/report](http://srs.lds.org/report) вэбсайт дээр бүртгүүл.

Түүнчлэн бүлгийн гишүүдийн холбоо барих мэдээллийг хувилж олшруулахаа битгий мартаарай.

# Эх сурвалж

## БИЕ ДААХЫН ТУЛД СУРЧ БОЛОВСРОХ НЬ

Дүрүүдийг сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

**ЗОХИЦУУЛАГЧ:** Бүгдээрээ, сайн байна уу? Бидэнд нэрээ хэлээд, өөрийгөө товч танилцуулна уу.

**КВАМЭ:** За, намайг Квамэ гэдэг. Би дөнгөж саяхан номлолоосоо буусан, эхнэрээ хайж байгаа, мөн олдсон ажлаа хийж байгаа.

**КОНСУЭЛО:** Миний нэрийг Консуэло гэдэг. Би гэрлэсэн, хоёр жаахан хүүтэй. Би нөхөртөө жимсний лангуу ажиллуулахад нь тусалдаг.

**МЭКАЛА:** Намайг Мэкала гэдэг. Би зургаан настай охинтой, өрх толгойлсон эмэгтэй. Би зочид буудалд бүрэн цагийн цэвэрлэгчээр ажилладаг.

**РОБЭРТ:** Намайг Робэрт гэдэг. Би гэрлэсэн, таван хүүхэдтэй. Одоогийн байдлаар бишип хийдэг ч, сайн ажил олох гэж хичээж байгаа.

**ЗОХИЦУУЛАГЧ:** За, сайн байна. Тэгэхлээр, яагаад та бүхэн энд ирсэн бэ?

**КВАМЭ:** Би зүгээр л сургуульд орох гэсэн юм. Номлолын бүх хамтрагч маань сургуульд орохоор гэр рүүгээ буцаж байсан. Би ч мөн адил сургуульд явмаар байна.

**РОБЭРТ:** Ер нь бол би Тасралтгүй Боловсролын Сангийн зээлд хамрагдах хүсэлтэй байгаа юм л даа. Энд тэр талаар ярилцана биз дээ?

**КОНСУЭЛО:** Бошиглогч боломжийнхоо хэрээр боловсролтой бол гэж хэлсэн байдаг. Тийм учраас би нөхөртөө энэ бүхнийг хийх хэрэгтэй гэж хэлсэн.

**МЭКАЛА:** Тэгэхээр надад илүү бие даахад маань туслах сайн ажил хэрэгтэй байгаа юм. Тэгээд ч надад олон үр чадвар байхгүй.

**ЗОХИЦУУЛАГЧ:** За, тэгэхлээр бидэнд энд байх олон шалтгаан байгаа юм байна. Бүгдээрээ хамтдаа сайн ажиллацгаая. Мэкала, та маш чухал зүйл хэллээ. Та бидэнд илүү дэлгэрэнгүй ярьж өгнө үү.

**МЭКАЛА:** Би маш урт цагаар ажиллаж байгаа учраас охинтойгоо бараг хамт байж чаддаггүй. Үүнээс гадна, ямар нэгэн сургалтад хамрагдахгүйгээр сайн ажилд орох боломжгүй гэдгийг олж мэдсэн. Тийм ч учраас би ямар нэгэн мэргэжлийн үр чадвартай болохын тулд сурч боловсрох шаардлагатай байгаа юм. Манай бишип энэ бол тэр газар чинь гэж хэлсэн.

**ЗОХИЦУУЛАГЧ:** Таны зөв, Мэкала! Үнэндээ бид бүгд яг энэ зорилгоор энд цуглараад байгаа билээ. Энэ нь зөвхөн сурч боловсрох тухай биш юм. Гайхалтай байгаа биз? Энэ бүлэг дадлага туршилагатай болоход, эсвэл боловсролтой болоход тань төлөвлөхөд тусална. Гэхдээ бүлгийн зорилго нь мэргэжлийн үр чадвартай болох, илүү сайн ажилд орох, өөрсдийн орлогыг нэмэгдүүлэх зэрэгт оришиж байгаа юм. Магадгүй хамгийн чухал нь, бид энэхүү 12 долоо хоногийн турш жинхэнээсээ бие даахад маань туслах зарчим, үр чадвар, туршилагуудын талаар суралцах юм. Тэгэхээр энэ нь зүгээр сургуульд явахаас хавьгүй илүү, маш чухал зүйлийн тухай байх болно.

**РОБЭРТ:** ТБС-гийн зээлийн тухайд юу хэлэх вэ?

**ЗОХИЦУУЛАГЧ:** Хэрэв танд үнэхээр зээл хэрэгтэй гэдгийг олж мэдэх юм бол, **үргэлжлэл дараагийн хуудсанд бий**

мэдээж зээлд хамрагдах боломжтой бөгөөд бид хэрхэн хамрагдаж болох талаар бүх зүйлийг ярилцана. Хэрэв танд зээл авалгүй, шаардлагатай дадлага туршилага олж авах боломж гарвал та яах вэ? Тэгвэл танд тэр зээл хэрэггүй шүү дээ.

**КОНСУЭЛО:** Энэ нь бидэнд их сургуульд ороход туслах уу?

**ЗОХИЦУУЛАГЧ:** Хэрэв их сургууль нь сайн ажилд ороход тань шаардагдах мэргэжил эзэмшихэд туслах зөв газар мөн юм бол, тийм. Зарим үед манай улс оронд их дээд сургуулийн диплом нь ажилтай болгоно гэсэн үг биш байдаг.

**РОБЭРТ:** Тэр ч үнэн шүү. Би таксины жолооч хийдэг эмч нарыг танина.

**КВАМЭ:** Би зүгээр л ямар нэгэн юм эхлүүлмээр байна. Би номлолынхоо өмнө зөвхөн гудамжинд л юм зардаг байсан. Надад ямар нэгэн мэргэжлийн дадлага туршилага байхгүй.

**КОНСУЭЛО:** Тэгэхлээр би энд ажил, боловсролын алиных нь талаар суралцах гэж байгаа юм бэ?

**ЗОХИЦУУЛАГЧ:** Хоёуланд! Бид бие даахыг хүсэж байгаа, тийм үү? Тэгэхээр бид бие даах чадвар хөгжүүлэх гол чухал зарчмуудын талаар суралцана. Эхлээд бид ямар төрлийн ажил бие даасан амьдралтай байхад хөтлөх орлогыг өгөх тухайд шийдвэр гаргана.

Дараа нь тэр ажлынхаа шаардлагыг хангахад ямар мэргэжил, боловсрол туслах талаар шийдвэр гаргах юм. Түүний дараа бид тэр сургалтын төлбөрөө хэрхэн төлөх, мөн сургуульдаа хэрхэн амжилт гаргах арга замын талаар ярилцана. Бид нэг нэгэндээ зорилгодоо хүрэхэд нь тусална.

**РОБЭРТ:** Одоо харин ойлгомжтой болж байна. Өнөөдрийг хүртэл би зөвхөн сургуульд орох талаар л бодож байсан бо-

лохоос яагаад сургуульд орох ёстой гэдгээ бодож үзэж байгаагүй юм байна.

**КВАМЭ:** Энэ нь надад ямар нэгэн чиглэл өгөх юм шиг сонсогдлоо. Манай чуулгын ерөнхийлөгч намайг наашаа явуулсанд гайхаад байх юм алга даа.

**МЭКАЛА:** Энэ нь бодит үр дүнд хүргэх үү? Би их хэцүү байдалд байгаа л даа. Бас өөр арга замаар сурч боловсрох гэж үзсэн.

**ЗОХИЦУУЛАГЧ:** Ер нь бол бид хамтдаа сайн хичээж, нэг нэгэндээ туслах ёстой. Гэхдээ би энэ нь боломжтой гэдэгт итгэдэг. Их Эзэн биднийг бие дааж, амжилттай байгаасай гэж хүсдэг гэдэгт би чин сэтгэлээсээ итгэдэг. Тэрээр биднийг сурч боловсорч, өсөж хөгжөөсэй хэмээн хүсдэг. Түүнчлэн Түүнд бидэнд туслах хүч чадал бий. Цагаатгал нь сүнслэг болон материаллаг зүйлсийн аль алинд үнэн бодитой үйлчилдэг. Мөн бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүд нь бидэнтэй адил олон хүнд тусалсан. Та нар юу гэж бодож байна? Бид чадах уу? Бүгдээрээ үзээд алдах уу? Энд нэг хүний түүх байна л даа:

**ЭМЭЛДА:** Онц сурдаг оюутан байгаа маань миний хичээл зүтгэлийн үр дүн биш, харин Сүмийн ач гавьяа юм. Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд элсэх нь намайг илүү сүнслэг түвшинд авч ирнэ гэдгийг мэдэж байсан ч, эрдэм мэдлэгийн үүд хаалгыг нээж өгнө гэдгийг огтхон ч төсөөлж байгаагүй.

Сургаалын талаар суралцах нь намайг нойрноос минь сэрээсэн. Энэ нь би өөрөө хувь заяаныхаа эзэн гэдгийг ойлгоход тусалсан. Бидний өнөөгийн нөхцөл байдал, бидэнд юу мэдрэгдэж байгаа зэргээс үл хамааран миний Тэнгэрлэг Эцэг бидэнд зориулан сайхан зүйл төлөвлөсөн байгаа гэдэгт би эргэлзэхгүй байна.

**4-р хуудас руу буцаж оч**



## “ЯВЖ, МӨН ХИЙХ” ТАЛААР СУРАЛЦАХ НЬ

Дараах догол мөрүүдийг ээлжлэн унш.

Ердийн ангид бид ихэнхдээ дараах загварыг дагадаг: (1) Ихэнхдээ ангидаа ямар нэгэн бэлтгэлгүй орж ирж, сууна. (2) Багш ярина. (3) Бид сонсож, суралцах гэж хичээнэ. (4) Зарим үед асуултад хариулна. Дараа нь (5) бид гэр гэртээ харьдаг.

Бид бие даах чадвар хөгжүүлэх бүлэгт дараах загварыг дагах болно:



Бид долоо хоногийн турши үйлдэл хийж байх болно. Бид бүлгийнхээ өмнөх цугларалтаар хийнэ гэж амласан зүйлээ хийнэ. Бид асуулт асууж, шинэ санаа туршин, жинхэнээсээ суралцаж байх болно.

Дараа нь бүлгийнхээ цугларалтын өмнө бүгдээрээ дасгалын номоо, мөн өгсөн амлалтаа дахин нэг шалгаж, хичээлдээ оролцоход бэлэн, цагтаа ирж байна.

Бид долоо хоног болгоны бүлгийн цугларалтын эхний хагаст Суурь зарчим эсвэл дадал хэвшил дээр анхаарлаа хандуулж байна. Түүнчлэн бид гэр бүлийнхэндээ болон бусдад зааж өгөх үүрэгтэй.

Дараа нь бид амлалтаа **тайлагнаж**, нэг нэгнээсээ суралцан, сайжруулах арга замыг хайж олох юм.

Үүний дараа бид **Суралц** хэсэг рүү орно. Энд бид долоо хоногийн турши “явж, мөн хийх”-д шаардлагатай санаа, арга хэрэгслүүдийн талаар судална. Бид хамтдаа ярилцаж, видео бичлэг үзэн, суралцаж, мөн дадлага хийнэ.

Бид суралц хэсгийн дараа түр завсарлаад, **тунгаан бодно**. Энэ нь бидний сүнслэгээр өдөөгдөх, мөн хариултуудаа авах цаг байх юм.

Хамгийн сүүлд бид нэг нэгнийхээ өмнө **амлалт өгнө**. Бид амьдралаа сайжруулахын тулд долоо хоногийн турши хаашаа явж, юу хийх талаар ярилцана.

Энэ нь биднийг **үйлдэх** хэсэг рүү буцааж аваачих юм. Энэхүү сургалтын загварын хамгийн чухал хэсэг нь цугларалт хооронд болно! Бидэнд туслах долоо хоногийн “хамтрагчаа” бид өөрсдөө сонгох бөгөөд өдөр болгон үг хүнтэйгээ холбоо барьж, хийсэн, мэдэж сурсан зүйлсээ товч тайлагнаж байна. Бид мессеж илгээх юм уу, холбоо барих өөр арга хэрэгслийг ашиглаж болно. Нэмж хэлэхэд, бидний гэр бүл бидэнд туслах хамгийн чухал эх үүсвэр байх юм!

**5-р хуудас руу буцаж оч**

## ТБС-ИЙН САНАЛ БОЛГОСОН ЖАГСААЛТУУД

Дүрүүдийг сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

**ЗОХИЦУУЛАГЧ:** За, тэгэхээр бүгд анхаарлаа нааш хандуулна уу. ТБС-гийн энэхүү Санал болгосон жагсаалт нь манай нутаг дэвсгэрт буй хамгийн сайн ажил, боловсрол олгох хөтөлбөр, сургуулиудыг оруулсан байгаа. Хэрэв та ТБС-аас зээл авах хүсэлтэй байгаа бол энэ жагсаалтаас сонгох ёстой.

**КОНСУЭЛО:** Яагаад?

**ЗОХИЦУУЛАГЧ:** Сайн асуулт байна. Энэ жагсаалтад манай нутаг дэвсгэр дээрх хамгийн сайн ажлуудыг оруулсан байгаа. Эдгээр нь “хамгийн хүсүүштэй ажлууд” бөгөөд эрэл хэрэгцээ ихтэй ажлууд юм. Эдгээр ажлын нээлттэй орон тоо их, мөн олон хүнийг ажилд авч байгаа.

**РОБЭРТ:** Энэ ч үнэхээр хэрэгтэй зүйл харагдаж байна. Хэн энэ жагсаалтыг гаргасан бэ?

**ЗОХИЦУУЛАГЧ:** Манай орон нутгийн бие даах чадвар хөгжүүлэх төвийн менежер болон зарим сайн дурынхан зах зээлийн судалгаа хийж, ажлын чиг хандлагыг ажиглан, олон ажил олгогчтой уулзаж ярилцсан. Түүнчлэн тэд санал болгосон ажлын шаардлагад нийцэх мэргэжлийн ур чадвар олгох орон нутгийн сургууль, хөтөлбөрүүдийг олсон юм.

**МЭКАЛА:** Тэд хөтөлбөрүүдийн үргэлжлэх хугацаа, үнийг мөн оруулсан байна.

**КВАМЭ:** Пөөх. Зарим сургуулийн яг ажил хөтөлбөр хоёр гаруй жилийн хугацаатай байхад, зарим нь 10 сар байгаа нь сонирхол татаж байна.

**КОНСУЭЛО:** Төлбөрийн хувьд ч их ялгаатай юм байна. Яагаад ийм байгаа юм бол?

**ЗОХИЦУУЛАГЧ:** Бид сургалтын төлбөрийн үнэ ба чанарын талаар дараагийн долоо хоногуудад олж мэднэ. Гэхдээ та нарын харж буй зүйл бол маш чухал. Учир нь сургууль бүр адил чанартай гэсэн үг биш юм!

**МЭКАЛА:** Тэр ч чухал шүү. Надад сайн ажилд ороход туслах сургуульд л би явах хүсэлтэй байна. Гэхдээ хугацаа богино, төлбөр бага байх нь бас чухал л даа.

**ЗОХИЦУУЛАГЧ:** Яг зөв. Санал болгосон сургууль, хөтөлбөрүүд нь санал болгосон ажлуудын шаардлагыг хангах үр чадварыг боломжит хугацаанд боломжийн төлбөрөөр олгож байгаа юм. Мөн төгсөгчдийнх нь ажлын байртай болсон үзүүлэлт өндөр байх ёстой. Энэ бол бидний хувьд маш чухал хэрэгсэл юм.

**РОБЭРТ:** ТБС-гаас зээл авах шаардлагагүй байсан ч гэсэн энэ нь бидэнд тус болох уу?

**КВАМЭ:** Мэдээж, тийм. Би ямар ч байсан энэ жагсаалтаас эхэлнэ.

**ЗОХИЦУУЛАГЧ:** Сайхан санаа байна. Та энэ жагсаалтад ороогүй ажил, хөтөлбөрийг, эсвэл сургуулийг сонгосон ч байсан гэсэн, ямар ажил эрэлт хэрэгцээ ихтэй байгаа, мөн тэдгээр ажилд аль хөтөлбөр, сургуулиуд илүү тохирох вэ? гэсэн асуултын хариултыг олсон байх ёстой. Та нар юу гэж бодож байна?

**6-р хуудас руу буцаж оч**

## МИНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ГУРВАН МИНУТАД

Дүрүүдийг сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

**МЭКАЛА:** За тэгэхээр, би одоо ажлын төлөвлөгөөгөө гурван минутад багтааж танилцуулъя. Эхний хэсэгт ажлынхаа сонголтуудыг жагсаасан байгаа. Би одоогоор эдгээр сонголтын талаар бүрэн ишийдвэр гаргаагүй байгаа ч, их зүйл сурах илүү их найдвар төрж байна. Сонгосон ажлууд маань захирлын туслах, багш, зочид буудлын менежмент зэрэг юм. Тэгээд дараагийн хэсэгт. . .

**РОБЭРТ:** Ажлын төлөвлөгөөний дараагийн хэсэгт миний уулзаж ярилцсан хүмүүс байгаа. Орчуулагчийн ажлын хувьд, би орчуулгын товчооны хүмүүстэй болон гадаадын олон байгууллагатай хамтарч ажилладаг гадасны ерөнхийлөгчтэйгөө уулзсан. Боловсролын байгууллагын удирдах ажилтны тухайд, хувийн сургуулийн хоёрхон хүн надтай уулзаж ярилцах цаг гаргасан. Талхны үйлдвэрийн талаар хэлэхэд, би өөрийн нагац эгч Эллэнийг оруулаад, нийтдээ дөрвөн өөр талхны үйлдвэрийн эзэнтэй уулзсан. Бизнесийн туршлага дээрээ түлгүүрлал, энэ сонголт надад илүү боломжийн юм шиг харагдаж байгаа юм.

За тэгэхээр надаас асуух зүйл болон санал хүсэлт байна уу?

**МЭКАЛА:** Эдгээр сонголтын аль нь танд Сүмийн дуудлагаа илүү сайн хийх боломж олгох вэ? Танд энэ нь их чухал гэдгийг би мэднэ л дээ.

**КОНСУЭЛО:** Тэгэхээр, талхны үйлдвэрийг эхлүүлэхэд танд ямар ямар тоног төхөөрөмж хэрэгтэй вэ?

**РОБЭРТ:** Сайн асуулт байна. Тэгэхээр надад илүү их хугацаа хэрэгтэй, гэхдээ зардал . . .

**КВАМЭ:** Энэ нь сайхан үйл ажиллагаа байлаа, тийм ээ? Яг л номлолдоо буцаж очсон юм шиг. Манай гагнуурын газрын дарга надад өөрийгөө хэрхэн бэлтгэгдсэн болон төлбөр нь хэд байсан талаар хэлж өгсөн. Дараа нь надад ажлын байран дээрх сургалтад хамрагдвал сайн гэж хэлсэн. Өөр нэгэн газар намайг шууд ажлын байран дээрх сургалтад хамруулна гэсэн ч, цалин өгөхгүй гэсэн. Тийм болохоор хэрэггүй байх. Бас цагдаагийн академи надад их таалагдсан. Би сургуульд нэг жил суралцаад, дараа нь аль нэгэн офицерыг нэг жил дагах юм байна лээ. Тийм учраас өртөг нь өндөр ч, цалин нь миний авч байсан хамгийн өндөр цалингаас дөрөв дахин их байх юм. Би сонголтдоо л хийх хэрэгтэй байна . . .

**КОНСУЭЛО:** За, эцэст нь би сонголтдоо хийх болох нь. Одоогийн байдлаар би хоёр ажил сонгосон байгаа. Гэхдээ бид үүн дээр гэр бүлээрээ хамтарч ажиллаж байгаа болохоор сайхан байсан. Би программ хангамжийн мэргэжилтэн юм уу, эмнэлгийн лабораторийн технологич болохын тулд ажиллана гэж бодож байгаа. Хоёулангийнх нь цалин ойролцоо ч, программ хангамжийн мэргэжилтэн болох нь манай гэр бүлийн хувьд дээр байх гэж бодож байна. Би нөхөртөө үргэлжлүүлэн тусална, бас сургууль нь ч гэсэн гурван сарын хугацаагаар бага юм байна.

**КВАМЭ:** За, цаг дууслаа. Бид ч ахиц гаргаж байна шүү!

10-р хуудас руу буцаж оч

## ҮЙЛДЭЛ БА АМЛАЛТ

Дүрүүдийг сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

**БҮЛГИЙН 1 ДЭХ ГИШҮҮН:** Бид амлалт өгч, түүнийгээ биелүүлэх ёстой гэдэгт итгэдэг. Манай бие даах чадвар олгох бүлгүүдэд бидний хийж буй бүх зүйл амлалт өгөх, тайлагнахад тулгуурладаг.

**БҮЛГИЙН 2 ДАХЬ ГИШҮҮН:** Бид бүлгийн цугларалтын төгсгөлд, долоо хоногт өөрсдийн хийх зүйлийнхээ талаар хэлэлцэж, амлалт өгснөө батлахаар гарын үсгээ зурдаг. Түүнчлэн бид “хамтрагчаа” сонгодог. Хамтрагч маань бидний дасгалын дэвтэр дээр гарын үсэг зурж, дэмжин туслах үүрэг хүлээдэг. Цугларалт хооронд, өдөр бүр бид хамтрагчтайгаа холбогдож, хийсэн ажлаа тайлагнаж, шаардлагатай үед тусламж авдаг.

**БҮЛГИЙН 3 ДАХЬ ГИШҮҮН:** Цугларалт хооронд, бид хийсэн ажлаа дасгалынхаа номон дээр тэмдэглэж, дасгалын хуудас эсвэл өөр маягууд гээд бидэнд тарааж өгсөн хэрэгслүүдийг ашигладаг. Нэмэлт тусламж хэрэгтэй бол бид гэр бүл, найз нөхөд эсвэл зохицуулагчдаа ханддаг.

**БҮЛГИЙН 4 ДЭХ ГИШҮҮН:** Дараагийн цугларалт эхлэхэд бид ирж, амлалтаа хэрхэн биелүүлснээ тайлагнана. Энэ нь хүн бүрийн хувьд таатай, хүчирхэг туршлага байх ёстой. Бүлгийн бүх ги-

шүүнийг тайлагнах үед тэд хэрхэн танд амлалт өгч, хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнахад тусалсан талаар бод.

**БҮЛГИЙН 1 ДЭХ ГИШҮҮН:** Эхлээд би өөрийн амлалтын талаар тайлагнахад надад “Ямар сонин юм бэ?” Манай бүлгийн гишүүдэд миний юу хийж байгаа нь яагаад чухал гэж? хэмээн бодогдсон. Харин дараа нь би тэд үнэхээр миний төлөө санаа тавьдаг болохыг олж мэдсэн. Энэ нь надад их тусалсан шүү.

**БҮЛГИЙН 2 ДАХЬ ГИШҮҮН:** Би бүлгийнхээ нэр төрийг унагаахыг хүсээгүй. Тийм болохоор би өгсөн амлалтаа биелүүлэхийн тулд их хичээл зүтгэл гаргасан. Би өөр арга замаар амжилт гаргахгүй байсан байх. Цугларалт болгоноор тайлагнах нь надад юу чухал болохыг мэдэж авахад тусалсан.

**БҮЛГИЙН 3 ДАХЬ ГИШҮҮН:** Бие даах чадвартай болох арга зам нь их чухал зүйл болохоор би бодохоос ч айж байсан. Гэвч бүлгийн цугларалтууд нь надад үүнийг жижиг жижиг алхмуудад хувааж өгч тусалсан юм. Би алхам болгоноо бүлгийнхэндээ тайлагнадаг байсан. Түүний дараа харин би бодит ахиц гаргаж эхэлсэн. Миний бодлоор би шинэ дадал хэвшилийг хөгжүүлснийхээ үр дүнд энэхүү амжилтад хүрсэн байх.

**17-р хуудас руу буцаж оч**

# 1: Ямар төрлийн ажил бие даахад маань туслах вэ?

## МИНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: ЯМАР АЖИЛ БИЕ ДААХАД МААНЬ ТУСЛАХ ВЭ?

Сонирхож байгаа гурван төрлийн ажлаа жагсаан бич.

--	--	--

## ЭНЭ ТӨРЛИЙН АЖЛЫН ТАЛААР ХЭН МЭДЭХ ВЭ?

Ажил бүрийн талаар уулзаж ярилцах 3-5 хүний нэрийг жагсаан бич.

--	--	--

## БИ ЭДГЭЭР ХҮНД ЯМАР ЯМАР АСУУЛТ ТАВИХ ВЭ?

Би энэ ажилд орохдоо эхлээд хэдэн төгрөгийн цалинтай байх вэ? Нэг жил ажилласны дараа миний цалин хэд болох вэ?

--	--	--

Би ажил тус бүрийн шаардлагыг хэрхэн хангах вэ?

--	--	--

Танай нутаг дэвсгэрт сургууль бий юу?

--	--	--

Энэ төрлийн ажлын эрэлт хэрэгцээ өсөж байгаа юу?

--	--	--

Энэ ажлыг эхлүүлэхэд зардал нь хэд байх вэ?

--	--	--

Бусад асуулт?

--	--	--

## ЯМАР АЖИЛ ХАМГИЙН САЙН ОРЛОГОТОЙ БӨГӨӨД МИНИЙ ХҮЧТЭЙ ТАЛ, УР ЧАДВАРТ ИЛҮҮ ТОХИРЧ БАЙНА ВЭ?

Би эдгээр сонголтын талаар юу олж мэдсэн бэ? Аль нь надад хамгийн сайн тохирч байна вэ?

--	--	--





## 2

*Ямар боловсрол  
миний ажлын  
шаардлагыг  
хангах вэ?*

---

**Илүү сайн ажлын төлөө сурч  
боловсрох нь**

# ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

## Цугларалт хийх өдөр:

- Бүлгийн гишүүд рүү мессеж илгээ, эсвэл утсаар ярь. Тэднийг 10 минутын өмнө ирж, амлалтаа хэрхэн биелүүлсэн талаар тайлагнахад урь.
- Цугларалтын үеэр ашиглах материалыг бэлд. Ном эсвэл видео бичлэг байхгүй бол та тэдгээрийг онлайнаар srs.lds.org вэбсайтаас авч болно.
- Өнгөрсөн долоо хоногт та бүлгийнхээ гишүүн бүрд Бие даах чадвар хөгжүүлэх төвийн Санал болгосон жагсаалтуудын хуулбарыг өгөөгүй бол, өнөөдөр тэдгээрийг өгөхөд бэлд. Жагсаалтыг гадасны бие даах чадвар хөгжүүлэх төвөөс болон бие даах чадвар хөгжүүлэх төвийн мэргэжилтнээс, эсвэл онлайнаар srs.lds.org/pef вэбсайтаас авна уу.

## Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойрхон суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
- Амлалтын энэ хүснэгтийг өөрийн бүлгийн гишүүдийн нэртэй самбар дээр зур (доорх жишээг үзнэ үү).

ШИНЭ!

Бүлгийн гишүүний нэр	Ажлынхаа талаар наад зах нь таван хүнтэй уулзаж ярилцсан (Тоог бич)	Ажлын төлөвлөгөөг танилцуулахад бэлтгэсэн (Тийм/Үгүй)	"Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил" товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)
Глория	8	T	T	T	T

## Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Хүмүүсийг орж ирэхэд дотно хүлээж авч угт.
- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд, тэднээс самбар дээрх амлалтын хүснэгтийг бөглөхийг хүс.
- Цаг бүртгэгч томил.

ШИНЭ!

## Цугларалт эхлэх үед:

ШИНЭ!

- Бүлгийн гишүүдийн холбоо барих мэдээллийн хувийг тарааж өг (өмнөх цугларалтын үеэр авсан).
- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Нээлтийн залбирал хий (хүсвэл дуулал дуулж болно).
- Бүлгийн хүмүүсийг ярилцаж байх хооронд, хоцорч ирсэн хүмүүсээс гар утсаа унтрааж, амлалтын хүснэгтээ бөглөхийг нам дуугаар хүс.
- "Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил" товхимол дээр ажиллахад 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- "Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил" товхимлын 2-р зарчмыг үзэж дуусга. Дараа нь энэ дасгалын номны дараагийн хуудаснаас үргэлжлүүлэн унш.





# ТАЙЛАГНА

## БИ АМЛАЛТАА БИЕЛҮҮЛСЭН ҮҮ?

**Цаг:** Зөвхөн энэ хуудсанд 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул (Тайлагна хэсэгт бүхэлд нь биш).

**Ярилц:** Баруун гар талд байгаа эшлэлийг унш. Энэ нь манай бүлэгт ямар хамаатай вэ?

**Дадлага хий:** Амлалтаа тайлагнацгаая. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлсэн хүмүүс босно уу. (Бүх амлалтаа биелүүлсэн хүмүүст зориулж алга таш.)

**Унш:** Одоо бүгдээрээ бос. Бид өгсөн бүх амлалтаа биелүүлэхийг хичээх ёстой. Энэ нь бие даасан хүмүүсийн эзэмших чухал дадал хэвшлийн нэг байдаг.

Бүгдээрээ зогсоод, уриагаа хамтдаа уншицгаая. Энэ уриа бидэнд бүлгийн зорилгыг сануулдаг болно.

**“Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө.”**


*Сургаал ба Гэрээ 104:15*

**Бид Их Эзэнд итгэх итгэлтэйгээр бие даахын тулд хамтран ажиллаж байна.**

**Унш:** Сууцгаая.

Одоо бүгдээрээ хамт зөвлөлдөж, нэг нэгнийхээ боловсролын болон илүү сайн ажилд орох төлөвлөгөөнд тусалцгаая. Энэ нь энэ цугларалтын хамгийн чухал хэлэлцүүлэг юм!

**Ярилц:** Энэ долоо хоногт та нар өгсөн амлалтаа биелүүлж байхдаа юу сурч мэдэж авсан бэ? Танд бүлгийн зүгээс тусалцаа хэрэгтэй байсан уу?



*“Гүйцэтгэлийг хэмжвэл, гүйцэтгэл сайжирдаг. Гүйцэтгэлийг хэмжиж, тайлагнаж байвал сайжрах хурд нэмэгддэг.”*

**ТОМАС С.МОНСОН,**  
Ерөнхий чуулганы  
тайлан, 1970 оны 10-р  
сар, 107

## БИ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ БЭЛДЭЖ СУУХДАА ЮУ ОЛЖ МЭДСЭН БЭ?

**Цаг:** Зөвхөн энэ хуудсанд 40 минут зарцуулахаар тооцож, цаг хэм-жигчийг тааруул.

**Унш:** Танилцуулга хэрхэн хийх талаар сануулах үүднээс энэ видео бичлэгийг үзэцгээе.

**Үз:** “Миний ажлын төлөвлөгөө гурван минутад” (Видео бичлэг байхгүй бол 22-р хуудсыг унш.)

**Дадлага хий:** ■Бүлгийн гишүүн бүр ажлын төлөвлөгөөгөө 3 минутаас бага хугацаанд багтаан, бүлгийнхэндээ танилцуулах ёстой.

Танилцуулгаа хийж дууссаны-хаа дараа санал хүсэлт байгаа эсэхийг асуу. Хүлээн авсан санал хүсэлтээ бичиж ав. Доор өгөгд-сөн зайд бичиж тэмдэглэ.

Бүх хүнд өгөгдсөн хугацаанд тайлагнах боломж олгох үүд-нээс санал хүсэлтээ цөөн үгээр илэрхийл.

**Ярилц:** Та шийдвэрт тань туслах ямар санаануудыг тайлангуудаас олж авсан бэ? Өөрт төрсөн бодлоо бич.

---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---

МИНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: ЯМАР АЖИЛ БИЕ ДААХАД МААНЬ ТУСЛАХ ВЭ?			
Сонирхож байгаа гурван төрлийн ажлаа жагсаан бич.			
ЭНЭ ТӨРЛИЙН АЖЛЫН ТАЛААР ХЭН МЭДЭХ ВЭ?			
Ажил бүрийн талаар уулзаж ярилцах 3-5 хүний нэрийг жагсаан бич.			
БИ ЭДГЭЭР ХҮНД ЯМАР ЯМАР АСУУЛТ ТАВИХ ВЭ?			
Би энэ ажилд орохдоо эхлээд хэдэн төгрөгийн цалинтай байх вэ? Нэг жил ажилласны дараа миний цалин хэд болох вэ?			
Би ажил тус бүрийн шаардлагыг хэрхэн хангах вэ?			
Танай нутаг дэвсгэрт сургууль бий юу?			
Энэ төрлийн ажлын эрэлт хэрэгцээ өсөж байгаа юу?			
Энэ ажлыг эхлүүлэхэд зардал нь хэд байх вэ?			
Бусад асуулт?			
ЯМАР АЖИЛ ХАМГИЙН САЙН ОРЛОГОТОЙ БӨГӨӨД МИНИЙ ХҮЧТЭЙ ТАЛ, УР ЧАДВАРТ ИЛҮҮ ТОХИРЧ БАЙНА ВЭ?			
Би эдгээр сонголтын талаар юу олж мэдсэн бэ? Аль нь надад хамгийн сайн тохирч байна вэ?			



# СУРАЛЦ

## МИНИЙ БОЛОВСРОЛЫН СОНГОЛТУУД ЮУ ВЭ?

**Цаг:** Суралц хэсэгт 30 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Унш:** Одоо бид ирээдүйн ажлынхаа талаар ойлголттой болсон байгаа. Энэ долоо хоногт бид уг ажлын шаардлагыг хангахуйц ур чадвартай болохын тулд ямар сургууль, эсвэл дадлага туршлага хэрэгтэй болох талаар ярилцана.

1 дэх долоо хоног	2 ДАХЬ ДОЛОО ХОНОГ	3 дахь долоо хоног	4 дэх долоо хоног	5 дахь долоо хоног	6 дахь долоо хоног
Ямар төрлийн ажил бие даахад маань туслах вэ?	Ямар боловсрол миний ажлын шаардлагыг хангах вэ?	Сургалтын төлбөрөө хэрхэн төлөх вэ?	Би Тасралтгүй Боловсролын Сангаас зээл авах хүсэлт гаргах хэрэгтэй юү?	Би ангид байхдаа хэрхэн амжилттай суралцах вэ?	Би ангиас гадуурх орчинд хэрхэн амжилтад хүрэх вэ?

**Дадлага хий:** Хэрэв өмнөх долоо хоногт зохицуулагч Бие даах чадвар хөгжүүлэх төвийн Санал болгосон жагсаалтуудыг өгөөгүй бол энэ удаа нэг хувийг бүлгийн гишүүн тус бүрд тарааж өгнө.

Самбар дээр бичих хоёр хүнийг сонго. Дараа нь бүгдээрээ танай нутаг дэвсгэрт орших сургууль ба сургалтын хөтөлбөрүүдийг хоёр минутад багтаан нэрлэ. Дараах зүйлсийг авч үз:

- Улсын ба хувийн их, дээд сургуулиуд
- Мэргэжлийн ба техник мэргэжлийн сургалтууд
- Ажлын байран дээрх буюу компани дээрх сургалт
- Санал болгосон сургууль, хөтөлбөрүүдийн жагсаалт дээрх хөтөлбөр, сургуулиуд

**Унш:** Ямар сонголт нь бидний ирээдүйн ажлын шаардлагыг хангах вэ? Бүх сургууль, хөтөлбөр адил биш гэдгийг ойлгох нь чухал. Тэд хугацаа, төлбөр, түвшингээрээ өөр өөр байдаг. Зарим нь төгсөгчдөдөө ажилд ороход нь тусалдаг. Харин зарим нь үр дүн муутай эсвэл төлбөр нь хэт үнэтэй байдаг.

**Үз:** “Сургууль эсвэл сургалтын хөтөлбөрийг сонгох нь” (Видео бичлэг байхгүй бол 38-р хуудсыг унш.)

**Ярилц:** Та зөв сургалтын хөтөлбөрийг хайж олохын тулд ямар ямар алхам хийх ёстой вэ?

**Унш:** Хэрэв бидэнд ТБС-ийн зээл хэрэгтэй бол бид сургууль, хөтөлбөрөө Санал болгосон сургууль, хөтөлбөрүүдийн жагсаалтаас сон-

## 2: Ямар боловсрол миний ажлын шаардлагыг хангах вэ?

гох хэрэгтэй болно. Эдгээр сургууль нь санал болгосон ажилд ороход хэрэгтэй ур чадварыг олгодог. Түүнчлэн тэд төгсөгчдөдөө тухайн ажлыг олж өгч тусалдаг. Та орон нутгийнхаа Бие даах чадвар хөгжүүлэх төвийн менежертэй холбоо барьж, жагсаалтад харгалзаж үзэх юм уу, нэмж оруулах хүсэлт гаргаж болно.

**Унш:** Энэ долоо хоногт бид дараах асуултыг тавьж, энэ үйлдлийг хийнэ:

**Унш:** ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН АСУУЛТ—Ямар боловсрол, эсвэл сургалт миний ажлын шаардлагыг хангах вэ?

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ—Боловсролын сонголтуудыг судалж, хөтөлбөрүүдийн талаар бусад хүнтэй уулзаж ярилцах замаар мэдэж аваад, сурч боловсрох төлөвлөгөөгөө гаргана.

## БИ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?

**Дадлага хий:** Бид долоо хоногийн турш “боловсролын төлөвлөгөө” боловсруулна (33-р хуудсыг үзнэ үү). Энэ дасгал нь танд үүнийг хэрхэн хийж болохыг алхам алхмаар зааж өгнө!

**1-р алхам.** Жишээнүүдийг унш. Дараа нь дадлага хийх зорилгоор “Таны жишээ” гэдгийн доор сонирхож байгаа сургуулийнхаа сонголтыг бич. Тухайн сонголтынхоо талаар уулзаж ярилцаж болох бүх хүний нэрийг жагсааж бич.

### МИНИЙ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: МИНИЙ БОЛОВСРОЛЫН СОНГОЛТУУД ЮУ ВЭ?

	1-р жишээ	2-р жишээ	Таны жишээ
Судалж байгаа хөтөлбөрүүд, эсвэл сургуулиудаа жагсааж бич.	Политехникийн Их Сургууль	Программ хангамжийн мэргэжил олгох төв	

### ХӨТӨЛБӨР ЭСВЭЛ СУРГУУЛИЙН ТАЛААР ХЭН МЭДЭХ ВЭ?

Хөтөлбөр эсвэл сургууль тус бүрийн талаар уулзаж ярилцах хүмүүсийн нэрийг жагсааж бич.	Аддо эгч тэнд ажилладаг. Сургуулийн зөвлөхүүд болон багш нар Миний найз София тэр сургуульд явж байсан Суралцагчид	Компьютерийн дэлгүүрийн залуу Молдона ах мэргэжлийн гэрчилгээтэй Мэргэжлийн гэрчилгээ олгох төвийн хэн нэгэн	
--	--	--	--

2-р алхам. Доорх асуулт, жишээнүүдийг унш. “Таны жишээ” хүснэгтийг бөглө. Энэ дасгалыг хийхэд та зарим зүйлийг тааж бичих хэрэгтэй болно.

БИ ЮУ АСУУХ ВЭ?			
	1-р жишээ	2-р жишээ	Таны жишээ
Сургуулийг хэдэн хүн төгсдөг вэ? Хэдэн хүн сайн ажилд ордог вэ?	Төгсөгчдийн 80% нь сургуулиа төгсөж, гэрчилгээгээ авдаг Ихэнх төгсөгч сайн ажилд ордог Ихэнх нь жилийн дотор менежер болж, тушаал дэвшсэн байдаг	60–65% нь гэрчилгээтэй төгсдөг Төгссөн бараг бүх хүн сайн ажилд ордог	
Тухайн хөтөлбөр эсвэл сургуульд хамрагдахын тулд юу хийх ёстой вэ?	Тэд жилд 100 хүнийг гагнуурын ангид авдаг бөгөөд математикийн ерөнхий мэдлэгийн шалгалтад тэнцсэн байх, мөн хоёр тодорхойлолттой байх	Математикийн шалгалтад тэнцсэн байх Төлбөрөө төлөх Зөөврийн компьютертэй байх	
Уг гэрчилгээг авах/төгсгөхөд ямар хугацаа шаардагдах вэ?	Мэргэжлийн гэрчилгээ авахад 18 сар Ажил дээрх сургалтад 6 сар (сургууль үүнийг зохион байгуулна, үнэ төлбөргүй)	Нэмээд мэргэжлийн гэрчилгээ олгох шалгалт өгөхөд 9 сар	
Нэг жилийн сургалтын төлбөр хэд вэ? Хөтөлбөрийн нийт төлбөр хэд вэ? Мэргэжлийн гэрчилгээ авахад ямар үнэтэй байдаг вэ?	Сургалтын төлбөр жилд 10000 Хөтөлбөрийн нийт төлбөр 15000 Мэргэжлийн гэрчилгээ багаж хэрэгслийн үнэ 8000 (нэмэлт)	15000/9 сар (Хөтөлбөрийн нийт төлбөр 15000) Мэргэжлийн гэрчилгээний батламж 5000 (нэмэлт)	
Тэтгэлэг болон мөнгөн тусламж байгаа юу? Мөнгөн тусламжийн талаар? Зээлийн талаар?	Сайн суралцагчдад сүүлийн 6 сар тэтгэлэг өгнө; мөнгөн тусламж байхгүй; зээлийн хүү өндөр	Үгүй	
Хичээлийн хуваарь ямар вэ? Унааны хувьд?	3 ээлжтэй (өглөө, өдөр, оройн) Автобусны буудалтай ойр; би 45 минут явж очно.	Өглөө, орой 2 удаа автобусанд сууж, нэг талдаа 1 цаг явна.	

## 2: Ямар боловсрол миний ажлын шаардлагыг хангах вэ?

**3-р алхам.** Одоо жишээнүүдийг уншаад, “Таны жишээ”-ний хариулыг баруун гар талд байгаа хүснэгтэд нэгтгэн дүгнэ. Энэ бол зөвхөн дадлага хийж байгаа гэдгийг мартаж болохгүй. Бид энэ долоо хоногт илүү үнэн зөв мэдээлэл цуглуулна.

### ЯМАР АЖИЛ ХАМГИЙН ӨНДӨР ЦАЛИНТАЙ БӨГӨӨД МИНИЙ ДАВУУ ТАЛ, УР ЧАДВАРТ ТОХИРЧ БАЙНА ВЭ?

	1-р жишээ	2-р жишээ	Таны жишээ
Би эдгээр сонголтын талаар юу олж мэдсэн бэ? Аль нь надад илүү тохирч байна вэ?	<i>Илүү урт хугацаатай, бага зэрэг өндөр төлбөртэй Төгсөгчдийн ажилд орсон үзүүлэлт сайн, тэтгэлэгтэй, цагийн хуваарь уян хатан Ажил олгогчидтой харилцаа холбоо сайтай</i>	<i>Арай бага хугацаатай Нийт зардал бага, шалгалтад унах магадлал өндөр Ажилд орсон үзүүлэлт маш сайн, нийтийн тээврийн унааны асуудал хэцүү</i>	

**Унш:** Бид энэ долоо хоногт мэдээлэл цуглуулсныхаа дараа шийдвэр гаргах ёстой. Бид тусламж авахын тулд залбирч, патриархын адислалаа уншиж болно. Бид зохистой бөгөөд үнэн сэтгэлээсээ хандвал, Ариун Сүнс биднийг удирдан залах болно. Их Эзэн биднийг адислахыг хүсдэг. Түүний тусламжийг эрэлхийлцгээе!

## БИ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ ХЭРХЭН ТАНИЛЦУУЛАХ ВЭ?

**Унш:** Дараагийн долоо хоногт бэлтгэх үүднээс боловсролын төлөвлөгөөний танилцуулга хэрхэн хийх дадлага хийцгээе.

**Дадлага хий:** Босож очоод, дадлага хийх шинэ хамтрагчаа олж суу. Боловсролын төлөвлөгөөг өөрийн юм шиг танилцуул (30-31-р хуудсыг үзнэ үү). Хэрэв танд бүх мэдээлэл байхгүй бол өөрөө ургуулан бодоод хий. Гурван минутад багтаан танилцуул. Дараа нь нөгөө хүнийхээ санал хүсэлтийг сонсоход хоёр минут зарцуул.

Дүрээ солилцоод, нөгөө хүнээрээ танилцуулах дадлага хийлгэ.

**Ярилц:** Үндсэн бүлэгтэйгээ эргэн нэгд. Та долоо хоногийн турш хэрхэн мэдээлэл цуглуулах, мөн дараагийн долоо хоногт боловсролын төлөвлөгөөгөө хэрхэн танилцуулах талаар ярилц. Асуулт тавьж, мэдээлэл солилц.

**Унш:** Долоо хоногийн туршид мэдээлэл цуглуулаад, энэ боловсролын төлөвлөгөөнд оруул. Боломжтой бүх хүнтэй уулзаж ярилц. Олон асуулт тавьж, тэмдэглэл дээрээ асуултуудыг нэмж оруул. Хэрэв танд боловсролын төлөвлөгөөний маягт хэрэгтэй бол 39-р хуудаснаас хувилж авч болно.

**МИНИЙ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: МИНИЙ БОЛОВСРОЛЫН СОНГОЛТУУД ЮУ ВЭ?**

Өөрийн судалж буй хөтөлбөр, сургуулийг жагсаан бич

**ХЭН ТУХАЙН СУРГУУЛЬ ЭСВЭЛ ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААР МЭДЭЖ БАЙГАА ВЭ?**

Сургууль эсвэл хөтөлбөр тус бүрийн талаар уулзаж ярилцах хүмүүсийн нэрийг жагсааж бич

**БИ ЮУ АСУУХ ВЭ?**

Хэдэн хүн тус сургууль, хөтөлбөрийг төгссөн бэ? Хэд нь сайн ажилд орсон бэ?

Тухайн сургууль эсвэл хөтөлбөрт хамрагдахад юу хэрэгтэй вэ?

Гэрчилгээ авах/төгсөхөд ямар хугацаа шаардагдах вэ?

Жилийн зардал хэд вэ? Сургалтын нийт төлбөр хэд вэ? Гэрчилгээ авах талаар?

Тэтгэлэг байгаа эсэх? Мөнгөн тусламжийн талаар? Зээлийн талаар?

Хичээлийн хуваарь нь ямар вэ? Унааны талаар?

**БИ АЛЬ СУРГУУЛИЙГ СОНГОХ ВЭ?**

Би эдгээр сонголтын талаар юу олж мэдсэн бэ? Аль нь надад хамгийн сайн тохирч байна вэ?



### БИ ТБС-ААС ЗЭЭЛ АВАХАД ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

Хэрэв танд сургуулийн, эсвэл сургалтын төлбөрөө төлөхөд тусламж хэрэгтэй бол таны гаргасан боловсролын төлөвлөгөө ТБС-аас зээл авахад тань мөн бэлтгэнэ. Хэрэв та ТБС-аас зээл авах хэрэгтэй гэж бодож байгаа бол боловсролын төлөвлөгөөгөө хийж байхдаа эдгээр асуултад хариулж, мэдээллийг өөрийн ТБС-ийн маягт бөглөхөд зориулан хадгал.

#### МИНИЙ СУРЧ БОЛОВСРОХ ТӨЛӨВЛӨГӨӨ: ЯМАР БОЛОВСРОЛ ЭСВЭЛ ДАДЛАГА ТУРШЛАГА МИНИЙ АЖЛЫН ШААРДЛАГЫГ ХАНГАХ ВЭ?

Сонгосон сургууль (БДЧХТ-ийн Санал болгосон сургууль, хөтөлбөрийн жагсаалтаас):

Мэргэжил буюу хөтөлбөр (БДЧХТ-ийн Санал болгосон сургууль, хөтөлбөрийн жагсаалтаас):

Санал болгосон ажлууд (БДЧХТ-ийн Санал болгосон ажлын жагсаалтаас):

Та зээл авах энэ хүсэлтийг гаргаад, хэзээнээс сургуулиа эхлэх вэ?

Төгсөхөөр төлөвлөсөн он, сар:

**Тайлбар:** Таны сонгосон сургууль эсвэл хөтөлбөр БДЧХТ-ийн Санал болгосон сургууль, хөтөлбөрийн жагсаалтад байхгүй байсан ч, та зээлд хамрагдах хүсэлтэй хэвээр байгаа бол Бие даах чадвар хөгжүүлэх төвийн менежертэй холбоо барина уу.



# ТУНГААН БОД

## БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

**Цаг:** Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр судар хуваалцаныг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

---

---

---

---

---

---

---

**Ярилц:** Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

*“Би чиний явах ёстой замд чамд зааварлан зааж өгнө. Би чамайг ширтэн, чамд зөвлөнө.”*

**ДУУЛАЛ 32:8**



# АМЛАЛТ ӨГ

## БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

**Цаг:** Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

---

*Хамтрагчийн нэр*

---

*Холбоо барих мэдээлэл*

**Амлалтаа нэг нэгээр нь хамтрагчдаа чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.**

### МИНИЙ АМЛАЛТУУД

**Би боловсролынхоо төлөвлөгөөнд зориулж наад зах нь таван хүнтэй уулзаж, мэдээлэл цуглуулна.**

Миний зорилго:      5      8      10

**Би боловсролынхоо төлөвлөгөөг танилцуулахад бэлдэнэ.**

Би өнөөдрийн “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

---

*Миний гарын үсэг*

---

*Хамтрагчийн гарын үсэг*

## БИ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

**Дадлага хий:** Дараагийн цугларалтын өмнө гаргаж буй ахицаа тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх хүснэгтэд “Тийм,” “Үгүй” гэж, эсвэл амлалтаа биелүүлсэн тохиолдлынхоо тоог бич.

Боловсролынхоо сонголтуудын талаар наад зах нь таван хүнтэй уулзаж ярилцсан (Тоог бич)	Боловсролын төлөвлөгөөний талаарх танилцуулгад бэлтгэсэн (Тийм/Үгүй)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)

**Унш:** Түүнчлэн “Миний бие даах чадвараа хөгжүүлэх арга зам” товхимлынхоо арын хуудсан дээр зарлагаа тэмдэглэхээ битгий мартаарай.

Бидний дараагийн цугларалтын үеэр зохицуулагч амлалтын хүснэгтийг самбар дээр зурна (дээрхтэй адил). Бид цугларалт эхлэхээс 10 минутын өмнө ирж, хүснэгт дээр өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажлыг бичнэ.

Дараагийн долоо хоногт “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын нэг сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. Түүнд даалгасан материалаас өөр нэмэлт материал авч ирэх хэрэггүй гэдгийг сануул. (“Миний суурь. зарчим, ур чадвар, дадал хэвшил” томхимлын сэдвээр хэрхэн зохицуулагч хийхээ мэдэхгүй байвал 17-р хуудсыг болон нүүр хуудасны дотор талыг унш.)

Хэн нэгнээс хаалтын залбирал хийж өгөхийг хүс.

### Санал хүсэлт

Санал хүсэлт, санаа бодол болон туршлагаа [srsfeedback@ldschurch.org](mailto:srsfeedback@ldschurch.org) хаягаар илгээнэ үү.

# Эх сурвалж

## СУРГУУЛЬ БА СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ СОНГОХ НЬ

Дүрүүдийг сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

**КВАМЭ:** За тэгэхээр, би оролдоод үзэх хэрэгтэй хоёр ч сайн ажлын талаар илүү их ойлголттой боллоо.

**КОНСУЭЛО:** Тэдгээр ажил нь бие даах чадвараа хөгжүүлэх зорилгодоо хүрэхэд тань тусалж чадах уу?

**КВАМЭ:** Тийм гэж бодож байна. Гэхдээ надад тэдгээр ажлын шаардлагыг хангах ур чадвар одоогоор байхгүй байна.

**МЭКАЛА:** Харин тийм. Би ч мөн адил нөхцөлд байна.

**РОБЭРТ:** Бид бүгдээрээ сайн боловсролтой юм уу, дадлага туршлагатай болох хэрэгтэй юм байна.

**КОНСУЭЛО:** Гэхдээ ийм олон сонгох сургуулийн алинд нь явах нь зүйтэй гэдгийг яаж мэдэх юм бэ? Төлбөрийн хувьд ч гэсэн хоорондоо их ялгаатай юм байна. За, тэгээд бид сайн гэдгийг нь яаж мэдэх вэ?

**КВАМЭ:** Манай тойргийн нэг залуу Нью Эйжид явдаг. Техник мэргэжлийн сургууль л даа. Би тийшээ явж магадгүй.

**МЭКАЛА:** Улсын их, дээд сургуулиудыг хамгийн сайн гэсэн зурагт хуудаснууд энд тэндгүй байхыг би харсан. Гэхдээ надад тийшээ явах боломж огт байгаагүй.

**РОБЭРТ:** Ажлын байран дээрх сургалтад хамрагдах, эсвэл ажил дээрээ суралцах боломж олдвол, дараа нь ажилд орох нь илүү хялбар байдаг гэж би сонссон.

**КОНСУЭЛО:** Тэгэхээр бүгдээрээ яаж олж мэдэх вэ?

**КВАМЭ:** Бүгдээрээ сургуулиудын хэн нэгэнтэй нь уулзаж ярилцах уу? Эсвэл тэр сургуулийг төгссөн хүмүүстэй ч юм уу?

**МЭКАЛА:** Тэр ч хэцүү байх аа. Би ч хүнтэй ярина гэхээр сандраад байдаг юм.

**РОБЭРТ:** Тэгсэн ч гэсэн ер нь бид асуусан нь дээр байх. Бүгдээрээ тэдэнтэй ярилцаж, суралцагчид нь сургуулиа төгсөж чаддаг эсэх, мөн тэд сайн ажилд орж чаддаг эсэхийг олж мэдэх хэрэгтэй. Төлбөр, тэтгэлэг гэх мэт санхүүгийн мэдээллийг яах вэ? Миний бодлоор бид тэдэнтэй ярилцах нь дээр. Бас тэр сургуульд явж байсан хүмүүстэй уулзах хэрэгтэй юм байна.

**КОНСУЭЛО:** Мэкала, би чамтай хамт явъя. Хамтдаа хийе.

**МЭКАЛА:** Тэгье!

**КВАМЭ:** Энэ ч бидний мөнгө төгрөг, ирээдүйтэй холбоотой чухал шийдвэр шүү. Бид бас залбирсан нь дээр байх. Эсвэл удирдамж авахын тулд адислал авдаг ч юм бил үү. Би номлолд байхдаа Их Эзэнээр удирдуулах боломжтой гэдгийг ойлгож авсан.

**МЭКАЛА:** Би ч гэсэн үүнд итгэдэг. Магадгүй, бидний итгэл энэ бүх зүйлийн томоохон хэсэг байж болох юм. Итгэл, найдвар ба бидний хичээл зүтгэл гээд. Тэнгэрлэг Эцэг биднийг энэ бүх зүйлээр дамжуулан адислах гэж байна гэсэн мэдрэмж надад төрлөө.

**РОБЭРТ:** Бүгдээрээ Санал болгосон сургууль, хөтөлбөрийн жагсаалтаа мартажгүй шүү. Санал болгосон ажлуудын шаардлагыг хангах хөтөлбөр, ур чадваруудын талаар хэрэгтэй санаанууд байдаг юм байна лээ. Магадгүй, бидэнд ТБС-ийн зээл хэрэгтэй юү, үгүй юү гэдгийг үүнийг хийж байж л мэдэх байх.

29-р хуудас руу буцаж оч.

**МИНИЙ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: МИНИЙ БОЛОВСРОЛЫН СОНГОЛТУУД ЮУ ВЭ?**

Өөрийн судалж буй хөтөлбөр, сургуулийг жагсаан бич

**ХЭН ТУХАЙН СУРГУУЛЬ ЭСВЭЛ ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААР МЭДЭЖ БАЙГАА ВЭ?**

Сургууль эсвэл хөтөлбөр тус бүрийн талаар уулзаж ярилцах хүмүүсийн нэрийг жагсааж бич

**БИ ЮУ АСУУХ ВЭ?**

Хэдэн хүн тус сургууль, хөтөлбөрийг төгссөн бэ? Хэд нь сайн ажилд орсон бэ?

Тухайн сургууль эсвэл хөтөлбөрт хамрагдахад юу хэрэгтэй вэ?

Гэрчилгээ авах/төгсөхөд ямар хугацаа шаардагдах вэ?

Жилийн зардал хэд вэ? Сургалтын нийт төлбөр хэд вэ? Гэрчилгээ авах талаар?

Тэтгэлэг байгаа эсэх? Мөнгөн тусламжийн талаар? Зээлийн талаар?

Хичээлийн хуваарь нь ямар вэ? Унааны талаар?

**БИ АЛЬ СУРГУУЛИЙГ СОНГОХ ВЭ?**

Би эдгээр сонголтын талаар юу олж мэдсэн бэ? Аль нь надад хамгийн сайн тохирч байна вэ?







# 3

*Би сургалтын  
төлбөрөө хэрхэн  
төлөх вэ?*

---

**Илүү сайн ажлын төлөө сурч  
боловсрох нь**

# ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

## Цугларалт хийх өдөр:

- Бүлгийн гишүүд рүү мессеж илгээ, эсвэл утсаар ярь. Тэднийг 10 минутын өмнө ирж, амлалтаа хэрхэн биелүүлсэн талаар тайлагнахад урь.
- Цугларалтын үеэр ашиглах материалуудыг бэлд.

## Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойрхон суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
- Энэ амлалтын хүснэгтийг самбар дээр зур.

Бүлгийн гишүүний нэр	Боловсролынхоо сонголтын талаар наад зах нь таван хүнтэй уулзаж ярилцсан (Тоог бич)	Боловсролын төлөвлөгөөгөө танилцуулахад бэлдсэн (Тийм/Үгүй)	"Миний суурь: зарчим, ур чадвар, дадал" товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгалам-жиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хадгалам-жиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)
Глория	7	T	T	T	T

## Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Хүмүүсийг орж ирэхэд дотно хүлээж авч угт.
- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд, тэднээс самбар дээрх амлалтын хүснэгтийг бөглөхийг хүс.
- Цаг бүртгэгч томил.

## Цугларалт эхлэх үед:

- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Нээлтийн залбирал хий (хүсвэл дуулал дуулж болно).
- Бүлгийн хүмүүсийг ярилцаж байх хооронд, хоцорч орж ирсэн хүмүүсээс гар утсаа унтрааж, амлалтын хүснэгтээ бөглөхийг нам дуугаар хүс.
- "Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил" товхимолд 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- "Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил" товхимлын 3-р зарчмыг үзэж дуусга. Дараа нь энэ дасгалын номны дараагийн хуудаснаас үргэлжлүүлэн унш.



# ТАЙЛАГНА

## БИ ӨГСӨН АМЛАЛТАА БИЕЛҮҮЛСЭН ҮҮ?

**Цаг:** Зөвхөн энэ хуудсанд 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул (Тайлагна хэсэгт бүхэлд нь биш).

**Дадлага хий:** Амлалтаа тайлагнацгаая. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлсэн хүмүүс босно уу. (Алга таш.)

**Унш:** Одоо бүгдээрээ бос. Бид өгсөн бүх амлалтаа биелүүлэхийг хичээх ёстой. Энэ бол бие даасан хүмүүсийн эзэмших чухал дадал хэвшлийн нэг болно. Бүгдээрээ бүлгийнхээ уриаг хамт уншицгаая.

**“Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө.”**

*Сургаал ба Гэрээ 104:15*

**Бид Их Эзэнд итгэх итгэлтэйгээр бие даахын тулд хамт ажиллаж байна.**

**Унш:** Сууцгаая.

**Ярилц:** Энэ долоо хоногт та нар өгсөн амлалтаа биелүүлж байхдаа юу сурч мэдэж авсан бэ? Танд бүлгийнхний зүгээс ямар нэгэн тусалцаа хэрэгтэй байсан уу?

## БИ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ БЭЛДЭЖ СУУХДАА ЮУ ОЛЖ МЭДСЭН БЭ?

**Цаг:** Зөвхөн энэ хуудсанд 40 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** ■Бүлгийн гишүүн бүр боловсролын төлөвлөгөөгөө 3 минутаас бага хугацаанд багтаан бүлгийнхэндээ танилцуулах ёстой.

Танилцуулгаа хийж дууссанаа дараа хүмүүсээс санал хүсэлт байгаа эсэхийг асуу. Хүмүүсийн өгсөн санал хүсэлтийг бичиж ав. Доор өгөгдсөн зайд бичиж тэмдэглэ.

Бүх хүнд өгөгдсөн хугацаанд тайлагнах боломж олгох үүднээс санал хүсэлтээ цөөн үгээр илэрхийл.

**Ярилц:** Та шийдвэрт тань туслах ямар ямар санааг тайлангуудаас олж авсан бэ? Өөрт төрсөн бодлыг доор бич.

---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---



---

МИНИЙ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: МИНИЙ БОЛОВСРОЛЫН СОНГОЛТУУД ЮУ ВЭ?			
Өөрийн судалж буй хөтөлбөр, сургуулийг жагсаан бич			
ХЭН ТУХАЙН СУРГУУЛЬ ЭСВЭЛ ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААР МЭДЭЖ БАЙГАА ВЭ?			
Сургууль эсвэл хөтөлбөр тус бүрийн талаар уулзаж ярилцах хүмүүсийн нэрийг жагсааж бич			
БИ ЮУ АСУУХ ВЭ?			
Хэдэн хүн тус сургууль, хөтөлбөрийг төгссөн бэ? Хэд нь сайн ажилд орсон бэ?			
Тухайн сургууль эсвэл хөтөлбөрт хамрагдахад юу хэрэгтэй вэ?			
Гэрчилгээ авах/төгсөхөд ямар хугацаа шаардагдах вэ?			
Жилийн зардал хэд вэ? Сургалтын нийт төлбөр хэд вэ? Гэрчилгээ авах талаар?			
Тэтгэлэг байгаа эсэх? Мөнгөн тусламжийн талаар? Эзэгийн талаар?			
Хичээлийн хуваарь нь ямар вэ? Унааны талаар?			
БИ АЛЬ СУРГУУЛИЙГ СОНГОХ ВЭ?			
Би эдгээр сонголтын талаар юу олж мэдсэн бэ? Аль нь надад хамгийн сайн тохирч байна вэ?			



# СУРАЛЦ

## БИ СУРГАЛТЫН ТӨЛБӨРӨӨ ХЭРХЭН ТӨЛӨХ ВЭ?

**Цаг:** Суралц хэсэгт 30 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Унш:** Одоо бид ирээдүйн ажлынхаа шаардлагыг хангахад ямар боловсрол, эсвэл дадлага туршлага хэрэг болох талаар илүү сайн ойлголттой болсон байна. Одоо бид сургалтын төлбөр хэд байх, мөн төлбөрөө хэрхэн төлөхөө шийдэх боломжтой. Хувийн хадгаламж, гэр бүлийн туслалцаа, тэтгэлэг, зээл гээд олон боломж, эх сурвалж бий.

1 дэх долоо хоног	2 дахь долоо хоног	3 ДАХЬ ДОЛОО ХОНОГ	4 дэх долоо хоног	5 дахь долоо хоног	6 дахь долоо хоног
Ямар төрлийн ажил бие даахад маань туслах вэ?	Ямар боловсрол миний ажлын шаардлагыг хангах вэ?	Сургалтын төлбөрөө хэрхэн төлөх вэ?	Би Тасралтгүй Боловсролын Сангаас зээл авах хүсэлт гаргах хэрэгтэй юү?	Би ангид байхдаа хэрхэн амжилттай суралцах вэ?	Би ангиас гадуурх орчинд хэрхэн амжилтад хүрэх вэ?

**Үз:** “Сургалтын төлбөрөө төлөх нь” (Видео бичлэг байхгүй бол 54-р хуудсыг унш.)

**Унш:** Энэ долоо хоногт бид энэ асуултын хариултыг олох бөгөөд дараах үйлдлийг хийнэ:

**Унш:** **ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН АСУУЛТ—Сургалтын төлбөрөө хэрхэн төлөх вэ?**

**ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ—Би сонирхож буй сургалтын хөтөлбөрийнхөө төлбөрт хэдэн төгрөг төлөх хэрэгтэйг олж мэдэн, ямар арга замаар төлөх талаар судалж, санхүүгийн төлөвлөгөө боловсруулна.**

**Унш:** Бид сургалтын төлбөрөө төлөх мөнгөний талаар нэлээн бодох болно. Энэ нь эхлээд таатай санагдахгүй байж болох ч, бидэнд санхүүгээ ухаалаг төлөвлөж, шаардлагатай боловсролоо олж авахад маань тусална.

**Ярилц:** Баруун гар талд байгаа судрыг унш. Бүлгээрээ судрын зарчмыг ярилц. Та эдгээр зарчмыг ойлгосныхоо дараа мөнгөний талаар юу гэж бодож байна вэ?

“Харин та нар баялгуудыг эрэлхийлэхийн өмнө, Бурханы хаант улсыг эрэлхийлэгтүн та нар. Мөн та нар Христэд найдах найдварыг олсныхоо дараа хэрэв та нар тэдгээрийг эрэлхийлэх аваас, та нар баялгуудыг олох болно; мөн та нар тэдгээрийг сайныг үйлдэх зорилгын төлөө эрэлхийлэх болно---нүцгэнийг хувцаслахад, мөн өлссөнийг хооллоход, бас боолчлогдсоныг чөлөөлөхөд, мөн өвдсөн бас зовсныг халамжлахад буюу.”

ИАКОВ 2:18-19

## БИ ЗАРЛАГАА ХЭРХЭН УРЬДЧИЛАН ТООЦООЛОХ ВЭ?

**Дадлага хий:** Дараагийн жишээг чанга уншаад, хэрхэн тооцоо хийхээ ярилц.

Мануэл хөргөлтийн мэргэжилтэн болохоор төлөвлөж байна. Энэ ажил нь тухайн нутаг дэвсгэрт эрэлт хэрэгцээтэй байгаа юм. Энэ нь Санал болгосон ажлын жагсаалтад орсон байна. Тэр эхнэр Элизабеттайгаа Санал болгосон сургууль, хөтөлбөрийн жагсаалтаас хөтөлбөр, сургуулиа сонгосон ч төлбөрөө хэрхэн төлөхөө сайн мэдэхгүй байв. Тэд санхүүгээ хамтдаа эмхлэн цэгцэлсэн байна. Тэд зарлага, орлогоо тэмдэглэж, “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимол дээр сар тутмын орлого, зарлагынхаа мэдээллийг оруулсан байна. Тэд эдгээр зүйлийг олж мэдсэн байна:

САРЫН ОРЛОГО		САРЫН ЗАРЛАГА	
Ажлаас орж ирсэн орлого	1450	Аравны нэг ба бусад өргөл	170
Гэр бүлийнхний хандив	100	Түрээс	550
Бусад орлого (сараар)	100	Хоол хүнс	450
<b>“А” Сарын нийт орлого</b>	<b>1650</b>	Унаа	200
		Ус, цахилгаан, утас	230
		<b>“Б” Сарын нийт зарлага</b>	<b>1600</b>

Тэд сар тутам сургалтын төлбөрт хэдэн төгрөг төлж чадахаа тооцоолсон байна: **“А” Сарын нийт орлого - “Б” Сарын нийт зарлага = “В” эсвэл 50.**

Дараа нь тэд жилд хэдэн төгрөг төлөх боломжтой болохоор тооцоолсон байна: **“В” (50) x 12 (сар) = “Г” (600).** Тэд нийтдээ нэг жилд **“Г” (600)**-г сургалтынхаа төлбөрт төлж чадна.

Дараа нь тэдний боловсролын зардал **“Д”** хэд байхыг тооцоолсон байна.

Эцэст нь тэд одоогийн байдлаар төлөх боломжгүй байгаа төлбөр буюу **“Е”**-г тооцоолж гаргасан байна.

Тэд энэ мөнгийг өөр нэг ажил хийж, зээл авч, эсвэл өөр ямар нэгэн аргаар төлөх хэрэгтэй юм.

БОЛОВСРОЛЫН ЗАРДАЛ (нэг жилийн)	ТЕХНИКИЙН ИХ СУРГУУЛЬ
Сургалтын төлбөр	9800
Шалгалт ба төлбөрүүдийг нэм	<b>+500</b>
Ном ба бусад хэрэгслийг нэм	<b>+1200</b>
Тэтгэлэг хасах	<b>-1150</b>
<b>“Д” Миний боловсролын зардал</b>	<b>=10350</b>
<b>“Г” Бидний төлж чадах мөнгөн дүн</b>	<b>-600</b>
<b>“Е” Бидний төлж чадахгүй мөнгөн дүн</b>	<b>=9750</b>

**Ярилц:** Мануэл, Элизабет хоёр сургуулийн эхний жилийн төлбөрт 9750-ийг нэмж төлөх хэрэгтэй. Та нар тэдний хэрхэн тооцоолж гаргасныг олж харав уу? Та нарт байгаа аливаа асуултыг хамтдаа ярилц.

## МИНИЙ ОРЛОГО ХЭД ВЭ? МИНИЙ ЗАРЛАГА ХЭД ВЭ?

**Унш:** Тэгэхээр цөмөөрөө боловсролынхоо санхүүгийн төлөвлөгөөг боловсруулцгаая.

**Дадлага хий:** Хэдэн минут гаргаж, энэ маягтыг бие даан бөглө. Өөртөө шударга бай. Та харандаа ашиглаж болно. Дараа нь долоо хоногийн турш гэр бүлийнхэнтэйгээ хамтран ажиллаж, үүнийг илүү үнэн зөв болго. Одоогийн байдлаар тоог өөрийн мэдэхээр баримжаалан тооцоол.

*"Миний бие даах чадвартай болох арга зам" товхимлын арын хуудсан дээр тэмдэглэсэн тоог ашигла.*

САРЫН ОРЛОГО (гэрлэсэн бол эхнэр, нөхрийн орлого)	
Ажлаас орж ирсэн орлого	
Боловсролын зардалд оруулах гэр бүлийн хандив	
Бусад орлого	
Бусад орлого	
<b>"А" Сарын нийт орлого</b>	

Та орлого, зарлагаа бөглөснийхөө дараа сар болгон боловсролын зардалд хэдэн төгрөг төлж чадахаа тооцоолж гарга.

**"А" Сарын нийт орлого - "Б" Сарын нийт зарлага = "В"** \_\_\_\_\_.

Хэрэв **"В"** 0 эсвэл түүнээс бага байвал, танд боловсролын зардалд илүүчлэх мөнгө байхгүй гэсэн үг.

Хэрэв **"В"** 0-оос их байвал, дараа нь та жилд хэдэн төгрөг төлж чадахаа тооцоол:

**"В"** \_\_\_\_\_ x 12 сар (сар) = **"Г"** \_\_\_\_\_.

**"Г"** нь жил болгон боловсролын зардалд **таны нийт төлж чадах** мөнгөн дүн юм.

САРЫН ЗАРЛАГА	
Аравны нэг ба бусад өргөл	
Хадгаламж	
Хоол хүнс	
Орон сууц	
Ус	
Эмчилгээний зардал	
Унаа	
Боловсролын зардал	
Өр зээлийн төлбөр	
Хувцас	
Цахилгаан	
Утас	
Бусад	
<b>"Б" Сарын нийт зарлага</b>	



## МИНИЙ БОЛОВСРОЛЫН ЗАРДАЛД ЮУ ЮУ ОРОХ ВЭ?

**Унш:** Одоо бүгдээрээ боловсролын зардлаа авч үзье.

**Дадлага хий:** Эдгээр хоосон зайг бөглөж, тооцоо хий. Харандаа хэрэглэ. Хэрэв та нэг тодорхой хөтөлбөрийг сонгосон бол нэг баганыг бөглө. Хэрэв та хоёр юм уу гурван хөтөлбөр сонгосон бол тэдгээр баганыг бөглөөд, хооронд нь харьцуул. Тусламж хэрэгтэй бол нэг нэгэнтэйгээ, эсвэл зохицуулагчтайгаа хамтарч ажил.

Энэ жишээ нь нэг жилийг хамарсан болно. Таны хөтөлбөрийн хугацаа богино бол барагцаалсан тооцоогоо хугацаандаа тохируул. Танд БДЧХТ-ийн Санал болгосон сургууль, хөтөлбөрийн жагсаалт болон боловсролын төлөвлөгөөн дээрх мэдээлэл тусална.

МИНИЙ БОЛОВСРОЛЫН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (нэг жилийн)	Жишээ Рентгений эмч	1 дэх хө- төлбөр	2 дахь хө- төлбөр	3 дахь хө- төлбөр
Сургалтын төлбөр (нэг жилийн)	12000			
Шалгалтын болон бусад төлбөр (элсэлт, лиценз, гэрчилгээ, төгсөлтийн шалгалтын болон бусад төлбөр—нэг жилийн) <b>НЭМ</b>	+2000	+	+	+
Ном, хэрэгслүүдийг (нэг жилийн) <b>НЭМ</b>	+1000	+	+	+
Тэтгэлэг эсвэл мөнгөн тусламж (байвал—нэг жилийн) <b>ХАСАХ</b>	-1000	-	-	-
<b>"Д" Миний боловсролын зардлууд (нэг жилийн)</b>	= 14000	=	=	=
<b>"Г" Бидний төлж чадах мөнгөн дүн (нэг жилийн)</b>	-1000	-	-	-
<b>"Е" Төлөх мөнгөн дүн</b>	= 13000	=	=	=

## БИ БОЛОВСРОЛЫН ЗАРДЛЫНХАА ХЭДИЙГ НЬ ТӨЛЖ ЧАДАХ ВЭ?

**Дадлага хий:** Дээрх хүснэгтийн доод мөрийг хар.

Хэрэв "Е" нь 0 эсвэл түүнээс бага байвал, та өөрийн боловсролын бүх зардлыг төлж чадна гэсэн үг. Танд баяр хүргэе!

Хэрэв "Е" нь 0-оос их байвал та тэр хэмжээний мөнгөн дүнг төлөх арга олох хэрэгтэй гэсэн үг. Та шаардлагатай байгаа мөнгөө тэтгэлэгт хамрагдаж, нэмэлт ажил хийж, эсвэл зээл авч төлж болно.

## ХЭРЭВ БИ ӨӨРӨӨ ТӨЛЖ ЧАДАХГҮЙ БОЛ ӨӨР ЯМАР ЯМАР БОЛОМЖ НАДАД БАЙГАА ВЭ?

**Унш:** Бид ямар нэгэн золилол гаргаж байгаад ч гэсэн, өөрсдийн боловсролын зардлыг төлж чадвал сайн. Хэрэв бидний тооцоо боловсролын зардлаа төлж чадахгүй гэдгийг харуулбал бид өөр эх сурвалж руу хандана.

**Ярилц:** Бүлгээрээ энэ хүснэгтийн хэсэг бүрийг ээлжлэн унш. Сонголт бүрийг ярилц. Аль нь танд хамгийн тохиромжтой байна вэ?

САНХҮҮГИЙН БОЛОМЖУУД	ДАВУУ ТАЛУУД	СУЛ ТАЛУУД
<b>Сургуульд явах хугацаандаа дахиад нэг ажилд орох</b>	Өрөнд орохгүй, эсвэл хүү төлөхгүй. Ур чадварт суралцана, эсвэл түүнийг сайжруулна. Чухал харилцаа холбоо тогтооно.	Хоёр ажилд зэрэг ажиллахын хажуугаар хичээл сургуульдаа амжилт гаргах нь хэцүү байж магадгүй. Гэр бүлд хэцүү байж магадгүй. Хөтөлбөрөө дуусгахад илүү урт хугацаа шаардагдаж магадгүй.
<b>Гэр бүлийнхнээсээ авах</b>	Таньж мэддэг, итгэдэг хүмүүсээ зээлдэнэ. Тэд таныг амжилтад хүрээсэй гэж хүсдэг.	Гэр бүлийн харилцааг хөндийрүүлж магадгүй. Гэр бүлд гэнэтийн асуудал гарвал хэцүү байдалд орж магадгүй.
<b>Тэтгэлэг болон буцалтгүй тусламж олох</b>	Өрөнд орохгүй, хүү төлөхгүй. Өөр ажилд оролгүй чөлөөтэй суралцах боломж олгоно.	Олоход хэцүү байж магадгүй. Гэхдээ хичээгээд үзэх хэрэгтэй!
<b>Цалинтай ажлын байран дээрх сургалт юм уу, цалинтай дадлага хийлгэх газар олох</b>	Боловсролтойгоо холбоотой ур чадварт суралцана. Туршлагатай болно. Цаашид ажилд авч магадгүй.	Ажиллаж, суралцахын хажуугаар ажлын байран дээрх сургалтад хамрагдах нь хүндрэлтэй байж магадгүй.
<b>Банкнаас эсвэл төрийн байгууллагаас зээл авах</b>	Банкинд зээлийн түүхтэй болно. Засгийн газрын зарим зээлийн хүү бага байдаг.	Зээлийн хүү өндөр байх магадлалтай. Зээлсэн учраас буцааж төлөх хэрэгтэй.
<b>Тасралтгүй Боловсролын Сангийн (ТБС) зээлд хамрагдах хүсэлт гаргах</b>	Зохистой Сүмийн гишүүд авах боломжтой. Зээлийн хүү бага. Зээлийн эргэн төлөхөд туслах гүйцэтгэлийн урамшууллын системтэй.	Энэ нь зээл учраас буцааж төлөх шаардлагатай (бусад хүнд зээл авах боломж олгохын тулд).

**Ярилц:** Та төлбөр, чанар зэргийг судалж, хамгийн сайн сургуулийг олж чадсан уу?

Хэрэв та зээл авах сонирхолтой байвал зээлээ эргүүлэн төлж чадах уу? Зарчмын хувьд, боловсролынхоо хөтөлбөрт хамрагдаж, төгссөний дараах зээлийн төлбөр тань таны сарын орлогын 10 хувиас илүү гарсан байх ёсгүй.

Хэрэв танд боловсролын зардлын талаар нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол хэн таны асуултад хариулж өгч туслах вэ? Та гэр бүлийнхэнтэйгээ энэ талаар ярилцах уу? Та нэмэлт мэдээллийг өөр хаанаас авч болох вэ?

## БИ БОЛОВСРОЛЫН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ ХЭРХЭН ТАНИЛЦУУЛАХ ВЭ?

**Дадлага хий:** Дараагийн долоо хоногт та өөрийн санхүүгийн төлөвлөгөөг гурав эсвэл түүнээс бага минутад багтаан танилцуулна. Та доорх үгийг ашиглаж болно. Та хувийнхаа нууц мэдээллийг хуваалцах шаардлагагүй. Дараагийн долоо хоногт таныг танилцуулгаа өгсний дараа, бүлгээрээ Тасралтгүй Боловсролын Сангийн зээл гэсэн санхүүгийн өөр нэгэн боломжийг судална.

Долоо хоногийн турш, эдгээр хоосон зайг бөглөх хариултыг олж ав. Гэр бүлийнхэндээ юм уу, бусдад танилцуулга өгч, дадлага хий:

### МИНИЙ БОЛОВСРОЛЫН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Би \_\_\_\_\_ (тоо) сургуулийн үнэ, чанарыг хооронд нь харьцуулсан.
2. Миний хувьд хамгийн сайн гурван сургууль бол:  
\_\_\_\_\_.
3. Одоогийн байдлаар, би \_\_\_\_\_ сургуулийг хамгийн сайн хувилбар гэж бодож байна. Учир нь \_\_\_\_\_.
4. Би өөрийн орлого, зарлагыг гэр бүлийнхэнтэйгээ хамт тооцоолсон. Би эдгээр зүйлийг сурсан:  
\_\_\_\_\_.
5. Би сургалтынхаа төлбөрийг өөрөө төлөх боломжтой эсэхээ тооцоолж үзсэн бөгөөд би (чадна, чадахгүй) гэдгээ олж мэдсэн.  
(Хэрэв өөрөө төлөх боломжтой бол 9-ийг алгас; чадахгүй бол 6 руу оч.)
6. Би сургуулийнхаа эхний жилд өөр ажил, тэтгэлэг, гэр бүлийн тусламж эсвэл зээл маягаар нэмэлт \_\_\_\_\_ (мөнгөн дүн) олох хэрэгтэй.
7. Би энэ эхний жилийн дараах \_\_\_\_\_ жилд сургалтынхаа төлбөрт нэмж \_\_\_\_\_ (мөнгөн дүн) олох хэрэгтэй.
8. Би сургалтынхаа төлбөрийг төлөх өөр боломжуудыг судалж эхэлсэн. Одоогийн байдлаар миний сонирхож байгаа боломж бол \_\_\_\_\_.
9. (Хэрэв та хуваалцахыг хүсвэл) Би өөрийн боловсрол ба санхүүгийн төлөвлөгөөний талаар залбирсан бөгөөд  
\_\_\_\_\_.
10. Надад та нарын зөвлөгөө, тусламж хэрэгтэй байна. Та нарт надад санал болгох зүйл байна уу? Санаагаа энд бич.  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_



# ТУНГААН БОД

## БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

**Цаг:** Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр судар хуваалцаныг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

---

---

---

---

---

---

**Ярилц:** Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

*“Та нарын хичээл зүтгэл, итгэлтэй байдал мөн итгэлийн залбирлуудаар дамжин бүх ялалт хийгээд алдар суу та нарт тохиохоор авчрагддаг болой.”*

**СУРГААЛ БА ГЭРЭЭ**  
**103:36**

### 3: Би сургалтын төлбөрөө хэрхэн төлөх вэ?



## АМЛАЛТ ӨГ

### БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

**Цаг:** Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

---

*Хамтрагчийн нэр*

---

*Холбоо барих мэдээлэл*

**Амлалтаа нэг нэгээр нь хамтрагчдаа чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.**

#### МИНИЙ АМЛАЛТУУД

**Би гэр бүлийнхэнтэйгээ хамтарч, өөрийн орлого ба амьжиргааныхаа зардлыг үнэн зөв жагсааж бичнэ.**

**Би өөрийн боловсролын зардлыг тэмдэглэж, тэтгэлэг, мөнгөн тэтгэмж, зээл, өөр бусад санхүүгийн боломжийн талаар олж мэднэ.**

**Би санхүүгийн төлөвлөгөөгөө танилцуулахад бэлтгэнэ.**

Би өнөөдрийн "Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил" товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

---

*Миний гарын үсэг*

---

*Хамтрагчийн гарын үсэг*

## БИ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

**Дадлага хий:** Дараагийн цугларалтын өмнө гаргаж буй ахицаа тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх хүснэгтэд “Тийм,” “Үгүй” гэж, эсвэл амлалтаа биелүүлсэн тохиолдлынхоо тоог бич.

Гэр бүлийн-хэнтэйгээ хамтарч орлого, зарлагаа жагсааж бичсэн (Тийм/Үгүй)	Боловсролын зардлаа тэмдэглэсэн; санхүүгийн боломжуудыг судалсан (Тийм/Үгүй)	Санхүүгийн төлөвлөгөөний танилцуулгад бэлтгэсэн (Тийм/Үгүй)	“Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил,” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)

**Унш:** Үүнээс гадна, өөрийн хувийн зардлыг “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлын ар талд тэмдэглэхээ битгий мартаарай.

Дараагийн долоо хоногт “Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимлын нэг сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. (“Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимлын сэдвээр хэрхэн зохицуулагч хийхээ мэдэхгүй байна уу? 17-р хуудсыг болон хавтасны нүүр хуудасны дотор талыг уншина уу).

Хэн нэгнээс хаалтын залбирал хийж өгөхийг хүс.

### Санал хүсэлт

Санал, сэтгэгдэл, санаа бодол болон туршлагаа [srsfeedback@ldschurch.org](mailto:srsfeedback@ldschurch.org) хаягаар илгээнэ үү.

### Зохицуулагчийн анхааралд:

Дараагийн цугларалтын өмнө өөрийн улс орон дахь ТБС-ийн зээлийн төлбөрийн зааварчилгааг бэлд. Дараагийн цугларалтад зааварчилгааны хуулбарыг бүлгийн гишүүн бүрд зориулан авч ир.

# Эх сурвалж

## СУРГАЛТЫН ТӨЛБӨРӨӨ ТӨЛӨХ НЬ

Дүрүүдийг сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

**МЭКАЛА:** Ямар гоё байсан гээч. Энэ долоо хоногт би олон сургуулийн талаар их зүйл сурч авлаа.

**КОНСУЭЛО:** Та нар түүнийг харах байсан юм. Тэр шууд явж очин, энэ бүх хүнтэй ярьсан гээч. Би ч түүнийг гүйцэхгүй байсан шүү.

**РОБЭРТ:** Эцсийн сонголтоо хийсэн үү?

**МЭКАЛА:** Үгүй, гэхдээ хоёр сонголт болгож цөөрүүлсэн.

**КОНСУЭЛО:** Би ч гэсэн гурван сайн сонголт болгон багасгасан байгаа.

**КВАМЭ:** Залуус аа, сайн байна. Би харин ямар ч сонголт хийж чадаагүй.

**РОБЭРТ:** Юу гэсэн үг вэ?

**КВАМЭ:** Аан, би бага зэрэг будилсан хэвээр. Эсвэл айсан ч байж магадгүй. Манай гэр бүлээс хэн ч дунд боловсролоос дээш, их дээд сургуульд орж сурч байгаагүй. Би таван өөр сургуультай уулзаж ярилцсан бөгөөд надад давж гарахгүй мэт мэдрэмж төрсөн. Шаардлагууд нь хэцүү, бас үнийн хувьд ч гэсэн. . . Би лав хаанаас ч тийм их мөнгө олж чадахгүй юм байна лээ.

**РОБЭРТ:** Номлолд явахын өмнө чамд бас яг тийм мэдрэмж төрж байсан биз дээ?

**КВАМЭ:** Эргэж харахад тийм ч юм уу даа. Надад төрж байсан юм байна.

**КОНСУЭЛО:** Гэхдээ чи маш амжилттай байсан шүү дээ.

**КВАМЭ:** Нэг хэсэг хэцүү байсан л даа, гэхдээ би үнэхээр их адислагдсан шүү. Би өөрчлөгдөж чадсан.

**МЭКАЛА:** Би ч гэсэн айж л байна. Санхүүгийн хувьд боломжгүй юм шиг санагдсан. Гэхдээ би өөрийн талаас чадах бүхнээ хийчихээд, үлдсэн төлбөрөө зээл авч төлсөн тойргийнхоо нэг эгчтэй ярьсан. Тэр зээл нь ТБС-ийн зээл байсан юм байна лээ. Бид нэг нэгнээ үргэлжлүүлэн дэмжиж байхад бүх юмны учир олдох байлгүй дээ.

**РОБЭРТ:** Манай тойрогт эхний жилийнхээ төлбөрийг өөрөө төлөөд, хоёр дахь жилээсээ тэтгэлэгт хамрагдаж чадсан нэг ах байдаг.

**КОНСУЭЛО:** Нөхөр бид хоёр мөнгө хуримтлуулах гэж хичээж байгаа, бас авга ах маань ч гэсэн тусалж магадгүй.

**КВАМЭ:** За даа, манай гэр бүлд ч баян авга ах нар байхгүй л дээ. Гэхдээ бид ямар ч байсан энд ирчихлээ. Би ч мөрөөдлөө орчихгүй ээ. Мэкала, чиний зөв байж магадгүй. Хэрэв та нар намайг үргэлжлүүлэн урамшуулан дэмжих юм бол би дахиад хэдэн долоо хоног үзээд алдъя гэж бодож байна.

45-р хуудас руу буцаж оч





# 4

*Би Тасралтгүй  
Боловсролын Сангаас  
зээл авах хүсэлт  
гаргах хэрэгтэй юү?*

---

**Илүү сайн ажлын төлөө сурч  
боловсрох нь**

# ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

## Цугларалт хийх өдөр:

- Бүлгийн гишүүд рүү мессеж илгээ, эсвэл утсаар ярь. Тэднийг 10 минутын өмнө ирж, амлалтаа хэрхэн биелүүлсэн талаар тайлагнахад урь.
- Цугларалтын үеэр ашиглах материалуудыг бэлд.
- Гадасны бие даах чадвар хөгжүүлэх төвөөс ТБС-ийн товхимлын хувийг бүлгийн гишүүн бүрд зориулж ав. Тэдгээрийг өнөөдрийнхөө цугларалтад авч ир.
- Танай улсын ТБС-ийн зээлийн төлбөрийг хийх зааварчилгааг (гадасны бие даах чадвар хөгжүүлэх төвд, эсвэл онлайнгаар [srs.lids.org/ref](http://srs.lids.org/ref) вэбсайт дээр байгаа) авч ир. Бүлгийн гишүүн бүрд зориулж нэг хувийг хувилж ир.

ШИНЭ!

ШИНЭ!

## Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойрхон суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
- Энэ амлалтын хүснэгтийг самбар дээр зур.

Бүлгийн гишүүний нэр	Гэр бүлийн хэнтэйгээ хамтарч орлого, зарлагаа тэмдэглэсэн (Тийм/Үгүй)	Боловсролын зардлаа тэмдэглэсэн бөгөөд санхүүгийн боломжуудыг судалсан (Тийм/Үгүй)	Санхүүгийн төлөвлөгөөг танилцуулахад бэлдсэн (Тийм/Үгүй)	"Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил," дээрх зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамт-рагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)
Глория	Т	Т	Т	Т	Т	Т

## Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Хүмүүсийг орж ирэхэд дотно хүлээж авч угт.
- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд, тэднээс самбар дээрх амлалтын хүснэгтийг бөглөхийг хүс.
- Цаг бүртгэгч томил.

## Цугларалт эхлэх үед:

- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Нээлтийн залбирал хий (хүсвэл дуулал дуулж болно).
- Бүлгийн хүмүүсийг ярилцаж байх хооронд, хоцорч ирсэн хүмүүсээс гар утсаа унтрааж, амлалтын хүснэгтээ бөглөхийг нам дуугаар хүс.
- "Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил" товхимол дээр ажиллахад 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- "Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил" товхимлын 4-р зарчмыг үзэж дуусга. Дараа нь энэ дасгалын номны дараагийн хуудаснаас үргэлжлүүлэн унш.



# ТАЙЛАГНА

## БИ ӨГСӨН АМЛАЛТАА БИЕЛҮҮЛСЭН ҮҮ?

**Цаг:** Зөвхөн энэ хуудсанд 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул (Тайлагна хэсэгт бүхэлд нь биш).

**Дадлага хий:** Амлалтаа тайлагнацгаая. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлсэн хүмүүс босно уу. (Алга таш.)

**Унш:** Одоо бүгдээрээ бос. Бид өгсөн бүх амлалтаа биелүүлэхийг хичээх ёстой. Энэ нь бие даасан хүмүүсийн эзэмших чухал дадал хэвшлийн нэг юм. Бүгдээрээ бүлгийнхээ уриаг хамт уншицгаая.

**“Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө.”**

*Сургаал ба Гэрээ 104:15*

**Бид Их Эзэнд итгэх итгэлтэйгээр бие даахын тулд хамт ажиллаж байна.**

**Унш:** Сууцгаая.

**Ярилц:** Энэ долоо хоногт та нар өгсөн амлалтаа биелүүлж байхдаа юу сурч мэдэж авсан бэ? Танд бүлгийн зүгээс ямар нэгэн туслалцаа хэрэгтэй байсан уу?





# СУРАЛЦ

## БИ ТАСРАЛТГҮЙ БОЛОВСРОЛЫН САНГААС ЗЭЭЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХ ХЭРЭГТЭЙ ЮҮ?

**Цаг:** Суралц хэсэгт 30 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Унш:** Бид сургалтын төлбөрөө төлөх арга замуудыг авч хэлэлцсэн. Нэг боломж нь Тасралтгүй Боловсролын Сангийн (ТБС) зээл юм.

1 дэх долоо хоног	2 дахь долоо хоног	3 дахь долоо хоног	4 ДЭХ ДОЛОО ХОНОГ	5 дахь долоо хоног	6 дахь долоо хоног
Ямар төрлийн ажил бие даахад маань туслах вэ?	Ямар боловсрол миний ажлын шаардлагыг хангах вэ?	Сургалтын төлбөрөө хэрхэн төлөх вэ?	Би Тасралтгүй Боловсролын Сангаас зээл авах хүсэлт гаргах хэрэгтэй юү?	Би ангид байхдаа хэрхэн амжилттай суралцах вэ?	Би ангиас гадуурх орчинд хэрхэн амжилтад хүрэх вэ?

**Унш:** Энэ долоо хоногт бид дараах асуултын хариултыг олж, дараах үйлдлийг хийнэ:

**Унш:** **ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН АСУУЛТ—Би Тасралтгүй Боловсролын Сангаас зээл авах хүсэлт гаргах хэрэгтэй юү?**

**ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ—ТБС-аас зээл авах хэрэгтэй эсэхээ гэр бүлийнхэнтэйгээ хамтарч шийднэ. Хэрэв ТБС-ийн зээл авах нь надад зохимжтой бол, би зээлийн маягтыг бөглөж дуусгана.**

## ТАСРАЛТГҮЙ БОЛОВСРОЛЫН САН ГЭЖ ЮУ ВЭ?

**Үз:** “Тасралтгүй Боловсролын Сан гэж юу вэ?” (Видео бичлэг байхгүй бол 68-р хуудсыг унш.)

**Ярилц:** Видео бичлэгийг үзэж байхад танд ямар бодол, эсвэл мэдрэмж төрсөн бэ?

**Дадлага хий:** Хоёр юм уу, гурван хүнтэй нийлж, бүлэг болон хуваагд. Ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн ТБС-ийн зээл авсан хүмүүсийн талаарх дараах мэдэгдлийг ээлжлэн унш:

“Тэд эрэлт хэрэгцээтэй байгаа ур чадварт суралцана. . . . Ажлын сайн мэргэжил, ур чадвартай болсноор эдгээр залуу эрэгтэй, эмэгтэйчүүд . . . ядуурлаас гарч чадна. “Боловсрол бол ирээдүйд хүрэх түлхүүр юм” (“The Perpetual Education Fund,” *Ensign*, 2001 оны 5 сар, 52-53).

“Тэд эх нутагтаа энэхүү агуу ажлын удирдагчид болох юм. Тэд аравны нэг ба бусад өргөлөө төлснөөр өөрийн ажлыг дэлхий даяар түгээх боломжийг Сүмд өгнө” (“Reaching Down to Lift Another,” *Ensign*, 2001 оны 11-р сар, 53–54).

“Тэд гэрлэж, сайн цалин авах ур чадварыг эзэмшиж, урагшлан явах бөгөөд нийгэмд хувь нэмэр оруулж чадах өөрийн гэсэн байр суурийг олох болно” (“The Church Goes Forward,” *Ensign*, 2002 оны 5-р сар, 6–7).

“Тэд зээлээ эргүүлэн төлөх бөгөөд төлсний дараа өөрсдийнхөө амьдралын түвшинг сайжруулсан учраас эрх чөлөө гэх гайхамшигт мэдрэмжийг эдлэх болно. . . . Тэд аливаа зүйлээс үл хамааран, толгойгоо өндөрт өргөх боломжтой болох юм” (“Тасралтгүй Боловсролын Сан,” *Ensign*, 2001 оны 5-р сар, 53).

**Ярилц:** Дээрх амлалтуудаас аль нь танд чухал вэ? Эдгээр амлалт биелэгдвэл таны болон таны гэр бүлийн амьдрал хэрхэн өөрчлөгдөх вэ?



## ХЭН ТБС-ИЙН ЗЭЭЛД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ ВЭ?

**Унш:** Өмнө нь ТБС зээлийг зөвхөн 18-30 насны буцаж ирсэн номлогчид авах боломжтой байсан. Одоо бол зээлийг шаардлага хангасан, 18 ба түүнээс дээш насны Сүмийн бүх гишүүн авах боломжтой болсон. Шаардлагуудыг судалцгаая. (Онцгой хэрэгцээг харгалзан үзэх үүднээс санваарын удирдагчид шаардлагаас гадуурх нөхцөлүүдийг зөвшөөрсөн байх ёстой.)

**Дадлага хий:** Сандлаа бүлгийн нэг гишүүн рүү харуул. Зүүн гар талд байгаа доорх шаардлагуудыг хамтдаа унш. Дараа нь баруун гар талын үгс рүү зураас татаж, хоосон зайг бөглө. Нэг жишээг харуулсан байгаа.

### ТБС-ИЙН ЗЭЭЛД ХАМРАГДАГЧИД ДАРААХ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙХ ЁСТОЙ:

Сүмийн идэвхтэй гишүүн бөгөөд _____-д үйлчилдэг байх _____-д орох зохистой, зээлийн тусламж авах шаардлагатай бөгөөд тавьсан зорилгодоо хүрэхийн тулд хичээнгүйлэн зүтгэдгийг тань санваарын удирдагчид дэмжин баталсан байх	институт 18 эсвэл түүнээс дээш
Нас _____.	дуудлага
_____ сургууль, хөтөлбөрт сурч байгаа.	Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь
_____ бүлэгт хамрагдаж, ТБС-ийн төлөвлөгөөг хийж дуусгаснаар бэлтгэгдсэн.	Ариун сүм
Санал болгосон сургууль, хөтөлбөрийн жагсаалтад орсон _____.	нутаг дэвсгэрт амьдарч, ажиллаж, сургуульд сурч байгаа
Үнэнч байж, бие даах чадвараа хөгжүүлэх үүрэг хүлээж авсан _____.	зөвлөх
_____ нь оролцогчдод хичээл сургууль, ажил төрөл болон зээлийн төлбөрөө амжилттай хийхэд нь туслахаар хамтарч байгаа.	ТБС-ийн зээл зөвшөөрөгдсөн
Хэрвээ ганц бие залуу бол _____ . . . -д хамрагдсан байх.	зээлээ бүрэн төлж байгаа

Шаардлагуудыг ойлгохын тулд 69-р хуудас руу очно уу.



## ТБС-ИЙН ЗЭЭЛИЙГ ХЭРХЭН ОЛГОДОГ ВЭ?

**Зохицуулагчийн анхааралд:** Танай нутаг дэвсгэрт тусгайлан зориулсан ТБС-ийн хөтөлбөрийн тодорхой зааварчилгаа бүхий ТБС-ийн товхимлыг тарааж өг.

**Ярилц:** Танай орон нутагт зориулсан ТБС-ийн зээл авах зааварчилгаа бүхий ТБС-ийн товхимлыг унш. Та юу олж мэдсэн бэ?

**Унш:** Бид зээлээ хугацаанд нь төлж байвал, бидэнд зээлийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ. Зээлийн нийт төлбөрийн мөнгөн дүнг дараах нөхцөлд багасгах боломжтой: (1) сурлагын дүн сайн байвал, (2) төгсөж чадвал, (3) сонгосон ажилдаа орж чадвал, (4) зээлийнхээ төлбөрийг цаг хугацаанд нь төлж байвал. Хэрэв бид эдгээр зүйлийг хийж чадвал, гүйцэтгэлийн урамшуулал авч, төлөх ёстой зээлийн мөнгөн дүн маань багасах юм.

ТБС-ийн зээлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 70-р хуудаснаас үзнэ үү. Энэ мэдээллийг гэртээ очоод, дахин анхааралтай унш. Түүнчлэн та бие даах чадвар хөгжүүлэх төвтэй холбогдож болно.

**Ярилц:** Танд бүлгийнхэн хариулж туслах өөр асуулт байна уу?

## БИ ХЭРХЭН ЗЭЭЛИЙН ХҮСЭЛТ ГАРГАХ ВЭ?


**Унш:** ТБС-д зээлийн хүсэлт гаргахын тулд дараах алхмыг дага. Хамтрагчтайгаа уулзаж, алхам бүрд ямар мэдээлэл хэрэгтэй болох талаар олж мэд. Алхам бүрд зориулсан хуудсыг эргүүлж, ээлжлэн унш (бусад хуудсан дээрх мэдээллийг бөглөх хэрэггүй). Дараа нь энэ хуудас руу эргэн ирж, тухайн алхамд зориулсан зайг тэмдэглэ.

- 1. БДЧХТ-ийн Санал болгосон жагсаалтаас ажил, хөтөлбөр, сургуулийг сонго (11, 14, 33, 34-р хуудсуудыг үзнэ үү).
- 2. Боловсролын санхүүгийн төлөвлөгөөг хийж дуусга (50-р хуудсыг үзнэ үү).
- 3. ТБС-ийн зээлийн зөвлөхөө сонго (71-72-р хуудсыг үзнэ үү).
- 4. ТБС-ийн зээлийн төлөвлөгөөний ажлын хүснэгтийг хийж дуусга (73-74-р хуудсыг үзнэ үү).
- 5. Санваарын удирдагчаас дэмжсэн тодорхойлолт ав (75-76-р хуудсыг үзнэ үү).
- 6. ТБС-ийн зээлийн онлайн маягыг [srs.lds.org/pref](https://srs.lds.org/pref) вэбсайт дээр бөглөж дуусга (77-р хуудсыг үзнэ үү).

**Ярилц:** Танд дээрх алхмуудыг хийж дуусгахад шаардлагатай бүх мэдээлэл байгаа юү? Хэрэв танд мэдээлэл байхгүй бол та хэрхэн олж авч чадах вэ?

## ЗЭЭЛД ХАМРАГДАХ ХҮСЭЛТ ГАРГАСНЫ ДАРАА ЮУ БОЛОХ ВЭ?

**Унш:** Зээлд хамрагдах хүсэлт гаргасны дараа дараах зүйл болно.



**Ярилц:** Асуулт байна уу? Хэрэв та хариултаа мэдэхгүй байвал хамгийн ойр байрлах бие даах чадвар хөгжүүлэх төвд оч.

Цугларалтын дараа, хэрэв таны зөвлөхөд интернэт рүү орох эрх байвал, тэрээр ТБС-ийн хүсэлт гаргах вэбсайт руу орж, хэрхэн ашиглахыг үзүүлж болно.

## БИ ТӨЛБӨРӨӨ ЯАЖ ХИЙХ ВЭ?

**Унш:** ТБС-ийн зээл нь бэлэг биш учраас бид эргүүлэн төлөх ёстой. Бид эргүүлэн төлөх үүрэгтэй. Бид энэхүү амлалтыг санваарын удирдагчаас ТБС-ийн зээлийг дэмжих тодорхойлолт авах ярилцлагын үеэр, зээлийн хүсэлтийг онлайнгаар бөглөж дууссаныхаа дараа хийнэ.

ТБС-ийн зээлийн эргэн төлөлт нь бусад хүнд, түүний дотор манай гадас, дүүргийн бусад гишүүнд ирээдүйд ТБС-аас зээл авах мөнгөн санг бүрдүүлдэг болно. Хэрэв бид зээлээ эргүүлэн төлөхгүй бол ирээдүйд ТБС-аас олгох зээлийн мөнгөн дүн багасна гэсэн үг юм.

Баруун гар талд байгаа эшлэлийг унш.

**Ярилц:** ТБС-ийн зээлийг эргүүлж төлөх нь яагаад чухал вэ? Дараах шалтгааныг авч үз:

- Амлалт үүргээ биелүүлж, гэрээгээ сахих чадварыг өсгөнө.
- Бусдад өөртэйгээ адил зээл авах боломжийг олгоно.
- Та болон таны гэр бүл амлагдсан адислалуудыг хүлээн авна.
- Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, бие дааж чадна.

**Унш:** Зээлийн эргэн төлөлтийг хэрхэн хийхийг ойлгуулахын тулд бид сургууль руу мөнгийг шилжүүлэхээс өмнө зээлийнхээ эхний төлбөрийг хийсэн байх ёстой.

**Зохицуулагчийн анхааралд:** Танай улсад зориулсан эргэн төлөлтийн зааварчилгааг тарааж өг.

Өөрийн улсын эргэн төлөлтийн зааварчилгаатай хамтдаа танилц.

*“Зээлэнд хамрагдагчид нь зээлээ эргүүлж төлөх бөгөөд төлснөөрөө тэд өргүй байхын эрх чөлөөг эдэлнэ. Яагаад гэвэл, тэд амьдралаа мөнгөн тусламжаар юм уу бэлгээр биш, харин зээл авч эргүүлэн төлснөөр сайжруулсан юм. Тэд бие даасан байж, өөдрөг байх боломжтой. Тэд амьдралынхаа туршид итгэлтэй, идэвхтэй байх магадлал өндөр байх юм.”*

**ГОРДОН Б.ХИНКЛИ,** “The Perpetual Education Fund,” *Ensign*, 2001 оны 7-р сар, 53

## ТБС-ИЙН ЗЭЭЛИЙГ АМЖИЛТТАЙ ТӨЛЖ ДУУСГАХАД ТАНД ЮУ ТУС БОЛОХ ВЭ?

**Үз:** “Надад ажил хийх хоёр гар бий” (Видео бичлэг байхгүй бол 78-р хуудсыг унш.)

**Ярилц:** Таны мэдэрсэн зүйлийг дүрслэх нэг үгийг энэ видео бичлэгээс сонго. Өөрийн үгийг хуваалц.

Одоогийн байдлаар олж мэдсэн зүйл дээрээ үндэслээд та ТБС-ийн зээлд хамрагдах сонголтыг хийх үү? Та энэ боломжийн талаар оновчтой шийдвэрт хүрэхийн тулд энэ долоо хоногийн турш юу хийж болох вэ?

**Унш:** Бид өсөж хөгжихдөө ганцаардахгүй. “Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна” гэдгийг санацгаая (Филиппой 4:13).



# ТУНГААН БОД

## БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

**Цаг:** Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр судар хуваалцахыг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

---

---

---

---

---

---

---

**Ярилц:** Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

*“Их Эзэний үгсийг анхааран сонс, мөн өөрт хэрэгцээтэй ямар ч зүйлийн төлөө Эцэгээс Есүсийн нэрээр гуй. Бүү эргэлз, харин итгэлтэй бай.”*

**МОРМОН 9:27**



## АМЛАЛТ ӨГ

### БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

**Цаг:** Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

---

*Хамтрагчийн нэр*

---

*Холбоо барих мэдээлэл*

**Амлалтаа нэг нэгээр нь хамтрагчдаа чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.**

#### МИНИЙ АМЛАЛТУУД

**Би ажил, боловсрол болон санхүүгийн төлөвлөгөөгөө гэр бүлийнхэнтэйгээ ярилцана.**

**Би ТБС-ийн зээл надад хэрэгтэй эсэхийг гэр бүлийнхэнтэйгээ хамтарч шийднэ.**

**Би зээлийн зөвлөгч болох хүнийг олж, санваарын удирдагчтайгаа уулзан, зээлийн маягт бөглөх үйл явцыг эхлүүлнэ.**

Би өнөөдрийн "Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил," товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

---

*Миний гарын үсэг*

---

*Хамтрагчийн гарын үсэг*

## БИ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

**Дадлага хий:** Дараагийн цугларалтын өмнө гаргаж буй ахицаа тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх хүснэгтэд “Тийм,” “Үгүй” гэж, эсвэл амлалт үүргээ биелүүлсэн тохиолдлынхоо тоог бич.

Ажил, боловсрол болон санхүүгийн төлөвлөгөөнийхөө талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцсан (Тийм/Үгүй)	Надад ТБСаас зээл авах шаардлагатай эсэхийг шийдсэн (Тийм/Үгүй)	Хэрэв надад ТБС-ийн зээл хэрэгтэй бол, зээлийн маягт бөглөх ажлыг эхлүүлсэн (Тийм/Үгүй)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил,” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)

**Унш:** Үүнээс гадна, өөрийн хувийн зардлыг “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлын ар талд тэмдэглэхээ битгий мартаарай.

Дараагийн долоо хоногт “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын нэг сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. (“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын сэдвээр хэрхэн зохицуулагч хийхээ мэдэхгүй байна уу? 17-р хуудсыг болон хавтасны нүүр хуудасны дотор талыг уншина уу).

Хэн нэгнээс хаалтын залбирал хийж өгөхийг хүс.

### Санал хүсэлт

Санал хүсэлт, санаа бодол болон туршлагаа [srsfeedback@ldschurch.org](mailto:srsfeedback@ldschurch.org) хаягаар илгээнэ үү.

# Эх сурвалж

## ТБС-ИЙН ЗЭЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Дүрүүдийг сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

**БРАЗИЛ АХ:** Би номлолоосоо бууж, гэртээ ирэхдээ боловсрол олж авах маш их хүсэлтэй байв. Би жилээс жилд, хэчнээн их хичээл зүтгэл гаргаад ч сургуульд орж чадахгүй л байлаа. Би сургалтын төлбөр буурах болов уу гэж бодсон ч, огт буухгүй байв. Харин ч бүр өсөж, сурахад илүү хэцүү болж эхэлсэн.

**ГАИТИ ЭГЧ:** Ямар ч боловсролгүй бол Гаитид амьдрах боломжгүй. Боловсролгүй бол амьдрал гэж байхгүй.

**АРГЕНТИН АХ:** Надад Сүмийн ямар ч залуу хүнтэй адил гэр бүлтэй болж, Сүмдээ үйлчилье гэсэн мөрөөдөл бий. Гэхдээ би энэ бүгдийг хийхийн тулд сайн ажил төрөлтэй байх хэрэгтэй.

**ЕРӨНХИЙЛӨГЧ ХИНКЛИ:** Энэ бүх асуудлыг шийдвэрлэхийн тулд Их Эзэний сүнсээр өдөөгдсөн төлөвлөгөөг хэмээн бидний итгэж байгаа нэгэн төлөвлөгөөг санал болгох гэсэн юм. . . . Бид үүнийг Тасралтгүй Боловсролын Сан гэж нэрлэнэ.

**ВАНДЭРЛЭЙ:** Би номлолоосоо буцаж ирээд, сурч боловсрох ямар ч боломжгүй байсан. Гэтэл гэнэт, пүн пан! Тасралтгүй Боловсролын Сан бий болж, би маш их баярласан! Би сургуульд элсэж, хичээлдээ орон, төлбөрөө хийв. Би хамаг чадлаараа хичээж, амжилтад хүрч чадсан. Мөн би ангийнхаа тэргүүний оюутан болсон юм! Би сургуульдаа орохын өмнө хар бор ажил хийдэг байлаа. Бусад хүн надад тушаал өгдөг байв. Намайг сургууль төгссөний дараа, 450 хүний бүрэлдэхүүнтэй баг удирдуулах ажилд авсан бөгөөд өнөөдөр би хавьгүй өндөр цалинтай болж чадсан. Эхнэр маань

ажиллах шаардлагагүй болсон. Тэр маань бидний хувьд хамгийн чухал ажил болох үр хүүхдүүдээ хардаг болсон билээ. Мөн би Сүмдээ хайр энэрлээр үйлчлэх боломжтой болсон юм. Би хичээл зүтгэл гарган үйлчлэх боломжтой болсон. Энэ нь миний болон гэр бүлийнхний маань амьдралыг үнэхээр өөрчилж чадсан билээ.

**НАДИЙН:** Бусдад ТБС-нд хамрагдах боломж олгож, боловсролтой болоход нь тусална гэдгийг мэдэж байгаа учраас би зээлээ эргүүлэн төлөхийн тулд өөрийн зүгээс чадах бүх зүйлийг хийх ёстой. Та энэ хөтөлбөрийн нэгэн хэсэг болсон бол үнэнч байх ёстой.

**КАРЛОС:** Миний патриархын адислал дээр надад ийм боломж олдоно гэж дурдсан байсан бөгөөд тэр нь биеллээ олсон юм. Бидний хувьд Тасралтгүй Боловсролын Сан нь зүгээр нэг материаллаг зүйл биш. Энэ нь бидний хувьд бошиглол билээ. Энэ нь нандин зүйл мөн.

**КЭВИН:** Бошиглогч над руу харж, миний нөхцөл байдлыг үзсэн мэт мэдрэмж надад төрсөн юм. Тэр надад “Би чамд туслах хэрэгтэй” гэж хэлэхийг би мэдэрсэн.

**ЕРӨНХИЙЛӨГЧ ХИНКЛИ:** Бидний өмнөх зам маань тодорхой, хэрэгцээ нь агуу их, Их Эзэн замыг маань зааж өгсөн билээ. Энэ бол амьдралыг нь хөндсөн хэнд ч гэсэн, залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, тэдний ирээдүйн гэр бүл, Сүмд ч бас мөн адил адислал болно. Бид Бурханыг бидний энэхүү хичээл зүтгэлийг ивээн тэтгэх болтугай хэмээн даруухнаар, мөн талархан залбирч байна.

**60-р хуудас руу буцаж оч.**



## ТБС-ИЙН ЗЭЭЛ АВАХАД ЯМАР ШААРДЛАГА ТАВИГДДАГ ВЭ?

- Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь бүлэгт хамрагд. ТБС-ийн зээлийн төлөвлөгөөний ажлын хүснэгтийг бөглөж дуусгах
- БДЧХТ-ийн Санал болгосон жагсаалтаас ажил, сургууль, хөтөлбөрөө сонгосон байх; онцгой тохиолдолд хүсэлт явуулсан байх
- Та сургууль, ажил, зээлийн талаар өгсөн амлалтаа биелүүлэхэд туслах зээлийн зөвлөхөө сонгосон байх
- Институтэд хамрагдсан байх (ганц бие залуу насанд хүрэгчид)
- 18 ба түүнээс дээш настай байх
- Ариун сүм орох зохистой, мөн дуудлагад үйлчилдэг байх
- Санваарын удирдагчаас дэмжсэн тодорхойлолтыг авсан байх

**61-р хуудас руу буцаж оч.**

## ТБС-ИЙН ЗЭЭЛИЙГ ЮУНД ЗОРИУЛЖ АВАХ ВЭ? ЭРГЭН ТӨЛӨЛТ ХЭРХЭН ХИЙГДЭХ ВЭ?

ТБС-ийн зээлийг дараах төлбөрийг төлөхөд ашиглана:

- Орон нутагт боломжийн ажилд ороход, эсвэл хувийн бизнесээ эхлүүлэхэд туслах боловсрол эзэмшихэд, эсвэл дадлага туршлага олж авахад
- Сургалтын төлбөр, ном, зарим хэрэгсэлд (сургалтын төлбөрийг сургуульд төлнө)

Зээлийг дараах байдлаар эргүүлэн төлнө:

- Тухайн улс орон бүрд зориулсан зээлийн төлбөрийн тогтоосон мөнгөн дүн болон эргэн төлөлтийн зааварчилгаа гарсан байгаа.
- Эргэн төлөлт нь гүйцэтгэлийн урамшуулал болон мөнгөн дүн гэсэн хэсгээс бүрдэнэ.
  - \* **Гүйцэтгэлийн урамшуулал**-аар зээлийн үлдэгдлийг дараах байдлаар багасгана:
    - Жил болгон сайн дүнгийн урамшуулал болгон жилийн төлбөрийн 5%-тай тэнцүү мөнгөн дүнг зээлээс хасна (ТБС-ийн товхимлоос сайн дүнгийн тодорхойлолтыг үзнэ үү).
    - Боловсролын хөтөлбөрт хамрагдаж, хөтөлбөрөө гүйцээсний дараа (төгсвөл) 10% хасна
    - Төлөвлөсөн зорилгодоо хүрч чадвал 10% (ажил, цалингийн түвшин)
    - Хугацаандаа хийсэн бүх төлбөрийн 25%-тай тэнцүү урамшуулал
    - Зээлээ хугацаанаас нь өмнө төлбөл, нийт зээлийн үлдэгдлийн 10%-тай тэнцүү урамшууллыг нэмж олгоно
  - \* **Сургуульд сурах хугацаанд төлөх сар бүрийн зээлийн хөнгөвчилсөн төлбөр**
    - Сургуульд төлбөрийг шилжүүлэхээс өмнө эхнийхээ төлбөрийг хийсэн байх ёстой
    - Сургуулийн төлбөр хямд, хөтөлбөрийн хугацаа арай богино байвал, сард төлөх зээлийн төлбөрийн мөнгөн дүн бага байна
    - Сургуулийн төлбөр өндөр, хөтөлбөрийн хугацаа урт байвал сард төлөх зээлийн төлбөр их байна
  - \* **Сургуулиа төгсөх юм уу, сургуулиасаа гарснаас хойш 6 сарын дараа сар бүрийн зээлийнхээ төлбөрийг хийж эхэлнэ**
    - Төлбөрийн хэмжээ нь зээлийн дүн болон хөтөлбөрийн хугацаанаас шалтгаална
    - Бага хэмжээний зээлийн хүү орсон байна
    - Гүйцэтгэлийн бүх урамшууллыг оролцуулбал, зээлийг гурваас дөрвөн жилийн дотор төлж дуусгах боломжтой.

## ТБС-ИЙН ЗЭЭЛИЙН ЗӨВЛӨХ

### ТБС-ийн зээлийн зөвлөх гэж хэн бэ?

ТБС-ийн зээлийн зөвлөх бол сургууль болон ажилдаа амжилт гарган, зээлээ цаг хугацаанд нь эргүүлэн төлж байхад тань туслах насанд хүрсэн хүн байна. **ТБС-ийн зээлийн зөвлөх нь хамтран зээлдэгч эсвэл зээлийн баталгаа гаргагч биш бөгөөд ТБС-ийн зээлтэй холбоотой санхүүгийн аливаа үүрэг хариуцлага хүлээхгүй.**

### Би хэрхэн ТБС-ийн зээлийн зөвлөхөө сонгох вэ?

Насанд хүрсэн хариуцлагатай хүнээс ТБС-ийн зээлийн зөвлөхөө болохыг хүс. Таны төлөвлөгөөний талаар мэддэг хэн нэгнийг, тухайлбал, ажил эсвэл сургуулийн талаар уулзаж ярилцсан хүмүүсээс сонгох хэрэгтэй. Уг хүн нь Сүмийн гишүүн эсвэл гишүүн биш байж болно.

ТБС-ийн зээлийн зөвлөх нь ТБС-ийн вэбсайт дээрх ТБС-ийн зээлийн зөвлөхийн хуудас руу орохын тулд ХҮГ данстай байх хэрэгтэй. Та ТБС-ийн зээлийн маягтыг бөглөхийн тулд зөвлөхөөсөө дараах мэдээллийг авсан байх хэрэгтэй:

1. ХҮГ дансны хэрэглэгчийн нэр (заавал биш)

\_\_\_\_\_

*(ХҮГ дансыг хүн болгон нээх боломжтой)*

2. Холбоо барих утас (үндсэн) \_\_\_\_\_

3. Холбоо барих утас (хоёрдахь) \_\_\_\_\_

4. Э-мэйл хаяг \_\_\_\_\_

ТБС-ийн төлөөлөгч таны ТБС-ийн зээлийн зөвлөхтэй зөвлөхийн үүргийг хүлээн авах талаар холбоо барина.

**үргэлжлэл дараагийн хуудсанд бий**

### Миний ТБС-ийн зээлийн зөвлөх юуны талаар мэдэж, мөн юу хийх ёстой вэ?

Таны зөвлөх:

- Тэр таны ТБС-ийн зээлийг төлөх санхүүгийн хариуцлага үүрэхгүй гэдгээ мэдэж байх ёстой.
- Таныг урамшуулан дэмжиж, боловсролын болон ажлын, мөн зээлийн эргэн төлөлтийн асуудалтай тулгарах үед заавар зөвлөгөө өгч, ТБС-ийн зээлээ эргүүлэн төлөх үүргээ биелүүлэхэд тань тусална.
- ТБС-ийн төлөөлөгчид ба санваарын удирдагчид таны амжилт ололтын талаар ярилцахаар утсаар болон цахим мессежээр холбоо барихад хариулж байх ёстой.
- Таны зээлийн талаарх мэдээллийн нууцыг хадгалах ёстой.
- ТБС-д зээлийн зөвлөхийнх нь үүрэг хариуцлагатай холбоотойгоор түүний Сүмийн гишүүнчлэлийн бүртгэл рүү орох, мэдээлэл цуглуулах, боловсруулах эрхийг ТБС-ийн зээлийн зөвлөхийнхөө хувьд олгож, хүлээн зөвшөөрсөн байх ёстой.

62-р хуудас руу буцаж оч.

## ТБС-ИЙН ЗЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Энэ төлөвлөгөөг бүлгийн цугларалтын үеэр биш, харин гэртээ хийж дуусга.**  
 “Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь” дасгалын номон дээрх мэдээллийг ашигла. Энэхүү төлөвлөгөөг ТБС-ийн зээл авахыг дэмжсэн тодорхойлолт авах ярилцлагынхаа үеэр санваарынхаа удирдагчид үзүүл.

### Миний зөвлөх (4 дэх долоо хоног, 71-р хуудаснаас)

Нэр: \_\_\_\_\_

ХҮГ дансны хэрэглэгчийн нэр (заавал биш): \_\_\_\_\_

Холбоо барих утас (үндсэн): \_\_\_\_\_

Холбоо барих утас (хоёрдахь): \_\_\_\_\_

Э-мэйл хаяг: \_\_\_\_\_

### Миний ажлын төлөвлөгөө (1 дэх долоо хоног, 14-р хуудаснаас)

#### МИНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: ЯМАР АЖИЛ БИЕ ДААХАД МААНЬ ТУСЛАХ ВЭ?

##### Одоогийн эрхэлж буй ажил

Нэг долоо хоногийн ажлын нийт цаг (бүх ажил):

Ажлын албан тушаал (ууд):

Сарын цалин:

##### Ирээдүйн ажил (БДЧХТ-ийн Санал болгосон ажлын жагсаалтад орсон байх, эсвэл тухайн ажил Санал болгосон ажлын жагсаалтад ороогүй тохиолдолд хүсэлт гаргасан байх ёстой)

Ирээдүйн ажлын албан тушаал:

Төлөвлөж буй сарын цалин (хөтөлбөрт хамрагдаж дууссаны дараа):

### Миний боловсролын төлөвлөгөө (2 дахь долоо хоног, 34-р хуудаснаас)

#### МИНИЙ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: ЯМАР БОЛОВСРОЛ ЭСВЭЛ ДАДЛАГА ТУРШЛАГА МИНИЙ АЖЛЫН ШААРДЛАГЫГ ХАНГАХ ВЭ?

Сонгосон сургууль (БДЧХТ-ийн Санал болгосон сургууль, хөтөлбөрийн жагсаалтаас):

Мэргэжил эсвэл хөтөлбөр (БДЧХТ-ийн Санал болгосон сургууль, хөтөлбөрийн жагсаалтаас):

Сонгосон ажил (БДЧХТ-ийн Санал болгосон ажлын жагсаалтаас):

Та зээлийн хүсэлт гаргаад, хэзээ сургуулиа эхлэх боломжтой вэ?

Төгсөхөөр төлөвлөсөн он, сар:

**үргэлжлэл дараагийн хуудсанд бий**

## ТБС-ИЙН ЗЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (ҮРГЭЛЖИЛНЭ)

Миний орлого, зарлага (3 дахь долоо хоног, 47-р хуудаснаас)

САРЫНХАА ОРЛОГЫГ НЭМ (гэрлэсэн бол эхнэр, нөхрийн орлогыг оруул)		САРЫНХАА ЗАРЛАГЫГ НЭМ	
Ажлаас орж ирэх орлого		Аравны нэг ба бусад өргөл	
Гэр бүлийн зүгээс боловсролын зардалд оруулах хандив		Хадгаламж	
Бусад орлого		Хоол хүнс	
Бусад орлого (сар тутам)		Орон сууц	
<b>"А" Сарын нийт орлого</b>		Ус	
		Эмчилгээний зардал	
		Унаа	
		Боловсролын зардал	
		Өр зээлийн төлбөр	
		Хувцас	
		Цахилгаан	
		Утас	
		Бусад	
		<b>"Б" Сарын нийт зарлага</b>	

Одоо сар бүр боловсролын зардалдаа хэдэн төгрөг төлж чадахаа тооцоолж гарга:

**"А" Сарын нийт орлого** – **"Б" Сарын нийт зарлага** =

**"В"** \_\_\_\_\_ x 12 сар (сар) = **"Г"** \_\_\_\_\_.

Миний боловсролын зардал (3 дахь долоо хоног, 48-р хуудаснаас)

МИНИЙ БОЛОВСРОЛЫН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (нэг жилийн)	Сонгосон сургууль
Сургалтын төлбөр (нэг жилийн)	
Шалгалтын болон бусад төлбөр (элсэлт, лиценз, гэрчилгээ, төгсөлтийн шалгалтын болон бусад төлбөр—нэг жилийн) <b>НЭМ</b>	+
Ном ба хэрэгслүүд (нэг жилийн) <b>НЭМ</b>	+
Тэтгэлэг ба буцалтгүй тусламж (байвал—нэг жилийн) <b>ХАС</b>	-
<b>"Д" Миний боловсролын зардлууд (нэг жилийн)</b>	=
<b>"Г" Бидний төлж чадах мөнгөн дүн (нэг жилийн)</b>	-
<b>"Е" Төлөх үлдсэн мөнгөн дүн (нэг жилийн)</b>	=

### Зөвлөхийн тодорхойлолт

\_\_\_\_\_ (нэр) нь *Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь* бүлгийн дөрвөн хичээлийг авч дуусгасан бөгөөд ТБС-ийн зээлд хамрагдахад бэлэн болно.

Зөвлөхийн нэр

Зөвлөхийн гарын үсэг

Огноо

## САНВААРЫН УДИРДАГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Энэ маягт нь танай гадасны бие даах чадвар хөгжүүлэх төвд, эсвэл онлайнаар [srs.lds.org/ref](https://srs.lds.org/ref) вэбсайт дээр байгаа болно. ТБС-ийн зээлийн төлөвлөгөөгөө (73-74-р хуудас) санваарын удирдагчийн тодорхойлолт өгөх ярилцлагад авч ир.



### Priesthood Leader Interview and Endorsement

PEF Applicant (print name): \_\_\_\_\_

Dear Bishopric or Branch Presidency,

This member is seeking better education and work. Please discuss with the member the following statements. Place your initials in each box to indicate your endorsement.

Bishopric or Branch Presidency	Statements
	I have reviewed this member's Self Reliance Plan and budget and recommend that he/she receive a PEF loan.
	This member of my unit regularly attends sacrament and other Sunday meetings, is temple worthy, and fulfills a calling.
	I have reviewed the Self-Reliance Plan (as well as the member's back of this form). The member understands and is committed to the principles of the plan.
	This member is committed to the education and sacrifice necessary to succeed in school and gain better employment.
	This member has a qualified Loan Mentor for the PEF loan. His/Her name is: _____, I support the choice of mentor.
	This member is a person of integrity and acknowledges that s/he is making a financial commitment to pay the Perpetual Education Loan in full.
	This member understands that they may review their loan repayment status with the ward or self-reliance committee or the loan mentor.
	If a Young Single Adult, this member has satisfactorily fulfilled the Institute attendance requirement and has presented verification from the Institute.
	I will review on a monthly basis this member's loan repayment status and offer encouragement and counsel as needed.

As leaders of the applicant, we have discussed these statements and certify that they are true.

	Name	Signature	Date
Applicant	_____	_____	_____
Bishopric or Branch Presidency	_____	_____	_____

үргэлжлэл дараагийн хуудсанд бий



**Санваарын удирдагчдад болон маягт бөглөсөн хүмүүст зориулсан бие даах талаарх чухал сургаалууд**

**Есүс Христэд итгэх итгэл**

С ба Г 104:15; Ифер 12:27

Бурханы зорилго бол Өөрийн гэгээнтнүүдийн материаллаг хэрэгцээг хангах явдал бөгөөд Түүнд энэ бүхнийг хийх хүч чадал бий гэдэгт итгэ.

**Дуулгавартай байдал**

С ба Г 130:21; Магай 7:21

Бие даах чадварын адислал нь бие даах байдлын тулгуурлагдсан хууль ба ёслолууд дээр тогтоогддог юм.

**Хувь хүн үйлдэх ёстой**

2 Нифай 2:16, 26

Бие даах чадвар нь олгогдох эрх мэдэл биш, харин өөрөө өөртөө үзүүлэх тусламж юм. Та ажиллах ёстой. Та үйлдүүлдэг бус, харин үйлддэг нэгэн байх ёстой.

**Нэгдмэл байдал ба үйлчлэл**

Моце 7:18; С ба Г 56:16-17

Ядуу, баян хоёр нэгдмэл байх ёстой. Бүх хүн нэг нэгэндээ үйлчилж, нэг нэгнийгээ хайрлах ёстой.

**62-р хуудас руу буцаж оч.**

### ТБС-ИЙН ЗЭЭЛИЙН ОНЛАЙН МАЯГТ РУУ ХОЛБОГДОХ НЬ

Та ТБС-ийн зээлд хамрагдахын тулд өөрийн ХҮГ дансыг ашиглаад, [srs.lds.org/ref](https://srs.lds.org/ref) вэбсайт дээрх зээлийн онлайн маягтыг бөглөх ёстой.

ХҮГ данс бүхий ТБС-ийн зээлийн зөвлөхүүд нь ТБС-ийн вэбсайт дээрх өөрийн ТБС-ийн зээлийн зөвлөхийн хуудас руу орж болно.

Хэрэв та саяхан номлолд үйлчилсэн бол танд ХҮГ данс байгаа байх. Хэрэв танд ийм данс байхгүй бол та ХҮГ дансыг [ldsaccount.lds.org](https://ldsaccount.lds.org) вэбсайт дээр нээж болно.

#### Ерөнхий асуултууд

##### 1. ХҮГ данс гэж юү вэ?

ХҮГ данс гэдэг нь [ldsjobs.org](https://ldsjobs.org), гэр бүлийн түүх, онлайн номлогчийн маягт, тойрог ба гадасны вэбсайт зэрэг Сүмийн ихэнх вэбсайт руу нэвтэрч орох систем юм (хэрэглэгчийн нэр, нууц үг).

##### 2. Би ХҮГ дансыг ашиглахын тулд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн байх ёстой юү?

Үгүй. Гишүүн байх шаардлагагүй. Сүмийн гишүүд өөрсдийн гишүүнчлэлтэй (ТБС-ийн зээлийг авахад гишүүн байх ёстой) холбоотой нэмэлт эх сурвалж руу орох боломжтой ч, ямар ч хүн “найз” маягаар чөлөөтэй данс нээж болно (үүнд: гишүүн бус зээлийн зөвлөх орно).

##### 3. Өөрийн ХҮГ данстай болохын тулд надад ямар мэдээлэл хэрэгтэй вэ?

Хэрэв та Сүмийн гишүүн бол таны гишүүнчлэлийн бүртгэлийн дугаар, төрсөн огноо, хүчин төгөлдөр э-мэйл хаяг шаардлагатай болно. Та гишүүнчлэлийн бүртгэлийн дугаараа ариун сүмийн зөвшөөрлийн бичиг дээрээсээ, эсвэл тойргийнхоо юм уу, салбарынхаа бичиг хэргийн ажилтнаас авч болно. Хэрэв таны зээлийн зөвлөх Сүмийн гишүүн биш бол, тэрээр нэр, төрсөн огноо, хүйс болон улс орныхоо талаарх мэдээллээ өгсөн байх хэрэгтэй.

ТБС-ийн зээлийн онлайн маягт руу орохын тулд бидэнд дараах зүйлс хэрэгтэй:

##### 1. Таны тухай болон танай гэр бүлийн талаарх ерөнхий мэдээлэл

##### 2. Санваарын удирдагчийн дэмжсэн тодорхойлолт

##### 3. Гүйцэд хийж дуусгасан “ТБС-ийн зээлийн төлөвлөгөө”

- \* Зөвлөхийн мэдээлэл
- \* Ажлын төлөвлөгөө
- \* Боловсролын төлөвлөгөө
- \* Боловсролын санхүүгийн төлөвлөгөө
- \* Зөвлөхийн тодорхойлолт

62-р хуудас руу буцаж оч.

## НАДАД АЖИЛ ХИЙХ ХОЁР ГАР БИЙ

Перугийн Сүмийн гишүүн Аргуругийн тухай энэ түүхийг ээлжилж унш.

Номлолын талбараа орхиж явах амар байсангүй. Надад олон мөрөөдөл, төлөвлөсөн зүйл байсан боловч гэртээ ирсний дараа бодит байдалтай нүүр тулах хэрэгтэй болсон юм. Надад ямар ч үр чадвар, олигтой орлого байсангүй. Ажил олох ч амар байсангүй.

Эцэст нь би жимсний лангуу ажиллуулж, олсон мөнгөөрөө сургуулийнхаа төлбөрийг төлөн, гэр бүлдээ тусалж, аравны нэг болон бусад өргөлөө төлж байлаа.

Би иймэрхүү байдлаар 9-р сарыг хүргэв. Жимсээ зарж байтал дарсны машин миний араас ирж, намайг мөргөв. Тэр машин намайг хана руу хүчтэй цохиж, миний баруун хөлийг гэмтээсэн юм. Би баруун хөлгүй болж, нэг нүд минь хараагүй болов. Миний баруун гар, зүүн хөл ч мөн адил гэмтсэн байлаа.

Энэ бүхний дараа, би бошиглогчийн ядуурал үгүй болох ёстой, мөн санхүүгийн эх сурвалжгүй буцаж ирсэн номлогчид боловсролтой болох боломжтой гэж хэлэхийг сонссон юм. Хүсэл тэмүүлэл дүүрэн залуучуудад зориулж ТБС-г бий болгоно гэсэн байв. Би хөлгүй, мөн нүдгүй болсон ч, амьдрах хүсэл эрмэлзлээ буюу мөрөөдлөө орхиогүй. Би өөрийнхөө өмнө тавьсан зорилго бүрийнхээ төлөө зүтгэхээр шийдсэн юм.

Би Тасралтгүй Боловсролын Сангийн хүчинд тусгай мэргэжлийн сургалтаа гурван жилийн дотор дүүргэж, дараа нь илүү ихийг сурахыг хүссэн. Би их сургуульд орох өргөдөл гаргаж, сургуульдаа ч орж чадсан билээ.

Өнөөдөр би хувиараа ажилладаг бөгөөд хэрэглэгчдэд туслах төлөөлөгч хийдэг. Би өглөөнөөс эхлэн 16 цаг хүртэл хэд хэдэн компанийн харилцагчдын ба компьютерийн техник хангамжийн үйлчилгээг үзүүлдэг. Түүнчлэн би гэртээ компьютерын засварын үйлчилгээ хийдэг. Би оройгоор сургуульдаа явдаг юм. Би 17 цагт гэрээсээ гарч, 18 цаг гэхэд хичээл эхэлдэг. Хичээл маань 23 цаг хүртэл үр-

гэлжилдэг. 23:30 гэхэд би таксид сууж, гэртээ шөнийн 00:30 гэхэд ирдэг. Би бага сага хоол идэж, хичээлээ давтчихаад, орондоо ордог юм. Маргааш нь би эрт босож, ажилдаа явах юм уу, ажлын эрэлд гардаг. Би үдийн 14 эсвэл 15 цаг хүртэл ажиллаад, дараа нь сургуульдаа явдаг.

Би өөртөө байгаа бүхнийхээ төлөө Бурханд талархаж явдаг. Би Түүний миний төлөө хийсэн бүх зүйлийг нь ямар нэгэн арга замаар эргүүлэн төлөхийг хүсдэг. Би өөрөө их зүйл хийгээгүй бөгөөд би Түүнд үргэлж өртэй байх болно. Би Сүмийн Тасралтгүй Боловсролын Сангийн албаны дуудлага хүлээн авах төвд сайн дурын ажилтнаар үйлчилдэг.

Би хоёр жил хагасын дараа гэхэд, системийн техникчийн мэргэжлээр төгссөн байгаагаар өөрийгөө төсөөлөн харж байна. Би таван жилийн дараа гэхэд, ямар нэгэн чухал компанид ажилд орж, өөрийгөө болон ирээдүйн гэр бүл, үр хүүхдээ тэжээх болно.

Би ариун сүмд гэрлэх зорилго тавьсан. Тийм ч учраас би сурч, ажиллаж байгаа юм. Тийм ч учраас би өдөр болгон тэмцдэг.

Амар хялбар байхгүй гэдгийг мэддэг ч, Их Эзэн хэзээ ч замыг нь бэлдэлгүйгээр тушаал өгдөггүй болохыг би сурсан юм.

Тэр надад амьдрал өгсөн. Тэр надад Тасралтгүй Боловсролын Санг өгсөн. Тэр надад ажил хийх хоёр гар, бодож сэтгэх тархи, хэлж ярих ам, мэдрэх зүрхийг, мөн өөрийн мөрөөдлийн төлөө урагш тэмүүлэх хүсэл эрмэлзлийг өгсөн юм.

Би мөн “Мөхөс байдал дотор миний хүч чадал төгс болно” хэмээн Паулын хэлсний адил бүх зүйл боломжтой гэдгийг мэднэ. Их Эзэнд надад тусалсан.

Гэр бүл, сургууль, амьдрал гээд надад байгаа бүх зүйлийг Бурхан өгсөн юм. Бүх зүйл Түүний гараас ирдэг бөгөөд би тэр бүхэнд талархаж явдаг.

**64-р хуудас руу буцаж оч.**



# 5

*Би ангид байхдаа хэрхэн амжилттай суралцах вэ?*

---

**Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь**

# ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

## Цугларалт хийх өдөр:

- Бүлгийн гишүүд рүү мессеж илгээ, эсвэл утсаар ярь. Тэднийг 10 минутын өмнө ирж, амлалтаа хэрхэн биелүүлсэн талаар тайлагнахад урь.
- Цугларалтын үеэр ашиглах материалуудыг бэлд.

## Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойрхон суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
- Энэ амлалтын хүснэгтийг самбар дээр зур.

Бүлгийн гишүүний нэр	Гэр бүлийн хэнтэйгээ ажил, боловсрол болон санхүүгийн төлөвлөгөөгөө ярилцсан (Тийм/Үгүй)	Би ТБС-ийн зээл авах хэрэгтэй эсэхээ шийдсэн (Тийм/Үгүй)	Хэрэв надад ТБС-ийн зээл авах хэрэгтэй бол би маягтаа бөглөж эхэлсэн (Тийм/Үгүй)	Суурь зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамт-рагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)
Глория	Т	Т	Т	Т	Т	Т

## Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Хүмүүсийг орж ирэхэд дотно хүлээж авч угт.
- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд, тэднээс самбар дээрх амлалтын хүснэгтийг бөглөхийг хүс.
- Цаг бүртгэгч томил.

## Цугларалт эхлэх үед:

- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Нээлтийн залбирал хий ( хүсвэл дуулал дуулж болно).
- Бүлгийн хүмүүсийг ярилцаж байх хооронд, хоцорч ирсэн хүмүүсээс гар утсаа унтрааж, амлалтын хүснэгтээ бөглөхийг нам дуугаар хүс.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимол дээр ажиллахад 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” дээрх 5-р зарчмыг үзэж дуусга. Дараа нь энэ дасгалын номны дараагийн хуудаснаас үргэлжлүүлэн унш.





# ТАЙЛАГНА

## БИ ӨГСӨН АМЛАЛТАА БИЕЛҮҮЛСЭН ҮҮ?

**Цаг:** Зөвхөн энэ хуудсанд 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Амлалтаа тайлагнацгаая. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлсэн хүмүүс босно уу. (Алга таш.)

**Унш:** Одоо бүгдээрээ бос. Бид өгсөн бүх амлалтаа биелүүлэхийг хичээх ёстой. Энэ бол бие даасан хүмүүсийн эзэмших чухал дадал хэвшлийн нэг болно. Бүгдээрээ бүлгийнхээ уриаг хамт уншицгаая.

**“Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө.”**

*Сургаал ба Гэрээ 104:15*

**Бид Их Эзэнд итгэх итгэлтэйгээр бие даахын тулд хамт ажиллаж байна.**

**Унш:** Сууцгаая.

**Ярилц:** Энэ долоо хоногт та нар өгсөн амлалтаа биелүүлж байхдаа юу сурч мэдэж авсан бэ? Танд бүлгийн зүгээс ямар нэгэн туслалцаа хэрэгтэй байсан уу?

## МИНИЙ ГАРГАСАН АХИЦ

**Цаг:** Зөвхөн энэ хуудсанд 15 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Унш:** Өнөөдрийг хүртэл гаргасан ахицаа тайлагнацгаая. Энэ видео бичлэг үүнийг хэрхэн хийх талаар үзүүлнэ.

**Үз:** “Гаргасан ахицаа тайлагнах нь” (Видео бичлэг байхгүй бол 92-р хуудсыг унш.)

**Дадлага хий:** Одоо бүлгийн гишүүд өнгөрсөн долоо хоногуудад гаргасан ахицынхаа талаар хуваалцана. Эхлээд эдгээр зааврыг унш.

1. Доорх чухал асуултуудад өгөх хариултын талаар дотроо хэдэн минут бод. Мэдээлэл нь таны өмнөх долоо хоногуудын дасгалын номон дээр байх ёстой.
2. Бүгд бэлэн болсны дараа хариултаа хамтрагчдаа ээлжлэн танилцуул. Санал хүсэлтийг нь авахаа битгий мартаарай.

### МИНИЙ ИЛҮҮ САЙН АЖИЛТАЙ БОЛОХЫН ТӨЛӨӨ СУРЧ БОЛОВСРОХ ЯВЦДАА ГАРГАСАН АХИЦ

Яагаад би илүү бие даахыг хүсэж байна вэ? \_\_\_\_\_

Би бие даахын тулд ямар орлоготой байх шаардлагатай вэ? \_\_\_\_\_

Би тийм хэмжээний орлоготой болохын тулд ирээдүйд хийх ямар төрлийн ажлыг сонгосон бэ? \_\_\_\_\_

Ямар дадлага туршлага, эсвэл боловсрол эзэмшвэл миний ирээдүйн ажлын шаардлагыг хангах вэ? \_\_\_\_\_

Би ямар сургууль, хөтөлбөрийг сонгосон бэ? Яагаад? \_\_\_\_\_

Би боловсролынхоо зардлуудыг мэдэх үү? Би тэдгээрийг хэрхэн төлөх вэ? Ажил хийж? Гэр бүлээс? Зээл авч? \_\_\_\_\_

Би эдгээр зардлыг төлөхийн тулд ТБС-аас зээл авах хүсэлт гаргах хэрэгтэй юү? \_\_\_\_\_

Хэрэв зээл авах хэрэгтэй бол, би зөвлөхтэй болсон уу, мөн санваарын удирдагчтайгаа уулзсан уу? \_\_\_\_\_

Тийм бол, би зээлийн маягыг бөглөж дууссан уу? \_\_\_\_\_

Надад байгаа хамгийн том асуудал эсвэл асуулт бол: \_\_\_\_\_

Надад өгөх санал хүсэлт эсвэл зөвлөгөө байна уу? \_\_\_\_\_





# СУРАЛЦ

## БИ СУРГУУЛЬД ОРСНЫХОО ДАРАА ХЭРХЭН АМЖИЛТТАЙ СУРАЛЦАХ ВЭ?

**Цаг:** Суралц хэсэгт 45 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Унш:** Бид боловсролоо төлөвлөхөд нэлээн их ахиц гаргалаа. Гэхдээ яг сургуульд орсныхоо дараа амжилт олоход бидэнд юу хэрэгтэй вэ?

1 дэх долоо хоног	2 дахь долоо хоног	3 дахь долоо хоног	4 дэх долоо хоног	5 ДАХЬ ДОЛОО ХОНОГ	6 дахь долоо хоног
Ямар төрлийн ажил бие даахад маань туслах вэ?	Ямар боловсрол миний ажлын шаардлагыг хангах вэ?	Сургалтын төлбөрөө хэрхэн төлөх вэ?	Би Тасралтгүй Боловсролын Сангаас зээл авах хүсэлт гаргах хэрэгтэй юү?	Би ангид байхдаа хэрхэн амжилттай суралцах вэ?	Би ангиас гадуурх орчинд хэрхэн амжилтад хүрэх вэ?

**Унш:** Энэ долоо хоногт бид энэ асуултын хариултыг олох бөгөөд дараах үйлдлийг хийнэ:

**Унш:** ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН АСУУЛТ—Би ангид байхдаа хэрхэн амжилттай суралцах вэ?

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ—Сүнслэг зарчмуудад дуулгавартай байх байдлаа хүчирхэгжүүлж, суралцах ур чадвар, дадал хэвшлээ сайжруулна.

## ЯАГААД ИХ ЭЗЭН БИДЭНД СУРАЛЦ ХЭМЭЭН ЗӨВЛӨСӨН БЭ?

- Унш:** Их Эзэн болон Түүний бошиглогчид бидэнд сурч боловсорч, дадлага туршлагатай болохыг эрэлхийлэн, сайн ажилтай болохын тулд ур чадвар эзэмшиж, сайн ажиллаж хөдөлмөрлөхийг зөвлөсөн байдаг.
- Үз:** “Боловсрол бол боломж нээх түлхүүр юм” (Видео бичлэг байхгүй бол 93-р хуудсыг унш.)
- Ярилц:** Гурав гурваараа бүлэг болон хуваагд. Хэдэн минутын дотор дараах асуултуудыг ярилц. Дараа нь бүлгээрээ сурч мэдсэн зүйлээ товч дүгнэ.
1. Их Эзэн яагаад биднийг боловсрол, дадлага туршлагатай болоосой хэмээн хүсдэг вэ? Тэр биднийг амжилтад хүрэхэд туслах уу?
  2. Боловсрол, дадлага туршлага нь Бурханы бидэнд өгсөн “дуудлагыг хичээнгүйлэн гүйцэтгэхэд” хэрхэн туслах вэ?

*“Мөн бүгдээр итгэлгүй байгаа учраас, та нар хичээнгүйлэн эрэлхийлж мөн мэргэн ухааны үгсийг бие биендээ заагтун; тийм ээ, мэргэн ухааны үгсийг шилдэг номнуудаас эрэлхийлэгтүн та нар; бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэгтүн.”*

**СУРГААЛ БА ГЭРЭЭ**  
**88:118**

## БИ ИТГЭЛЭЭР ХЭРХЭН СУРАЛЦАЖ БОЛОХ ВЭ?

- Унш:** Баруун гар талд байгаа судрыг унш.
- Дадлага хий:** Хүснэгт дээрх нэг зарчмыг сонгоод, дотроо унш. “Энэ нь миний суралцах арга барилыг хэрхэн өөрчлөх вэ?” гэж өөрөөсөө асуу.

### ИТГЭЛИЙН ЗАРЧИМ

**Зохистой бай.** “Хэрэв та нар зөвшөөрч, дуулгавартай дагавал, энэ газрын хамгийн сайныг иднэ” (Исаиа 1:19); “Мөн бид ямар ч адислалыг Бурханаас авлаа гэхэд, энэ нь тулгуурлагдсан тэрхүү хуульд дуулгавартай байснаар буюу” (С ба Г 130:21).

**Сүнсийг эрэлхийл.** “. . . Харин Туслагч. . . та нарт бүх зүйлийг заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно” (Иохан 14:26); “Хичээнгүйлэн судлагтун, үргэлж залбирагтун, мөн итгэлтэй байгтун” (С ба Г 90:24).

**Сонс, тунгаан бод, итгэ.** “Анхаарагтун, та нарын Гэтэлгэгч. . . Есүс Христийн дуу хоолойг буюу” (С ба Г 29:1); “Тийм ээ, . . . намуухан аниргүй дуу хоолой ийн хэлдэг” (С ба Г 85:6); “Бүү гайхшир, . . . бүү эргэлз, харин итгэлтэй бай” (Мормон 9:27).

**Үйлд, өөрийгөө бүрэн зориул.** “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсэж байвал тэр нь . . . мэднэ” (Иохан 7:17); “. . . би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно” (1 Нифай 3:7); “хүмүүс сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулж, . . . туйлын зөв шударга байдлыг тохиолгохоор авчрах ёстой” (С ба Г 58:27).

Бүлгээрээ сурч мэдсэн зүйлээ ярилц. Та энэ дөрвөн зарчмыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх вэ? Та тэдгээрийг гэр бүлийнхэндээ хэрхэн заах вэ?

- Унш:** Бид үнэнийг мэдэх учраас итгэлээр суралцаж чадна! Бурхан бол бидний Эцэг бөгөөд бид Түүний хүүхэд мөн. Тэрээр биднийг Өөртэйгөө адилхан байгаасай гэж хүсдэг. Аврагч Өөрийн хүчийг бидэнд өгөх боломжтой. Ариун Сүнс бидний ойлголтыг тэлж, сурч мэдсэн зүйлээ тогтооход тусална. Бид эдгээр үнэнийг мэддэг учраас, бид сайн суралцагч байна гэдэгт итгэлтэй байж болно!

## БИ ХЭРХЭН СУДАЛЖ СУРАЛЦАХ ВЭ?

**Унш:** Бид итгэлээр суралцахаас гадна, мөн судалж суралцах ёстой. Судлах үйл явцад бидний анги *дотоо* юу хийдэг, мөн ангиас *гадуурх* орчинд хэрхэн бэлтгэдэг зэрэг нь ордог. Цугларалтын үлдсэн хугацаанд бид эдгээр чухал зарчимд анхаарлаа хандуулна. Дараагийн долоо хоногт бид ангиас гадуурх орчинд хэрхэн бэлтгэх талаар авч хэлэлцэнэ.



## СУРАЛЦСАН ЗҮЙЛЭЭ ОЮУН УХААНДАА БУУЛГАЖ АВАХЫН ТУЛД ХЭРХЭН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ ВЭ?

**Унш:** Бид ангидаа харж, сонссон зүйлээ оюун ухаандаа буулган авахын тулд тэмдэглэл хөтөлдөг. Бид сурсан зүйлээ эргэж санахын тулд тэмдэглэлээ дахин хардаг.

**Дадлага хий:** 94-р хуудсан дээрх нэг хүнийг сонгоод, “Бодит амьдрал дээрх боловсрол”-ыг уншуул. Бүлгийн бусад гишүүн сонсож, доорх тэмдэглэлийг үз. Эдгээр тэмдэглэл нь ерөнхийлөгч Айрингийн хэлсэн үгийг буулгаж авч чадсан байна уу?

### БОДИТ АМЬДРАЛ ДЭЭРХ БОЛОВСРОЛ: ХЭНРИ Б.АЙРИНГ

Их Эзэн намайг суралцаасай хэмээн хүсдэг; Түүний ач ивээл надад тусална	Хөрвөлт нь суралцах хүсэл эрмэлзлийг төрүүлдэг
Суралцах нь надад үйлчлэх боломжийг олгодог	Их Эзэн биднийг суралцаж, үйлчлээсэй хэмээн хүсдэг
Бодит амьдрал бол мөнх амьдрал мөн!!	Түүний ач ивээл бидэнд хурдан бөгөөд илүү сайн суралцахад тусална
	Түүний нэн тэргүүнд тавьдаг зүйл бол сүнслэг суралцахуй мөн
	Их Эзэн бидний хийх хэрэгтэй зүйлийг мэднэ
	Бодит амьдрал бол мөнх амьдрал мөн
	Бидний сурч мэдсэн зүйлс бидэнтэй хамт үлддэг
	Бурхан биднийг суралцаж, үйлчлээсэй хэмээн хүсдэг.
	Суралцах талаар илүү их залбир, Арцун Сүнсэнд найд

1. Гарчиг, үг хэлсэн хүний нэрийг бич.

2. Тэднийг ярьж байхад, энэ том зайд чухал гэсэн зарчмуудыг бич, мөн хялбарчил.

3. Хичээлийн дараа цаг алдалгүй өөрийн тэмдэглэлийг энэ зайд товчлон бич.

4. Санаж бас хийх ёстой хамгийн чухал зүйл юу болохыг шийд.



## СУРЧ МЭДСЭН ЗҮЙЛЭЭ ХЭРХЭН САНАЖ ТОГТООХ ВЭ?

**Унш:** Хэрэв бид зохистой байвал Ариун Сүнс бидэнд “бүх зүйлийг сануулах болно” (Иохан 14:26). Түүнчлэн бид тодорхой хугацааны дараа ахин дахин үзэж байвал илүү ихийг тогтоох боломжтой юм. Бид доорх загварыг дагавал, бараг бүх мэдээллийг тогтоох боломжтой гэдгийг эрдэмтэд олж тогтоосон байна:

Шинэ мэдээлэл	1 цагийн дараа	1 өдрийн дараа	1 долоо хоногийн дараа	1 сарын дараа
Ангид ямар нэгэн зүйлийг уншиж, эсвэл сурч, тэмдэглэл хөтөл	Тэмдэглэлээ дахин үзэхэд 10 минут зарцуул	Дахин 10 минут унш; тэмдэглэлээ товчлон бич	Дахин 10 минут унш	Дахин 10 минут унш. Та уншсан зүйлээ мартаггүй!

**Ярилц:** Та ийнхүү дахин дахин уншихын тулд өөрийн суралцах дадал хэвшил ба цагийн хуваарийг хэрхэн өөрчлөх вэ? Та өөрчлөх үү?

## БИ АНГИЙНХАА ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРХЭН ИДЭВХТЭЙ ОРОЛЦОХ ВЭ?

**Ярилц:** Анги эсвэл бүлгийн үйл ажиллагаанд оролцох нь яагаад чухал вэ? Та ингэж оролцсоноороо багшдаа юу харуулж байгаа вэ?

**Дадлага хий:** Та дараах асуултуудад хариулж, хэр сайн оролцдог болохоо дүгнэ.

Асуулт болгоны доор байрлах зайд “х” гэж тэмдэглээд, тухайн зүйлд ямар байгаагаа харуул.

Би бие даах чадвар хөгжүүлэх бүлэгт бэлэн байдаг. Би асуултуудад хариулж, тогтмол оролцдог.	Хэзээ ч үгүй	Заримдаа	Ихэнх тохиолдолд	Байнга
Би сургууль дээрээ хичээлд бэлэн байдаг. Би үүргээ биелүүлэн, асуултад хариулж, шаардлагатай бүх үйл ажиллагаанд оролцдог.	Хэзээ ч үгүй	Заримдаа	Ихэнх тохиолдолд	Байнга
Би сонсож, идэвхтэй суралцсанаар, эсвэл тэдэнтэй хамтран ажилласнаар бүлгийнхээ, эсвэл ангийнхаа хамт олонд туслахыг хичээдэг.	Хэзээ ч үгүй	Заримдаа	Ихэнх тохиолдолд	Байнга
Би өдөр болгон хичээлээ хийдэг бөгөөд цагаа төлөвлөж, төлөвлөгөөгөө дагадаг, мөн даалгавраа цаг тухайд нь хийдэг.	Хэзээ ч үгүй	Заримдаа	Ихэнх тохиолдолд	Байнга
Би багш эсвэл зохицуулагчаа сонсож, шаардсан зүйлээс нь илүү ихийг хийснээрээ тэдэнд туслахыг хичээдэг.	Хэзээ ч үгүй	Заримдаа	Ихэнх тохиолдолд	Байнга

**Ярилц:** Та өдөр бүр өөрийнхөө идэвхтэй оролцоог хэрхэн сайжруулах вэ?

### БИ ШАЛГАЛТАА ХЭРХЭН САЙН ӨГӨХ ВЭ?

**Унш:** Шалгалт өгөхөд хэцүү байх үе бий. Гэхдээ бид хэр сайн сурч мэдсэнээ харуулахын тулд зайлшгүй шалгалт өгөх шаардлагатай. Шалгалт нь биднийг хариуцлагатай болгодог. Амжилтад хүрэхийг хүсэж байгаа бол энэ нь сайн зүйл юм.

**Ярилц:** Бүлгээрээ дараах асуултын талаарх өөрсдийн бодол санааг хуваалц:

1. Та шалгалтаа сайн өгөхийн тулд юу хийдэг вэ?
2. Шалгалтын талаар танд ямар айдас байдаг вэ? Та тэдгээрийг хэрхэн даван туулдаг вэ?
3. Та шалгалтад бэлтгэдэг арга барилаа хэрхэн өөрчилж чадах вэ?

**Унш:** Бид шалгалтаа сайн өгөгч байхын тулд дараах зүйлсийг хийж болно:

- Итгэлээр залбир! Хичээлээ хийхийн өмнө, *мөн* шалгалт өгөхийн өмнө залбирч бай.
- Сайн бэлд; шалгалт өгөхөөсөө өмнө өөрийн гэсэн шалгалтыг бэлтгэж, хий.
- Шалгалт өгөх үедээ цагаа зөв зохицуул; мөн шалгалтаа өгч эхлэхдээ асуулт бүрд ямар хугацаа зарцуулахаа шийд.
- Зааврыг анхааралтай дахин дахин уншаад, яг юу хийлгэхийг хүсэж байгааг нь олж мэд;
- Хамгийн хялбар асуултуудад эхэлж хариулан, өөртөө итгэлтэй бол. Дараа нь эргэж бусад асуулт руу ор.
- Буруу хариулт өгвөл оноо хасагдах эсэхийг асуу; үгүй бол таа.

### БИ БАГШИЙН ШААРДЛАГЫГ ХЭРХЭН БИЕЛҮҮЛЭХ ВЭ?

**Ярилц:** Багшийнхаа шаардлагыг мэдэж, биелүүлэх нь яагаад чухал вэ?

**Дадлага хий:** Бүлгийн өөр нэгэн гишүүн рүү хар. Та хоёрын нэг нь багшийн, нөгөө нь суралцагчийн дүрд тоглоно. Суралцагч доорх асуултуудыг багшаасаа асууна. Багш нар хариултыг зохиож болно. Дараа нь дүрээ сольж, дахин хий.

1. Би таны ангид хэрхэн амжилттай суралцаж болох вэ?
2. Та биднээс ямар зүйлийг сураасай гэж хүсэж байна вэ?
3. Та миний гүйцэтгэлийг хэрхэн дүгнэх вэ?
4. Та ямар зүйлийг хамгийн их үнэлдэг вэ? Оролцоо, шуурхай байдал, бэлтгэлийн аль нь вэ? Эсвэл өөр зүйл үү?

**Ярилц:** Та энэ сэдвээр дадлага хийсэн тул одоо үүнийг жинхэнэ багштайгаа хийж чадах уу? Та үүнийг хэзээ хийх вэ?



# ТУНГААН БОД

## БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

**Цаг:** Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр судар хуваалцаныг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

---

---

---

---

---

---

---

**Ярилц:** Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

*“Гуй, тэгвэл энэ нь та нарт өгөгдөх болно; эрэлхийл, тэгвэл та нар олох болно; +ТОГШ ТЭГВЭЛ ЭНЭ нь та нарт нээгдэх болно.”*

**3 НИФАЙ 14:7**





# АМЛАЛТ ӨГ

## БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

**Цаг:** Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

---

*Хамтрагчийн нэр*

---

*Холбоо барих мэдээлэл*

**Амлалтаа нэг нэгээр нь хамтрагчдаа чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.**

### МИНИЙ АМЛАЛТУУД

Би итгэлээр хэрхэн суралцах талаар гэр бүлийнхэндээ эсвэл найз нөхдөдөө зааж өгнө.

Би өдөр болгон ангидаа судалж суралцах үндсэн зарчмуудаар дадлага хийнэ.

Зээл авах хэрэгтэй бол би ТБС-аас зээл авах асуудал дээр үргэлжлүүлэн ажиллана.

Би өнөөдрийн "Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил" товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

---

*Миний гарын үсэг*

---

*Хамтрагчийн гарын үсэг*

## БИ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

**Дадлага хий:** Дараагийн цугларалтын өмнө гаргаж буй ахицаа тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх зайд “Тийм”, “Үгүй” гэж, эсвэл амлалтаа биелүүлсэн тохиолдлынхоо тоог бич.

Гэр бүлийн-хэндээ, эсвэл найз нөхдөдөө итгэлээр хэрхэн суралцах талаар заасан (Тийм/Үгүй)	Ангид судалж суралцах бүх үндсэн зарчмаар өдөр бүр дадлага хийсэн (Тийм/Үгүй)	Хэрэв надад зээл хэрэгтэй бол би ТБС-аас зээл авах асуудал дээр үргэлжлүүлэн ажилласан (Тийм/Үгүй)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил,” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийн-хэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгалам-жиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)

**Унш:** Түүнчлэн хувийн орлого, зарлагаа “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлын арын хуудсан дээр тэмдэглэхээ битгий мартаарай.

Дараагийн цугларалтаар бид илүү бие дааж чадсан эсэхийг мэдэхийн тулд бие даасан байдлын үнэлгээг давтан хийнэ. Бид “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлоо авчрах хэрэгтэй.

Дараагийн цугларалтад “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын нэг сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. (“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын сэдвээр хэрхэн зохицуулагч хийхээ мэдэхгүй байна уу? 17-р хуудсыг болон хавтасны нүүр хуудасны дотор талыг уншина уу).

Хэн нэгнээс хаалтын залбирал хийж өгөхийг хүс.

### Санал хүсэлт

Санал, сэтгэгдэл, санаа бодол болон туршлагаа [srsfeedback@ldschurch.org](mailto:srsfeedback@ldschurch.org) хаягаар илгээнэ үү.

### Зохицуулагчийн анхааралд:

Дараагийн цугларалтад “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлын таван хувийг илүү авч ир.

# Эх сурвалж

## ГАРГАСАН АХИЦАА ТАЙЛАГНАХ НЬ

Дүрүүдийг сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

**ЗОХИЦУУЛАГЧ:** Одоо бид ямар ахиц гаргаснаа тайлагнана. Робэрт, та эхлэх үү?

**РОБЭРТ:** За, тэгье. Эхнийх нь “Би яагаад бие даасан байхыг хүсэж байна вэ?” гэсэн асуулт байна. Та бүхэн миний нөхцөл байдлыг мэднэ. Би гэр бүлтэй, үүрэг хариуцлага ихтэй тул сайн ажилд орох хэрэгтэй. Би үнэхээр бие даан, гэр бүлээ тэжээж, дуудлагадаа илүү сайн үйлчлэхийг хүсэж байна.

**РОБЭРТ:** Дараагийн асуулт бол “Би ямар орлоготой байх хэрэгтэй вэ?” Төсвөө тооцоолох үйл явцыг авч үзсэн нь бидэнд их хэрэгтэй байсан. Бид одоогийн байгаагаасаа хоёр дахин илүү орлоготой болох хэрэгтэй юм байна лээ. Энэ нь ч зүгээр, бүх юм болж бүтнэ гэж бодож байгаа.

**РОБЭРТ:** Дараа нь “Ирээдүйд ямар төрлийн ажил тэр орлогыг авчрах вэ?” Би орчуулгын ажил зүгээр гэж бодож байгаа. Би одоо хоёр хэлээр ярьдаг. Ажлын цаг нь ч гэсэн уян хатан.

**МЭКАЛА:** Наадах чинь санал болгосон ажлын жагсаалтад байгаа юу?

**РОБЭРТ:** Тийм, байгаа. Энэ ажлын эрэлт хэрэгцээ их, маш хурдацтай өсөж байгаа.

**РОБЭРТ:** За тэгэхээр, “Надад ямар дадлага туршилага хэрэгтэй вэ?” Би өөрийн хэлний ур чадварыг сайжруулах хэрэгтэй. Үүнээс гадна, би техникийн болон бизнесийн ур чадварт суралцах хэрэгтэй. Би бас ажлын байран дээр явагддаг сургалтад хамрагдах хэрэгтэй гэдгийг олж мэдсэн.

**КВАМЭ:** Та тийм сургууль олсон уу?

**РОБЭРТ:** Олсон! Хөтөлбөр ба сургуулийн аль аль нь Санал болгосон сургууль, хөтөлбөрийн жагсаалтад орсон байна лээ. Би Лингуа Сэлери сургуулийн орчуулагчийн дээд түвшний сургалтад сууж болох байх гэж найдаж байна. Тэдний төгсөгчдийн ажилд орсон үзүүлэлт өндөр, ажлын байран дээрх сургалтад

хамрагдах боломжтойгоос гадна харилцаа холбоо сайтай юм байна лээ.

**ЖАНИЯ:** Хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа ба төлбөр хэд вэ?

**РОБЭРТ:** Ажлын байран дээрх сургалттайгаа нийлээд хоёр жилийн хөтөлбөр юм байна лээ. Би дуудлагаа хийхийн тулд сургалтдаа оройн цагаар сууна. Бид сургалтын төлбөрийнхөө хагасыг төлж чадна, харин үлдсэнд нь ТБС-ийн зээл авах хэрэгтэй.

**ЗОХИЦУУЛАГЧ:** Сайхан сонсогдож байна, Робэрт. Чамд үүнтэй холбоотой асуудал эсвэл асуулт байна уу?

**РОБЭРТ:** Үнэнийг хэлэхэд, эхнэр бид хоёр Сүмийн дуудлага, гэр бүлээсээ хол өнгөрүүлэх цагийн талаар санаа их зовсон л доо. Гэхдээ бид хүүхдүүдийнхээ саналыг асуухад бүгд дэмжиж байсан. Миний орлого бараг гурав дахин нэмэгдэх боломжтой болох юм.

**ЗОХИЦУУЛАГЧ:** Сайн тайлан байлаа. Робэртод өгөх санал хүсэлт юм уу, зөвлөх зүйл байна уу?

**ЖАНИЯ:** Танай сургууль руу унаа сайн явдаг уу, мөн та эдгээр зардлаа хэрхэн төлөх гэж байгаа вэ?

**РОБЭРТ:** Ирэх, очих замдаа хэд хэдэн автобус дамжин суух хэрэгтэй, харин зардлаа хэрхэн төлөх талаар бодож байгаагүй юм байна. Тийм болохоор сануулсанд баярлалаа.

**КВАМЭ:** Би чамайг сайн орчуулагч болно гэж бодож байна. Чи их хурдан сэтгэдэг, бас хэл яриа сайтай юм. Сургуульд сурч байх үедээ орчуулгын ажил хийж, туршилага хуримтлуулах боломжтой юу?

**РОБЭРТ:** Наадах чинь харин ёстой сайхан санаа байна. Та нарт энэ талаар мэдэж байгаа зүйл байна уу?

**82-р хуудас руу буцаж оч**

## БОЛОВСРОЛ БОЛ БОЛОМЖИЙГ НЭЭХ ТҮЛХҮҮР ЮМ

Дараах мэдэгдлүүдийг ээлжлэн унш.

### Томас С.Монсон

“... Би та нарыг хэрэгцээгээ хангахад бэлтгэгдсэн байхын тулд боловсролтой болж, шаардлагатай ур чадварыг эзэмшээсэй хэмээн урамшуулмаар байна. Судалж, суралцах тусам авьяас билэг тань өсөн нэмэгдэх болно. Та үр хүүхдүүддээ суралцахад нь илүү сайн тусалж чадах бөгөөд өөрийгөө бэлтгэлтэй байлгаж чадсан гэдгээ мэдэж байгаа учраас оюун ухаан тань амар амгалан байх болно” (“Be Thou an Example,” Ensign, 2001 оны 11-р сар, 99).

### Гордон Б.Хинкли

“Та нар одооноос эхлэн өөрийн эзэмшиж болох бүх боловсролыг олж авахаар төлөвлөж, дараа нь уг төлөвлөгөөгөө биелүүлэхээр ажиллах хэрэгтэй. Амьдралдаа алсын бодолтой хандаж сур” (“Four B’s for Boys,” Ensign, 1981 оны 11 сар, 40).

### Сургаал ба Гэрээ 130:18

“Бид энэ амьдралд оюун билгийн ямар ч түвшинд хүрлээ гэсэн, энэ нь амилуулалтад бидэнтэй хамт сэргэн босох болно.”

### Сургаал ба Гэрээ 88:78-80

“Та нар онолд, зарчимд, номлолд, сайн мэдээний хуулинд, та нарын ойлголтод шаардлагатай Бурханы хаант улсад хамаардаг бүх зүйл илүү төгс зааварлагдаж болохын тулд хичээнгүйлэн заагтун та нар, мөн миний ач ивээл та нартай байх болно; ... Та нарыг бибээр дуудсан тэрхүү дуудлагыг, би та нарт итгэмжилсэн тэрхүү үүрэг даалгаврыг хичээнгүйлэн гүйцэтгүүлэхээр би та нарыг дахин илгээхэд та нар бүх зүйлд бэлтгэгдэж болохын тулд буюу.”

84-р хуудас руу буцаж оч

## БОДИТ АМЬДРАЛААС ОЛЖ АВАХ БОЛОВСРОЛ

Бүлгийн бусад гишүүнийг 85-р хуудас дээрх тэмдэглэлийг харж байх үед нэг гишүүнээс үүнийг уншихыг хүс.

### ХЭНРИ Б.АЙРИНГ

Есүс Христийн сайн мэдээнд хөрвөгдөх нь сурч мэдэх хүсэл эрмэлзлийг өгдөг.

. . . Энэ нь Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдарсны жинхэнэ үр жимс юм.

. . . Бид Бурханд болон Түүний хүүхдүүдэд илүү сайн үйлчлэхийг үргэлжлүүлэн эрэлхийлбэл, энэ нь хамгаас үнэтэй адислал болно. . . .

Их Эзэн ба Түүний Сүм нь Түүнд болон Түүний үр хүүхдүүдэд үйлчлэх чадварыг маань хөгжүүлэхийн тулд мэдлэг боловсролтой болохыг үргэлж дэмжиж байдаг билээ. Түүнд бидний ямар авьяас чадвартай байхаас үл хамааран, хүн нэг бүрээр хийлгэх үйлчлэл бий. Мөн энэ үйлчлэлийг сайн хийх нь эрдэм мэдлэгтэй байхтай нэг удаа юм уу, нэг хэсэг хугацаагаар биш, харин үргэлж холбоотой байдаг.

. . . Бид залбирч, мацаг барьж, хөдөлмөрлөснөөр, мөн Түүнд үйлчлэх санаа сэдэлтэй байснаар Түүний ач ивээлийг өөрсөд дээрээ хүлээн авна. . . . [Энэ] нь бид үүнд дан ганц өөрийн төрөлх чадавхаас илүү хурдан суралцаж, үр чадвараараа түүнийг илүү их хөгжүүлж чадна гэсэн үг юм. . . .

Бидний хамгийн түрүүнд хийж сурах ёстой зүйл бол сүнслэг суралцахуй юм. . . . Та нар боловсролыг зөвхөн энэ зуурдын амьдралд зориулж биш, бас мөнх амьдралдаа зориулан эрэлхийлж байгаа болно. Та нар энэ бодит үнэнийг тодорхой хардаг болсон цагт, сүнслэг суралцахуйг нэгдүгээрт тавьж, шашны

бус боловсролоо ч мөн адил орхигдуулахгүй. Үнэндээ та тэрхүү сүнслэг үзэгдлийг харсан учраас шашны бус боловсролдоо илүү их анхаарал хандуулах болно. . . .

. . . Их Эзэн та нарын хийх ёстой зүйлийг төдийгүй, уг зүйлийг хийхийн тулд та нар юу мэдэх хэрэгтэйг аль алиныг нь мэднэ. Тэр танд суралцах боломжуудыг бэлтгэсэн байгаа гэдэгт та итгэлтэй байж болно. . . .

Бидний сурч боловсрох аян хэзээ ч төгсөх ёсгүй. . . . Бидний амьдрахаар бэлтгэгдэж буй жинхэнэ амьдрал бол мөнх амьдрал мөн. . . . Бурхан, бидний Тэнгэрлэг Эцэг Өөрийн амьдарч буй амьдралаар биднийг амьдраасай хэмээн хүсдэг гэдэгт бид итгэдэг. Бидний энэ амьдралдаа сурч мэдсэн бүх зүйл амилуулалтаар бидэнтэй хамт сэргээгдэх болно гэдэг нь үнэн билээ. Түүнчлэн бидний сурч мэдсэн бүх зүйл бидний үйлчлэх чадварыг нэмэгдүүлнэ. . . .

Та бүхэн Их Эзэн Багш, бидний Аврагч Есүс Христэд талархалтай байгаасай хэмээн би залбирч байна. Та нар хайрт Тэнгэрлэг Эцэгийнхээ үр хүүхдүүддээ өгөөсэй хэмээн та бүхнээс хүсэж байгаа тэрхүү агуу үйлчлэлийг мэдрээсэй, мөн Түүний та нарт зориулан бэлдсэн суралцах боломжуудыг хараасай хэмээн би залбирч байна. (“Real-Life Education,” New Era, 2009 оны 4-р сар, 2–8)

**85-р хуудас руу буцаж оч**

## СУРАЛЦАХУЙ БА ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮД

Бүлгийн бусад гишүүнийг 86-р хуудсан дээрх тэмдэглэл хөтлөх дасгалыг хийж байх үед нэг гишүүнээс үүнийг чанга уншихыг хүс.

### ДАЛЛИН Х.ӨҮКС, КРИСТЭН М.ӨҮКС НАР

Бид хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд боловсролд итгэдэг. . . Манай шашин бидэнд Сүнсээр суралцахыг эрэлхийлэх, хүн төрөлхтний ашиг тусын тулд мэдлэгээ ашиглах үүрэг хариуцлагатай хэмээн сургадаг. . . [Тэнгэрлэг Эцэгийн] Сүнс нь сурч боловсрох гэсэн бидний хүчин чармайлтыг чиглүүлэн эрчимжүүлж, үнэнийг ойлгох чадварыг нэмэгдүүлж чадна. . . .

Бид Ариун Сүнсний удирдамжийг хүлээн авахын тулд суралцах хүчин чармайлтаа хувийн зохистой байдалтайгаа хослуулсан байх ёстой. . . Нүгэл нь Их Эзэний Сүнсийг зайлуулдаг бөгөөд энэ тохиолдолд Сүнсний онцгой гэрэл алга болж, сурч мэдэх хүсэл эрмэлзэл сулардаг байна. . . .

. . . Хэрэв бид зохистой байж, бие сэтгэл бүхнээ Бурханы алдар сууд зориулах юм бол, бидний “бүхэл бие гэрлээр дүүргэгдэх болно, мөн бидэнд харанхуй байх нь үгүй; мөн гэрлээр дүүргэгдсэн тэрхүү бие бүх зүйлийг ухамсарладаг бөлгөө” (С ба Г 88:67) гэсэн амлалтыг бидэнд өгсөн байдаг билээ. . . .

. . . Наманчлал нь Есүс Христийн цагаатгагч золиослолоор дамжуулан биднийг нүглээс цэвэршүүлдэг учраас, Ариун Сүнсний заах хүчээр дамжуулан гэрэл ба үнэнийг эрэлхийлдэг бүх хүний сурч боловсрох замдаа хийх ёстой нэн чухал алхам мөн. . . .

Бид сурч боловсрох сонголтгоо хийхдээ өөрсдийгөө болон биднээс хамааралтай байж болох бүх хүнийг дэмжихэд бэлэн байх ёстой. Зах зээлд хэрэгтэй ур чадвар, мэргэжлийг эзэмших нь маш чухал юм. Боловсрол нь хувь хүний аюулгүй байдал,

сайн сайхан амьдралд зайлигүй хэрэгтэй зүйл.

Бидний Тэнгэрлэг Эцэг биднээс сонгох эрх ба сүнсний нөлөөг ашиглан, өөртөө болон өөрийн ур чадварт дүгнэлт хийж, ямар боловсрол эзэмших нь дээр болох талаар шийдвэр гаргахыг хүсэж байдаг. . . . Патриархын адислалаа уншиж, өөрсдийн төрөлх чадавх, авьяас чадварын талаар эргэцүүлэн бодож, урагшил. Эхний алхмаа хий, тэгсэн цагт үүд хаалгууд нээгдэх болно. . . . Их Эзэнтэй хамт байхад “бүхий л зүйл эцэстээ тэдний сайн сайхны төлөө байдаг” (Ром 8:28) гэдгийг мэдэх болно. . . .

Бидэнд зорилгодоо хүрэхийн тулд тэмцэх үе тулгарах боловч, бидний тэмцэл олж авсан мэдлэгтэй минь адил өсөлт хөгжлийг бидэнд авчрах юм. Сорилтуудыг даван туулах явцдаа хөгжүүлсэн чадварууд маань үүрд мөнхөд бидэнтэй хамт байх болно. . . .

Хамгийн чухал нь, бид судруудыг болон Сүмийн ном зохиолуудыг уншиж, Сүмд болон ариун сүмд явснаар сүнслэг боловсролоо байнга хөгжүүлж байх үүрэгтэй. Амьдралын үгс дээр найрлах нь бидний амьдралыг баяжуулан, хайрладаг хүмүүстээ заах чадварыг маань хөгжүүлж, биднийг мөнх амьдралд бэлтгэнэ.

Боловсролын эцсийн зорилго бол биднийг хаант улс дахь илүү сайн эцэг эх, үйлчлэгч болгох явдал мөн. . . . Боловсрол бол Бурханаас ирдэг бэлэг. Бид үүнийг бусдын ашиг тусын төлөө ашиглах юм бол энэ нь манай шашны тулгуур чулуу болдог билээ. (“Learning and Latter-day Saints,” *Liahona*, 2009 оны 4-р сар, 26–31)

**86-р хуудас руу буцаж оч**







## 6

*Би ангиас гадуурх  
орчинд хэрхэн  
амжилтад хүрэх вэ?*


---

**Илүү сайн ажлын төлөө сурч  
боловсрох нь**

# ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

## Цугларалт хийх өдөр:

- Бүлгийн гишүүд рүү мессеж илгээ, эсвэл утсаар ярь. Тэднийг цугларалт эхлэхээс 10 минутын өмнө ирж, амлалтаа хэрхэн биелүүлсэн талаар тайлагнахад урь.
- “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлын таван хувийг илүү авч ир.
- Бид дараагийн зургаан цугларалтаар “Ажил хайх нь” номыг хэрэглэнэ. Энэ цугларалтаар гишүүдэд харуулах зорилгоор хэдэн хувийг авч ир.



ШИНЭ!

ШИНЭ!

## Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойрхон суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
- Энэ амлалтын хүснэгтийг самбар дээр зур.

Бүлгийн гишүүний нэр	Гэр бүлийнхэндээ, эсвэл найз нөхдөдөө хэрхэн итгэлээр суралцах талаар заасан (Тийм/Үгүй)	Ангид судалж суралцах бүх үндсэн зарчмаар дадлага хийсэн	Хэрэв надад зээл хэрэгтэй бол ТБС-аас зээл авах дээр үргэлжлүүлэн ажилласан (Тийм/Үгүй)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)
Глория	Т	Т	Ү	Т	Т	Т

## Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Хүмүүсийг орж ирэхэд дотно хүлээж авч угт.
- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд, тэднээс самбар дээрх амлалтын хүснэгтийг бөглөхийг хүс.
- Цаг бүртгэгч томил.

## Цугларалт эхлэх үед:

- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Нээлтийн залбирал хий (хүсвэл дуулал дуулж болно).
- Хүмүүсийг ярилцаж байх хооронд, хоцорч ирсэн хүмүүсээс гар утсаа унтрааж, амлалтын хүснэгтээ бөглөхийг нам дуугаар хүс.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимол дээр ажиллахад 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын 6-р зарчмыг үзэж дуусга. Дараа нь энэ дасгалын номны дараагийн хуудаснаас үргэлжлүүлэн унш.



# ТАЙЛАГНА

## БИ ӨГСӨН БҮХ АМЛАЛТАА БИЕЛҮҮЛСЭН ҮҮ?

**Цаг:** Тайлагна хэсэгт 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Амлалтаа тайлагнацгаая. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлсэн хүмүүс босно уу. (Алга таш.)

**Унш:** Одоо бүгдээрээ бос. Бид өгсөн бүх амлалтаа биелүүлэхийг хичээх ёстой. Энэ бол бие даасан хүмүүсийн эзэмших чухал дадал хэвшлийн нэг болно. Бүгдээрээ бүлгийнхээ уриаг хамт уншицгаая.

**“Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө.”**

*Сургаал ба Гэрээ 104:15*

**Бид Их Эзэнд итгэх итгэлтэйгээр бие даахын тулд хамт ажиллаж байна.**

**Унш:** Сууцгаая.

**Ярилц:** Энэ долоо хоногт та нар өгсөн амлалтаа биелүүлж байхдаа юу сурч мэдэж авсан бэ? Танд бүлгийн зүгээс ямар нэгэн туслалцаа хэрэгтэй байсан уу?



# СУРАЛЦ

## БИ АНГИАС ГАДУУРХ ОРЧИНД ӨӨРИЙГӨӨ ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

**Цаг:** Судал хэсэгт 60 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Унш:** Бид өнгөрсөн долоо хоногт хэрхэн итгэлээр суралцах, мөн ангидаа хэрхэн судалж суралцах талаар ярилцсан. Энэ долоо хоногт бид ангиас гадуурх орчинд өөрийгөө хэрхэн бэлтгэх талаар ярилцана.

1 дэх долоо хоног	2 дахь долоо хоног	3 дахь долоо хоног	4 дэх долоо хоног	5 дахь долоо хоног	6 ДАХЬ ДОЛОО ХОНОГ
Ямар төрлийн ажил бие даахад маань туслах вэ?	Ямар боловсрол миний ажлын шаардлагыг хангах вэ?	Сургалтын төлбөрөө хэрхэн төлөх вэ?	Би Тасралтгүй Боловсролын Сангаас зээл авах хүсэлт гаргах хэрэгтэй юү?	Би ангид байхдаа хэрхэн амжилттай суралцах вэ?	Би ангиас гадуурх орчинд хэрхэн амжилтад хүрэх вэ?

**Унш:** Энэ долоо хоногт бид энэ асуултын хариултыг олох бөгөөд дараах үйлдлийг хийнэ:

**Унш:** **ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН АСУУЛТ—Би ангиас гадуурх орчинд хэрхэн амжилтад хүрэх вэ?**  
**ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ—Би өөрийн сүнслэг бэлтгэлийг хүчирхэгжүүлэн, бусадтай хамтарч ажиллах, даалгавар хийж гүйцэтгэх зэрэг суралцах ур чадвар, дадал хэвшлээ сайжруулна.**

## БИ ХЭРХЭН СҮНСЛЭГ БАЙДЛААР ӨӨРИЙГӨӨ БЭЛТГЭХ ВЭ?

**Унш:** Боловсрол олж авахыг эрэлхийлэх нь бидэнд илүү их боломж олгоно. Бид бүх зүйлийн үнэн мөн чанарыг мэдэгч Ариун Сүнсийг дагаж чадна! Бид хэчнээн завгүй байсан ч, өдөр бүр сүнслэг байдлаар өөрийгөө бэлтгэхэд цаг зав гаргах ёстой. Тэгсэн цагт Сүнс бидэнд илүү хурдан суралцаж, илүү их зүйлийг санаж тогтооход тусална.

**Үз:** “Сүнслэг байдлын хувьд бэлэн байх” (Видео бичлэг байхгүй бол 112-р хуудсыг унш.)

**Ярилц:** Бид Сүнсний удирдамжийг хүлээн авах шаардлагыг хэрхэн хангах вэ? Сүнс нь бидэнд суралцахад хэрхэн туслах вэ?

**Унш:** Эдгээр нь сүнслэгээр бэлтгэхэд туслах хүчин зүйлс болно:

- Өглөө болгон, орой бүр залбир. Хичээлээ хийхийн өмнө болон дараа нь залбир. Тэнгэрлэг Эцэгээс бидний оюун ухаан, хүчин чармайлтыг адислахыг хүс;
- Өдөр бүр судруудаас унш.
- Зарлигуудыг дага. Өөрсдийгөө цэвэр ариун байлга.
- Бусдад үйлчил. Бусдыг бидэнтэй хамт суралцахад нь тусал.

**Дадлага хий:** Доорх хүснэгтэд сүнслэгээр өөрийгөө бэлдэж, хичээл сургуульдаа амжилт гаргахад тань туслах зарчмууд орсон байгаа.

Та дараах зүйлсийг хэр сайн хийж байгаа тухай бод. Сайжрах арга замуудыг бич.

Би Сүнс надад тусалж, надаар дамжуулан ажиллаж байгааг мэдэрдэг.

Миний суралцах хүсэл эрмэлзэл, сурч боловсрох хүсэл, мөн сурах чадвар өсөж байгаа.

Би Бурханы тушаалуудыг дагаж, үр дүнтэй суралцах зарчмуудыг хэрэгжүүлдэг.

Би өдөр болгон суралцдаг. Би цагаа төлөвлөж, төлөвлөгөөгөө дагадаг. Би даалгавраа цаг тухайд нь хийж гүйцэтгэдэг.

Би Христийнхтэй адил зан чанарыг хөгжүүлж, мөн бусдад тэдгээрийг хөгжүүлэхэд нь тусалдаг.


“Бид энэ дэлхийд мөнх амьдралд бэлдэхээр, хэрхэн суралцах талаар суралцахаар, зуурдын амьдралд чухал болон мөнх амьдралд зайлшгүй шаардлагатай зүйлсийн талаар суралцахаар, мөн бусдад мэргэн ухаан хийгээд үнэний талаар сурч мэдэхэд нь туслахаар ирсэн болно [С ба Г 97:1-ийг үзнэ үү].”

**ДЭВИД А.БЭДНАР,**  
“Learning to Love Learning,” *Ensign*, 2010 оны 2-р сар, 27

**Ярилц:** Бидний хүн нэг бүр сүнслэг байдлаараа илүү сайн бэлтгэлтэй байхын тулд ямар амлалт өгөх ёстой вэ? Бид эдгээр амлалтыг биелүүлэхэд бие биедээ хэрхэн тусалж болох вэ?

## БИ АНГИАС ГАДУУР ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

**Унш:** Эдгээр нь ангиас гадуурх орчинд бэлтгэх явцад амжилтад хүргэх дөрвөн хүчин зүйл болно. Бид тэдний тухай нэг бүрчлэн суралцана.



## БИ ҮР ДҮНТЭЙ СУРАЛЦАХАА ХЭРХЭН ТӨЛӨВЛӨХ ВЭ?

**Ярилц:** Хаана, хэзээ суралцахаа төлөвлөх нь яагаад чухал вэ? Цагаа нарийвчлан зохицуулах нь яагаад чухал вэ?

**Дадлага хий:** Бүлгийн өөр нэг гишүүнтэй хамтар. Та нар сургууль эхэлсний дараа хэзээ, хаана хичээлээ хийж байх талаар шийдвэр гаргахад нэг нэгэндээ тусал.

1. Та нар өдөр болгон хичээлээ хийж байх цэвэр цэмцгэр, нам гүм газар олж чадах уу? Та хаана хичээлээ хийж байх вэ? \_\_\_\_\_
2. Та өдөр бүр тогтсон цагт хичээлээ хийж байхаар төлөвлөж чадах уу?

Да. \_\_\_\_\_ Мя. \_\_\_\_\_ Лха. \_\_\_\_\_

Пү. \_\_\_\_\_ Ба. \_\_\_\_\_ Бя. \_\_\_\_\_

**Дадлага хий:** Бүлгийн өөр нэгэн гишүүнтэй хамт өдөр болгон хичээлээ хийхэд тань саад болох аливаа асуудлыг жагсаан бич. Эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар шийд гарга.

### ЯМАР ЗҮЙЛ НАДАД ХИЧЭЭЛЭЭ ХИЙХЭД СААД БОЛОХ ВЭ?

*Хөршүүд чимээ шуугиан гаргах*

.....

.....

.....

### БИ ЭНЭ АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ ВЭ?

*Үдээс хойш 3-5 цагийн хооронд чимээ гаргахгүй байхыг тэднээс эелдэгхэн хүс.*

.....

.....

.....



## БИ АНГИАС ГАДУУР ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

**Унш:** Зарим хүн бүлэг дотор сайн суралцдаг. Манай бие даах чадвар хөгжүүлэх бүлэг бол үүний сайн жишээ!

**Ярилц:** Ямар зүйл манай бие даах чадвар хөгжүүлэх бүлгийг суралцах сайн газар болгож байгаа вэ? Манай бүлэг та бүхнийг хариуцлагатай байж, үйлдэхэд тань хэрхэн тусалж байна вэ?

**Унш:** Бид сургуульд суралцаж байхдаа ихэвчлэн ангийнхныхаа дунд байдаг. Тэд ч мөн адил суралцахыг хүсдэг. Хэрэв бид зөв хүнээ олж чадах юм бол, тэд бидэнд, бид тэдэнд суралцахад нь тусалж чадна.

**Ярилц:** Үр дүнтэй суралцахад нөлөөлөх эдгээр хүчин зүйлийн талаар ярилц. Та нар суралцах бүлгээс ихийг сурч мэдсэн тохиолдлынхоо талаар ярилц. Их зүйл сурч мэдээгүй тохиолдлынхоо талаар ярилц. Юугаараа ялгаатай байсан бэ?

- Хамт ажиллахад хамгийн сайн суралцагчдыг—ялангуяа тантай адил сурч мэдэх хүсэл эрмэлзэлтэй нэгнийг ол.
- Хамтдаа хичээлээ тогтмол давтаж байх цагийг товлло.
- Хичээлээ хийж эхлэхийн өмнө тодорхой зорилго дээр санаагаа нэгтгэ.
- Хичээл хийж дуусах үед хоёулаа юу хийх, хэзээ хийж дуусах талаар амлалт өг.
- Хамтдаа цагийг сайхан өнгөрүүл. Гэхдээ гол зүйлдээ анхаарлаа хандуул.
- Бэлтгэлтэй байж, өөрийн зүгээс хийх ёстой зүйлээ хийж бай. Бүлгийн гишүүддээ суралцахад нь тусал. Тэднээс боломжтой бүх зүйлийг сурч ав.

**Дадлага хий:** Та өөрийн суралцах арга барилыг сайжруулахын тулд суралцах бүлгийг хэрхэн ашиглаж болох вэ? Өөрийн бодол санааг бичиж аваад, хэрэгжүүл.



## БИ УНШСАН ЗҮЙЛЭЭ ХЭРХЭН ОЙЛГОЖ, ТОГТООН АВАХ ВЭ?

**Унш:** Бид сургуульд орвол их зүйл унших хэрэгтэй болно. Бид уншсан зүйлээ ойлгож, тогтоохын тулд олон зүйл хийж чадна.

- Ярилц:** Та нарт уншсан зүйлээ ойлгон, тогтоож, хэрэгжүүлэхэд тань туслах дараах алхмын талаар ярилц.
1. Залбир. Та ойлгож, тогтооход тань туслахыг Сүнснээс хүс.
  2. Тоймлон бич. Уншсан зүйлийнхээ гол утга санааг бич. Дараа нь утга агуулгыг дэмжих үзэл санаа, баримт мэдээлэл, тоо хэмжээ зэргийг нэмж бич. Тэдгээр тэмдэглэлийг тухайн өдрөө, долоо хоногийн болон сарын дараа дахин эргэн харж унш.
  3. Хэрэв та сурах бичигтэй бол чухал ба мэдэхгүй үгсийн доогуур зур. Үгсийн тодорхойлолтыг хажуу талын зайд бич.
  4. Хажуу талын зайд бичиж, тэмдэглэл хий. Хоорондын уялдаа холбоо ба үйл явцыг харуулан зур. Шинэ мэдээллийг мэддэг зүйлтэйгээ уялдуулан холбо.
  5. Өөрөөсөө шалгалт ав. Энэ мэдээллийг ашиглаж, хэрэгжүүлэх арга замыг ол.

**Дадлага хий:** Бүлгээрээ энэ нийтлэлийг үз. Уншигч дээрх бүх санааг хэрхэн ашигласан байна вэ? Дараагийн хуудсан дээрх уншигчийн хичээлийн тоймыг авч үз. Та үр дүнтэй унших талаар юу сурч мэдсэн бэ?

### ГУРВАН СОНГОЛТ

*Ерөнхийлөгч Томас С. Монсон*

Сүүлийн үед би сонголт ба түүний үр дүнгийн талаар их бодож байна. . . . Би сонголтын талаар тунгаан бодсоны эцэст түүнийг гурван бүлэгт хуваасан юм. Эхнийх нь сонголтын эрх; удаах нь сонголтын хариуцлага; гурав дахь нь сонголтын үр дүн юм. . . .

Миний эхэнд хэлсэн нь сонголтын эрх юм. Тэнгэрлэг Эцэг маань бидэнд сонгох эрх буюу сонголтын эрхийг өгсөнд би маш их талархдаг. . . . Бид энэ дэлхийн үүслээс өмнө сонгох эрхтэй байсан бөгөөд Люцифер үүнийг биднээс салган авахыг оролдсоныг бид мэднэ. . . . Аврагчийн төлөвлөгөөг сонгосон бид дэлхий дээр гэм нүгэлд автан бүдчиж, ингэснээр Эцэгээс тусгаарлагдан, хэцүү замаар бэдэрнэ гэдгээ ч мэдэж байсан. Гэвч Сүнсээр төрсөн Ууган Хүү Өөрийгөө бүгдийн төлөө золиослол болгохоор өгсөн юм. . . . Бид ямар ч нөхцөл байдалд хумигдан орлоо ч, үргэлж сонгох эрхтэйгээ байх болно.

*Залбирал: Надад энэ захиасыг сонсох хэрэгтэй байсан гэсэн мэдрэмж төрсөн.*

*“Сонгох эрх” бол сонголт хийх эрх юм.*

*Нүгэлээ наманчилбал, Цагаатгал буруу сонголтуудыг засаж залруулна.*

**ГУРВАН СОНГОЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)**

Дараа нь сонгох эрхтэй хамт сонголтын хариуцлага ирдэг. . . . Тэнгэрлэг Эцэг маань биднийг энэхүү мөнхийн аян замд гаргахдаа мөнх бус амьдралын дараа Түүнд эргэн ирэхэд туслах бурханлаг тусламжуудыг өгсөн. Би энд залбирлын талаар ярьж байна. Мөн бидэнд байдаг намуун бөгөөд зөөлөн шивнээний тухай ярьж байна. Түүнчлэн бидний өмнө явж, бидний туулах амьдралын их далайг амжилттай гатлан гарсан далайчдын үгс болох ариун судруудын талаар би ярьж байна. . . . Сонголтууд маань үнэхээр бидний хувь тавиланг тодорхойлдог. . . .

Эцэст нь . . . би сонголтын үр дагаврын талаар ярья. Бидний сонголт бүр үр дагавартай. . . . Та нар бол тэнгэрийг өвлөгчид юм. Тэнгэрлэг Эцэгийн хаант улсад мөнх амьдралыг хүртэх нь та нарын зорилго билээ. Энэхүү зорилгод нэг удаагийн бахдам оролдлогоор бус, харин амьдралын туршид хуримтлуулсан ухаалаг сонголтууд, зөвт байдал, хөдөлшгүй зорилгоор хүрдэг юм. . . .

. . . Бид бүгд сонгох эрх чөлөөндөө талархалтай байж, сонголтын хариуцлагыг өөр дээрээ авч, сонголтын үр дүнд болгоомжтой байцгаая. . . . Бид Их Эзэн, Есүс Христийн ажилд гар бие оролцож байгаа. Эрт цагийн тэр хүмүүсийн адилаар Тэр биднийг дуудахад бид хариулсан юм. Бид Түүний даалгаврыг биелүүлж байгаа билээ. (Ensign эсвэл 2010 оны 10-р сарын Ерөнхий Чуулган, 70-73)

Би залбирахдаа илүү анхааралтай сонсож байх хэрэгтэй.

Би үүнийг номлолд байхдаа мэдэж авсан.

Энэ нь миний зорилготой хэрхэн холбогдож байна вэ?

**ТОЙМЫГ СУДАЛ (ХИЧЭЭЛИЙН ДЭВТЭР ДЭЭРХ)**

1. Сонгох эрх

Бидэнд сонгох эрх бий бөгөөд Их Эзэн бидэнд сонголт өгсөн

2. Сонголтын хариуцлага

3. Бидний сонголтын үр дагавар

Сайн сонголтууд хийснээр зорилгодоо хүрнэ

4. Сайн сонголт хийх нь амьдралд чухал

**Дадлага хий:** 113-р хуудсан дээрх “Итгэлээр суралцахыг эрэлхийлэх нь” нийтлэлийг ганцаараа унш. Ойлгож, тогтоож авахыг хичээ. 104-р хуудсан дээрх бүх таван алхмыг хий.

Нийтлэлийг дахин уншилгүйгээр, уншсан зүйлийнхээ талаар энэ шалгалтыг ав. Та ойлгож, тогтоож авахын тулд уншсан уу?

1. Бид итгэлээр суралцахыг эрэлхийлэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ?

---

2. Бидний хүн нэг бүр итгэлээр суралцахыг эрэлхийлэх нь яагаад чухал вэ?

---

3. Иосеф Смит итгэлээр суралцахыг хүсэж байгаагаа хэрхэн харуулсан бэ?

---

**Ярилц:** Та мэдээллийг илүү сайн тогтоохын тулд эдгээр суралцах таван алхмыг хэрхэн ашиглаж болох вэ?

## БИ ДААЛГАВРАА ХЭРХЭН ХИЙЖ ДУУСГАХ ВЭ?

**Унш:** Бид даалгавраа хэрхэн ойлгож, цагт нь хийж дуусгах вэ? Бид хэрхэн хамгийн сайнаараа хийж чадах вэ? Эдгээр нь суралцагч бүрд байдаг асуулт юм.

**Ярилц:** Та даалгавраа ойлгохын тулд юу хийсэн бэ? Танд даалгавраа цагтаа, сайн хийж дуусгахад юу тусалсан бэ?

**Унш:** Сайнаар эхлэх нь ихэвчлэн сайнаар төгсдөг гэдгийг санаж байх нь зүйтэй. Даалгавар хүлээн авсан бол эртнээс төлөвлөж, хийж эхлэх нь зүйтэй!

**Дадлага хий:** Энэ үйл ажиллагааг хийж, өөрийгөө шалга. Мөр болгон дээрх дөрвөн зайны нэгэнд “х” гэж тэмдэглэн, энэ тал дээр хэр байгаагаа шалга. Ахиц гаргахын тулд энэ үйл ажиллагааг долоо хоног тутам давтан хий.

Би даалгавраа бүрэн ойлгох хүртлээ асуулт тавьдаг.	Хэзээ ч үгүй	Заримдаа	Ихэнх тохиолдолд	Байнга
Би даалгавар юм уу, төсөл хүлээн авсныхаа дараа хийж дуусгах огноогоо хуанли дээр тэмдэглэж, хийж дуусгах алхмуудаа төлөвлөдөг.	Хэзээ ч үгүй	Заримдаа	Ихэнх тохиолдолд	Байнга
Би хэрхэн дүгнэгдэх тухай олж мэдэн, амжилтад хүрэхийн тулд өөрөөсөө шаардагдах бүх зүйлийг сурч, хийдэг.	Хэзээ ч үгүй	Заримдаа	Ихэнх тохиолдолд	Байнга
Би даалгавраа цаг алдалгүй хийж дуусгадаг. Би залуурч, хойш суудаггүй.	Хэзээ ч үгүй	Заримдаа	Ихэнх тохиолдолд	Байнга
Боломж гарвал би багштайгаа даалгаврынхаа явцын талаар хуваалцаж, шаардлагатай үед хийж дуусгах хугацаанаас нь өмнө туслалцаа авч чаддаг.	Хэзээ ч үгүй	Заримдаа	Ихэнх тохиолдолд	Байнга

## АМЛАЛТ БА ХИЧЭЭНГҮЙ БАЙДАЛ

**Унш:** Бид “судлахаар мөн тэрчлэн итгэлээр” суралцахад бэлэн байна уу (С ба Г 88:118)? Бид хичээл зүтгэл гарган, хэзээ ч бууж өгөхгүй байж чадах уу?

Биднийг зохистой байвал Ариун Сүнс биднийг хүчирхэгжүүлнэ гэдэгт бид итгэдэг үү? Бид үйлчлэхийн тулд сурч боловсорч байна уу?

**Ярилц:** Бид нэг нэгэндээ амжилт гаргахад нь хэрхэн тусалж чадах вэ?

**Дадлага хий:** Гэртээ 114-р хуудсан дээрх амжилтад хүрэх бэлтгэлээ шалга.

## БИ ИЛҮҮ БИЕ ДААСАН БОЛЖ БАЙНА УУ?

**Цаг:** Зөвхөн энэ хуудсанд 15 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Унш:** Бидний зорилго бол материаллаг болон сүнслэг тал дээрээ бие даах явдал мөн. Боловсролтой, мөн ажилтай болох нь энэ зорилгын зөвхөн нэг хэсэг юм. Итгэлээ хөгжүүлж, сүнслэг байдлаа хүчирхэгжүүлэх нь энэхүү зорилгын өөр нэгэн хэсэг юм.

**Ярилц:** Та *"Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил"* товхимлын зарчмуудаар дадлага хийж, зааж сургаснаар илүү бие даасан болж чадсан уу?


**Дадлага хий:** Өнөөдөр та болон таны гэр бүлийн бие даасан байдал ямар байна вэ? *"Миний бие даах чадвартай болох арга зам"* товхимлынхоо Бие даасан байдлын үнэлгээний хоосон хуудсыг нээ. Алхмуудыг хий. Дараах зүйлсийн талаар гурван минут тунгаан бод:

Та одоо зарлагаа илүү сайн мэддэг болсон уу? Та одоо эдгээр асуултад "ихэвчлэн" эсвэл "байнга" гэж хариулдаг болсон уу? Та бие даахад шаардлагатай орлогынхоо тодорхойлсон мөнгөн дүнд илүү итгэлтэй байна уу? Та бие даахад тань шаардлагатай орлогодоо хүрэхэд илүү ойртож байна уу?

**Унш:** Бидний зорилго бол материаллаг болон сүнслэг тал дээрээ бие даах явдал мөн. Боловсролтой болох нь энэхүү зорилгын зөвхөн нэг хэсэг нь юм. Түүнчлэн бид *"Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил"* товхимлын зарчмуудын дагуу амьдарснаар, мөн сайн ажилд орж чадсанаар бие дааж чадах юм.

Бид дараагийн зургаан цугларалтаар *"Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил"* товхимлын зарчмуудаар үргэлжлүүлэн дадлага хийнэ. Бид үлдсэн зарчмуудыг үзэж, төгсгөл хэсгийн төслийг хийж дуусгана.

Бид *"Ажил хайх нь"* дасгалын номыг ашиглаж, илүү сайн ажилд ороход туслах дадлага хийх болно.





# ТУНГААН БОД

## БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

**Цаг:** Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр судар хуваалцаныг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

---

---

---

---

---

---

---

**Ярилц:** Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

*“Надаас сурагтун, мөн миний үгсийг анхаарагтун; миний Сүнсний номхон дөлгөөн байдалд алхагтун, мөн надаар дамжин амар амгалан чамд байх болно.”*

**СУРГААЛ БА ГЭРЭЭ 19:23**



# АМЛАЛТ ӨГ

## БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

**Цаг:** Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

**Дадлага хий:** Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

---

*Хамтрагчийн нэр*

---

*Холбоо барих мэдээлэл*

**Амлалтаа нэг нэгээр нь хамтрагчдаа чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.**

### МИНИЙ АМЛАЛТУУД

Би гэр бүлийнхэндээ, эсвэл найз нөхдөдөө суралцахад өөрийгөө сүнс-лэгээр хэрхэн бэлтгэх талаар заана.

Би өдөр болгон ангиас гадуур судалж суралцах үндсэн зарчмуудаар дадлага хийнэ.

Хэрэв надад зээл хэрэгтэй бол би ТБС-ийн зээлийн маягтыг бөглөж дуусгана.

Би өнөөдрийн "Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил" товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

---

*Миний гарын үсэг*

---

*Хамтрагчийн гарын үсэг*



## БИ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

**Дадлага хий:** Дараагийн цугларалтын өмнө өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажлыг тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх хүснэгтэд “Тийм” эсвэл “Үгүй” гэж бич.

Суралцахад хэрхэн өөрийгөө сүнслэгээр бэлтгэх талаар гэр бүлийнхэндээ, эсвэл найз нөхдөдөө заасан (Тийм/Үгүй)	Ангиас гадуур судалж суралцах үндсэн зарчмуудаар дадлага хийсэн (Тийм/Үгүй)	Хэрэв надад ТБС-ийн зээл хэрэгтэй бол зээлийн маягтыг бөглөж дууссан (Тийм/Үгүй)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил,” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)

**Унш:** Үүнээс гадна, өөрийн хувийн зардлыг “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлын ар талд тэмдэглэхээ битгий мартаарай.

Дараагийн долоо хоногт “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын нэг сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. (“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын сэдвээр хэрхэн зохицуулагч хийхээ мэдэхгүй байна уу? 17-р хуудсыг болон хавтасны нүүр хуудасны дотор талыг уншина уу).

Хэн нэгнээс хаалтын залбирал хийж өгөхийг хүс.

**Зохицуулагчийн анхааралд:** Дараагийн цугларалтад бүлгийн бүх гишүүнд зориулж “Ажил хайх нь” дасгалын номыг авчир.

Дараагийн цугларалтыг “Ажил хайх нь” дасгалын номны 1-р хуудаснаас эхэл. Сурах материал нь таныг Тэргүүн Зөвлөлийн захидал руу болон “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын 1-р зарчим руу чиглүүлэх ч, та 7-р зарчмыг үргэлжлүүлэн үзэх хэрэгтэй. Бид дараагийн 6 цугларалтаар “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын үлдсэн зарчмуудыг болон төгсгөл хэсгийн төслийг үзэж дуусгана.

12 дахь цугларалтын үеэр “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлын арын хуудсан дээрх бие даасан байдлын үнэлгээг хийж дуусгах ёстойг битгий мартаарай.

### Санал хүсэлт

Санал, сэтгэгдэл, санаа бодол болон туршлагаа [srsfeedback@ldschurch.org](mailto:srsfeedback@ldschurch.org) хаягаар илгээнэ үү.

### Зохицуулагчийн анхааралд:

Бүлгийн гишүүдэд ХҮГ Бизнесийн коллежийн гэрчилгээ авах боломжийг олгохын тулд тэднийг “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын 12 зарчмыг бүгдийг үзэж дуусгасны дараа бүлгийн хийж гүйцэтгэсэн ажлыг [srs.lds.org/report](http://srs.lds.org/report) вэбсайт дээр тайлагнах ёстойг битгий мартаарай.

# Эх сурвалж

## СҮНСЛЭГ БАЙДЛААР БЭЛТГЭЛТЭЙ БАЙХ НЬ

Дараахыг ээлжилж уншина уу.

### ЖЮЛИ Б.БЭК

Хувийн илчлэлт хүлээн авахуйц зохистой байж, улмаар илчлэлт хүлээн авч, хэрэгжүүлэх чадвар бол энэ амьдралд олж авах нэн чухал чадвар юм. Их Эзэний Сүнсийг хүлээн авахад тэнцэхүйц байхын тулд Ариун Сүнсийг эгээрэн хүсэхийн зэрэгцээ зохистой байх хэрэгтэй юм.

Зарлигуудыг дагаж, нүглээ наманчлан, баптисм хүртэхдээ хийсэн гэрээгээ шинэчлэх нь Их Эзэний Сүнс үргэлж бидэнтэй хамт байх адислалыг боломжтой болгодог билээ [С ба Г 20:77-г үзнэ үү]. Ариун сүмд гэрээнүүд хийж, сахих нь. . . сүнслэг хүч чадлыг нэмэгдүүлдэг. . .

Олон хэцүү асуултын хариултыг судар уншсанаар олж авч болно [2 Нифай 32:3-ыг үзнэ үү]. Судруудаас олж авсан гүнзгий ойлголтууд цаг хугацааны явцад өсөн нэмэгддэг билээ. Тиймээс өдөр бүр судар уншихад тодорхой цаг гаргаж байх хэрэгтэй.

Бас өдөр бүр залбирах нь Их Эзэний Сүнстэй байхад зайлшгүй хэрэгтэй юм (3 Нифай 19:24–33-ыг үзнэ үү). Залбирч, судраас судалснаар тусламжийг шаргуу эрж хайдаг хүн асуултуудыг болон төрсөн сэтгэгдэл, санаа бодлоо бичиж тэмдэглэхээр цаас, харандаа бэлтгэж, хажуудаа тавих нь олонтоо байдаг.

Бид зөв зохистой байх үед илчлэлт нь цаг, хором бүрд ирэх болно. . . . Хувиараа илчлэлт хүлээж авах нь итгэл, хувийн шударга зан чанараа өсгөн нэмэгдүүлж, гэр бүлээ бэхжүүлэн, бидний тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийг эрж олохын тулд өдөр бүр юу хийх ёстойгоо ойлгох боломжийг бидэнд олгодог. Хувийн илчлэлт нь хүч чадлыг байнга шинэчлэх эх сурвалж учраас ороо бусгаа, үймээн самуунтай үед ч бид найдвартай тусламж хүлээн авах боломжтой юм.

Биднийг “шударгаар үйлдэхэд, даруухнаар алхахад, зөв шударгаар шүүхэд” хөтөлдөг Сүнсэнд итгэлтэй байх ёстой гэдэг (С ба Г 11:12). Мөн энэ Сүнс нь оюуныг гэгээрүүлж, Сүнсийг баяраар дүүргэж, бидний хийх ёстой бүхнийг мэдэхэд тусална гэж заасан байдаг (С ба Г 11:13–14-ийг үзнэ үү).

Бид хувийн илчлэлтийг хүсэж, хүлээн авахад бэлтгэн, илчлэлт ирэх болно гэдэгт гуйвшгүй итгэлтэй байвал амлагдсан хувийн илчлэлт ирэх болно. (“Тэр өдрүүдэд Би шивэгчингүүд дээр ч Өөрийн Сүнсийг цутгана,” Ensign эсвэл 2010 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 11)

**101-р хуудас руу буцаж оч.**

## ИТГЭЛЭЭР СУРАЛЦАХЫГ ЭРЭЛХИЙЛ

Энэ захиасыг ганцаараа юм уу, бүлгийн өөр нэгэн гишүүнтэй хамт унш. Уншаад, 104-р хуудсан дээрх санаануудыг ашиглан тэмдэглэ. Үүнийг өнөөдөр болон долоо хоногийн дараа, мөн нэг сарын дараа дахин унш. Та тэгж чадвал, мэдэж авсан зүйлээ бараг бүгдийг тогтоосон байна!

### ДЭВИД А.БЭДНАР

*Итгэлээр суралцахыг эрэлхийлэх гэдэг нь юу гэсэн үг вэ?*

. . . Бид Бурханы охид, хөвгүүд учраас сонгох эрхээр адислагдсан билээ. . . . Суралцагчийн хувьд бид үгийг үйлдэж, үйл хэрэг болгогчид байх ёстой. . . . Бид үйлдэж, итгэлээр суралцахыг эрэлхийлдэг хүмүүс үү, эсвэл зааж өгөхийг, өөр дээр үйлдүүлэхийг хүлээж суудаг хүмүүс үү? . . . Бид бүхэн асууж, эрэлхийлж, тогшиход санаа сэтгэлээ бүрэн зориулах ёстой [3 Нифай 14:7-г үзнэ үү].

. . . “Итгэлээр суралцахад идэвхгүй хүлээн авах биш, харин сүнслэг, оюун ухаан, бие бялдрын хүч чармайлт шаардагддаг юм. . . . Итгэлээр суралцах нь “зүрх сэтгэл хийгээд эрмэлзэгч оюуныг” аль алиныг нь шаарддаг билээ (С ба Г 64:34). Итгэлээр суралцах нь Ариун Сүнс Бурханы үгийн хүчийг зүрх сэтгэлд ойртуулан, дотор нь оруулж өгсний үр дүн юм. Итгэлээр суралцахыг багшаас суралцагчид ишилжүүлж өгөх боломжгүй, харин суралцагч мэдлэгийг өөртөө олж авахын тулд итгэлээ хөгжүүлж, үйлдэх ёстой.

Бага залуу Иосеф Смит . . . итгэлээр суралцах гэдэг нь юу болохыг ойлгож байсан юм. . . . Тэр өөрийгөө “итгэлээрээ гүйж,” [Иаков 1:6] мөн үйлдэхэд гарцаагүй бэлдсэн байсан билээ. . . . Иосефийн асуултууд түүнд мэдэх хэрэгтэй зүйлээс гадна хийх хэрэгтэй зүйлс дээр нь мөн адил төвлөрсөн байсныг анзаарна уу.

. . . Түүний залбирал зөвхөн аль сүм зөв болох талаар байгаагүй. Түүний тавьсан асуулт аль сүмд орох нь зүйтэй болох талаар байсан юм. Иосеф ойн цоорхой руу итгэлээр суралцахаар очсон байв. Тэр үйлдэхээр шийдсэн байлаа. . . .

Үнэхээр, мөнх бус амьдралын хамгийн хүнд асуудлуудын нэг бол яах аргагүй итгэлээр суралцахыг эрэлхийлэх явдал юм. . . . Иосеф “Үнэн болон мэргэн ухааныг олж авах хамгийн сайн арга бол номоос олж авах биш харин Бурханд залбирлаар очиж, тэнгэрлэг сургаалуудыг олж авах байдаг билээ” [Сүмийн түүх, 4:425]. . . .

. . . Өөр хүнээс олж авсан хариулт ихэвчлэн мартагддаг болохыг би өөрийн туршилагаас ойлгож авсан юм. . . . Гэхдээ итгэлээ хөгжүүлснээр нээгдсэн, эсвэл олж авсан хариулт нь ихэвчлэн насан туршид бидэнтэй үлддэг байна. . . .

Итгэлээр суралцахыг эрэлхийлэх нь хүн нэг бүрийн өөрийн үүрэг хариуцлага юм. . . . Итгэлээр суралцах нь бидний хувь хүний сүнслэг хөгжилд болон Сүмийн өсөлтөд нэн чухал зүйл билээ. . . . Бид итгэлээр суралцахыг эрэлхийлэхийн тулд хүн нэг бүр зөв шударгын төлөө өлсөж, цангаж, Ариун Сүнсээр дүүргэгдэх болтугай [3 Нифай 12:6-г үзнэ үү]. (“Seek Learning by Faith,” Ensign, 2007 оны 9-р сар, 63–68 эсвэл Лианоно, 2007 оны 9-р сар, 19–24)

**106-р хуудас руу буцаж оч**

## ГЭРТ ХИЙХ ДАСГАЛ: БИ СУРГУУЛЬДАА АМЖИЛТТАЙ СУРАЛЦАХАД БЭЛЭН ҮҮ?

Бид сурч боловсрох, эсвэл дадлага туршлагатай болох явцдаа амжилт гаргахад өөрийгөө бэлдсэн байх хэрэгтэй. Энэ үнэлгээг бие даан хийж дуусга. Та бусад хүнээс өөрийн санал бодлыг нэмэрлэхийг хүсэж болно.

Мэдэгдэл болгоны өмнө 1, 2 эсвэл 3 гэсэн тоо бич. 1 = ажиллах хэрэгтэй 2 = боломжийн 3 = маш сайн

Тэр тал дээр хэрхэн ахиц гаргаж болох талаар санал бодлоо бич.

\_\_\_\_\_ **Өөртөө сэдэл төрүүлэх.** Би хэцүү зүйлсийг өөрөө хийж чадна. Би бусдын шахалт шаардлагагүйгээр өдөр бүр ажилладаг.

Ахиц гаргах арга замууд:

\_\_\_\_\_ **Ажил мэргэжлийн тухай шийдвэр.** Надад тодорхой зорилго байдаг бөгөөд би сургуулиа төгсөж чадна.

Ахиц гаргах арга замууд:

\_\_\_\_\_ **Сурах хүсэл эрмэлзэл.** Би хүсэл эрмэлзэлтэй бөгөөд надад саад бэрхшээлүүд саад болж чадахгүй.

Ахиц гаргах арга замууд:

\_\_\_\_\_ **Төлөвлөлт.** Би амьдралынхаа эзэн. Би өдөр, долоо хоногуудаа төлөвлөдөг бөгөөд Ариун Сүнсээр удирдагддаг.

Ахиц гаргах арга замууд:

\_\_\_\_\_ **Дэмжлэг туслалцаа.** Миний эргэн тойронд намайг дэмжин, чиглүүлж, хайрладаг хүмүүс бий. Байхгүй байсан ч, би дэмжлэг туслалцаа үзүүлэх хүмүүсийг олно.

Сайжрах арга замууд:

\_\_\_\_\_ **Мөнгөний менежмент.** Би мөнгө олж, хадгалж чадна. Би ТБС-ийн зээл зэрэг төлбөрөө цаг тухайд нь төлдөг. Би олсон орлогынхоо хэмжээнд амьдардаг.

Ахиц гаргах арга замууд:

Та энэ дасгалаас юу олж сурсан бэ? Өөрийн санаа бодлыг гэр бүлийнхэнтэйгээ эсвэл найз нөхөдтэйгөө хуваалц.



ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

